ШИХИХУТУГ ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ

# ШИХИХУТУГ

ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ, АРГА ЗҮЙ, МЭДЭЭЛЭЛ 2005/1-2

**Сэтгүүлийн зөвлөл:**

Д.Лүндээжанцан (эрхлэгч)

О.Амархүү (ерөнхий редактор)

Гишүүд:

Ж.Болдбаатар

Г.Совд

Ч.Энхбаатар

Н.Лүндэндорж

Б.Мандахбилэг

Н.Батболд (нарийн бичгийн дарга)

РЕДАКЦИЙН ХАЯГ: Сүхбаатар дүүрэг 6 дугаар хороо,
Их сургуулийн гудамж, Шихихутуг ХЗДС-ийн
хичээлийн I байр.
E-mail: shikhi_setguul@yahoo.com
Утас: 323392
91181909
99150269

Сүхбаатарпринт ХХК-д хэвлэв.

# ГАРЧИГ


## ОНОЛ АРГА ЗҮЙ:

**Ш .Сүхбаатар**
- НЭР ТӨР, АЛДАР ХҮНД ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ — 3

**Г.Цэцгээ**
- МОНГОЛ УЛС ДАХЬ ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭД ХӨРӨНГИЙН БУСАД ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮНДСЭН ШИНЖ — 19

## ТҮҮХ, УЛАМЖЛАЛ, СОЁЛ ИРГЭНШИЛ:

**О.Амархүү**
- МОНГОЛ УЛСАД ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХИЙН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛ — 27

**Н.Лүндэндорж, Б.Баярсайхан**
- МОНГОЛЫН ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ ТҮҮХЭН ХӨГЖИЛ — 47

## ҮЗЭЛ БОДОЛ, ЧӨЛӨӨТ ХУУДАС:

**Л.Баасан**
- БАГШ НАРЫН АЖЛЫН ЦАГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ — 60

**Ц.Цэлмэг**
- НЭР ТӨР, АЛДАР ХҮНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ — 66

**Б.Бат-Ерөөлт**
- ЦААЗААР АВАХ ЯЛЫН ОНОЛ ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ — 72

**Ч.Өнөрбаяр**
- ҮНДСЭН ХУУЛЬТ ЁС БУЮУ ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ТУХАЙД — 80

**А.Энхбат**
- ҮНДСЭН ХУУЛЬ БА ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ — 85

**Г.Ганболд**
- ЗАХИРГААНЫ АЛБАДЛАГА — 89

## ГАДААД ОРНЫ БОЛОН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ:

**Ж.Хулан**
- ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ — 94

## ШИНИХУТУГ СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

- БАГШИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЛДРЫГ ЁСЛОН ТЭМДЭГЛЭВ — 99
- КАНАДАД ЗОЧИЛСОН АЯНЫ БОГЦООС — 111

## ХУУЛЬЧ ЗӨВЛӨЖ БАЙНА

**М.Алтан-Өлзий**
- ХУУЛЬЧ ЗӨВЛӨЖ БАЙНА — 117

## ШИНЭ НОМ

# НЭР ТӨР, АЛДАР ХҮНД ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ

*Докторант Ш.Сүхбаатар*

## Нэг. Монголчуудын нэр төрөө эрхэмлэх үзэл санааны уламжлал, уг сурвалж,онцлог

Нэр төр, алдар хүнд бол хүний заяагдмал амьдралын хамгийн үнэт зүйлсийн оргил юм. Нэр төр, алдар хүндийн тухай ойлголтгүйгээр бие хүний хувь оршихуйг төсөөлөх нь угаас бэрхтэй билээ. Нэр төр, алдар хүндийн тухай ерөнхий ойлголтыг энгийн хэлний хэрэглээнд ойлгохдоо хувь хүний, гэр бүлийн, нийгмийн хийгээд /тодорхой хүрээллийн / улс үндэстний түвшингээр авч үздэг нь түүнийг үнэт зүйлсийн оргил болохыг нь гэрчлэн баталдаг байна. Эцэг эх, төрөл ургийн нэр төрийг хамгаалах нь мах цусны тасархай, элгэн садныхаа өмнө хүлээх үүрэг хариуцлага юм. **"Эцэг үрийн элбэрлийг сахиж, эрхмийн дээд нэрийг нь хугалахгүйг хичээж, хүний зэрэгтэй хүн болж, хөгшид өтгөсөө баярлуулдаг, "алаг махны тасархай, алтан ясны хэлтэрхий"** хэмээн үр удмаа энэрдэг нь эртнээс уламжилж ирсэн монгол зан бөгөөд өөрийн нэр төрийг хамгаалах, үүний тулд нөхрийн нэр төрийг хамгаалах нь монгол араншин юм.

Г.Эрдэнэ-Очирын "Зарим зүйр цэцэн үгийн товч тайлбар"–т "Муу нэрийг хусаад арилахгүй сайн нэрийг хүсээд олохгүй", "Нэр хугархаар яс хугар" гэсэн зүйр цэцэн үгсийн утга санааг тайлбарласан байдлаас үзвэл:

**"Муу нэрийг хусаад арилахгүй сайн нэрийг хүсээд олохгүй".** "Хүний нэр төр бол өөрийн нь үйл ажиллагааны үр дүнд бий болдог зүйл. Хэрэв нэг л муу нэр зүүвэл түүнийг цагаатгах нь тун ч амаргүй учир алдаа дутагдлаас ямагт сэрэмжил. Харин сайн нэр алдрыг хөдөлмөр бүтээл, үйл ажиллагаагаараа олж авахаас биш хүсч мөрөөдсний зоргоор олж чадахгүй гэсэн санааг илэрхийлнэ".

**"Нэр хугархаар яс хугар".**"Хүн нэр төрөө эрхэмлэн сахиж,түүнийг хэзээ ч гутаахгүйн төлөө ажиллаж амьдрах хэрэгтэй.Хэрэв алдаа дутагдал гаргаж нэр хүндээ гутаавал бие эрхтнээсээ салснаас ч дор, нөхөшгүй хохирол болно гэсэн санааг илэрхийлнэ" хэмээн тайлбарлажээ.

Түүнчлэн ардын сургаал үгэнд **"Хүн нэрээ,тогос өдөө"**, **"Нэрэлхээд нэрээ идэхгүй, хариад гэрээ идэхгүй"**, **"Нэрээ эвдэхээр гараа эвд"**, **"Нэрээ барахаар насаа бар"**, **"Нэрээ залуугаас нь хувцсаа шинээс нь"**, **"Сайн хүний нэрийг гурав худаллаж идэх"**, **"Нэр нэгтийн чих нэг"** гэж товч хэрнээ гүн утга агуулгаар илэрхийлж ирсэн нь нэр төрийн үнэ цэнийг монголчууд эртнээс эрхэмлэн дээдлэж ирсний нэг илрэл юм. Эдгээр үгсийн гарал утгыг хөөн үзвээс цөм нэр төрөө сахин хамгаалах гэсэн утгатай байна.

Ийнхүү нэр төрөө эрхэмлэн дээдэлж сахин хамгаалах үзэл бодол бол хүн төрөлхтөний нийтлэг ойлголт бөгөөд олон орны ардын цэцэн үгэнд энэ үзэл санаа тусгалаа олсон байдаг байна.

**"Монголын нууц товчоо"**-ны баримтуудыг түшиглэн үзвээс Чингис хаан Уйгурын Идүүд хаанд Алалтун Бэхи охиноо зарлиглан хатан болгож өгөөд "Хатагтай хүнд гурван эр бий. Анхны эр нь алтан төр, дараахь эр нь **ариун нэр**, түүний дараахь эр нь авсан эр мөн. **Алтан төрийг хатуужиж дагавал ариун нэртэй болно.** Ариун нэрийг бэхэлбэл авсан эр ангид үл одно" (11.207) хэмээн сургамжилсан нь их л гүн утга санааг агуулсан бөлгөө. Чингисийн толгойлсон хаант төрд "иргэдийн амь бие, **нэр төрийн эсрэг үйлдлийг гэмт хэрэг** гэж үзэж байсныг хууль зүйн шинжлэх ухааны доктор И.Дашням "Чингисийн хаант улсын төр,хууль цааз" бүтээлдээ тэмдэглэжээ. Гэвч дээрхи заалт нь Чингисийн хаант засаглал, түүний тэргүүний бие махбодь,удам угсаа,эрх мэдэл,нэр төрийг гэмт халдлагаас хамгаалсан шинжтэй байсан байна.

Монголчуудын нэр төр, алдар хүндээ хамгаалах зан заншил нь нийгмийн бүх гишүүдийн ашиг сонирхлыг илэрхийлж, үеийн үед уламжлагдан, нийгэмд ашиг тустай зан үйлийн горимуудыг бэхжүүлж ирсэн байна. Нэлээд хожуу үед зан заншлын хажуугаар тухайн нийгмийнхээ онцлогийг тусгасан шударга ёс, сайн муугийн тухай төсөөлөл, шашны болон ёс суртахууны хэм хэмжээнүүд бий болж эхэлсэн байна. Ёс суртахуун,шашны зан үйлээр баяжигдсан зан заншил нь аажмаар хэм хэмжээний бүхэл бүтэн цогц болон хувирч иржээ. Тэдгээрийн хамгийн томоохон нь 1640 оны "Монгол-Ойрадын цааз бичиг", 1709-1795 оны хооронд халхын хаад ноёд,төр шашны том зүтгэлтнүүд хорь гаруй удаа хуралдаж хэлэлцэн тогтоосон "Халх журам" хууль юм.

Дээрхи цааз, хуулиудад нэр төр, алдар хүндийг зөвхөн ардын сургаал

номлолоор сургаад зогссонгүй хуульчлан журамлаж байжээ. Тухайлбал 1640 оны **"Монгол-Ойрадын цааз бичиг"**-т:

-Хүн гүтгэсэн тайж тавнанг таван есөөр торгох,

-Ноёдыг гүтгэсэн харцыг долоон есөөр торгох,

-Их ноёныг доромжилбол цаазаар авах,

-Дунд ноёныг доромжилбол нэг ес авах,

-Банди нарыг доромжилбол тав авах тухай заажээ.

Монголын хууль цаазын болон түүхийн нэн чухал баримт бичиг **"Халх журам"**-ын зургадугаар бүлэгт "Хүн гүтгэж" нэр төрд нь халдваас хүлээлгэх хариуцлагын тухай хуульчилж өгсөн байна. "Халх журам" хуулийн нэг зуун арван наймдугаар зүйлд:

-Гүжрээр худал үг айлтгаваас ноёдыг бол тэмээ тэргүүлэн долоо есөөр торго. Үүний таван есийг санд, хоёр есийг гүжирдүүлэгчид өг.

-Тайж тавнангууд бол тэмээ тэргүүлэн таван ес, үүний гурван ес бөхөл болоод есийн хагас дөрвийг санд, нэг бөхөл ес болоод есийн хагас тавыг гүжирдүүлэгчид өг.

-Харц хүн бол тэмээ тэргүүлэн гурван ес, үүний хоёр есийг санд, нэг есийг гүжирдүүлэгчид өгөх" ял хариуцлагын тухай заалт оруулжээ.

Үүнээс үзвэл хүний нэр төр, алдар хүндэд халдсан нөхцөлд тухайн үеийн нийгэмд эзлэх байр сууриар ангилан ялгавартай хариуцлага оногдуулан, гүжигдүүлэгчид учирсан гэм хорын хохирлыг гаргуулан олгох, ихэнх хэсгийг төрийн санд хуримтлуулах хэлбэрээр шийдвэрлэж байжээ.

Нэр төр, алдар хүндээ эрхэмлэж ирсэн монголчуудын энэхүү үзэл санаа нь хөгжин хөгжсөөр хүн төрөлхтөний эрх зүйн үнэт зүйлсийн нэг хэсэг болсон гэж үзэх үндэстэй байна.

## Хоёр. Нэр төр, алдар хүндтэй холбогдсон нэр томъёоны гаргалгаа

Нэр төр хэмээх үнэт зүйлсийн агуулга нь нийгэмд өөрийн гэсэн сөрөг нөлөөлөлтэй цаг ямагт учирч түүгээр дамжсан гомдол мэтгэлцээн, хэрэг маргаан байнга гарч эрх зүйн зохицуулалтыг шаардаж байдаг байна. Позитив онолын түвшингээр авч үзвэл нийтээр дагаж мөрдөгдөх заавал биелэгдэх /албадлагаар/ шинж чанараар илрэх нийгмийн хэм хэмжээний

бүрдэл буюу эрх зүй нь нэр төр, алдар хүндийг нийгмийн зохисгүй нөлөөллөөс хамгаалах хамгийн үр нөлөөтэй зохицуулалт болж ирсэн байна.

Эрх зүйгээр нэр төр, алдар хүндийг хамгаалах нь хүний эрх, эрх чөлөө ардчилсан ёсны үнэт зүйлийн илэрхийлэл бөгөөд хүн бүрийн эрх, эрх чөлөөг дээдэлснээр хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэхийн эрхэм зорилго орших юм. Үүний тулд **нэр төр, алдар хүнд** хэмээх уялдаа бүхий ойлголтуудын ялгааг нэр томъёоны хувьд зааглан авч үзэж хууль зүйн зохицуулалтын нарийн дэг журмыг хангах үүднээс зайлшгүй судлах шаардлага өнөө бидний өмнө тулгарч байна.

Нэр гэдэг үгийн ойролцоо утгыг С.Лувсанбалдан, Сумъяабаатар нарын "Монгол хэлний ойролцоо үгийн товч толь" номонд **алдар-нэр, нэр-алдар, үнэ хүнд, хүнд-нэр** хэмээн тодотгожээ.

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн талаарх онолын тодорхойлолтыг Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга, ОХУ-н иргэний эрх зүйн сурах бичиг, Эрх зүйн мэдлэгийн товч толь, Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар толь, Академич С.Нарангэрэлийн Англи-Монгол-Орос хууль зүйн толь номонд хэрхэн тусгасныг авч үзье.

**1. Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалгад:**

"**Нэр төр, алдар хүнд** гэдэг бол хамт олон, нийгэм төрөөс тухайн хүний хувьд өгсөн үнэлгээ юм. Хувь хүн нь нийгмийн гишүүний хувьд алдар хүндтэй байж нийгэм төрөөс оногдуулсан үүргийг нэр төртэй биелүүлэхийн зэрэгцээ бие хүний тухайд нэр төрөө бодож түүнийг ямагт ариун байлгаж алдраа цуурайтуулах ёс суртахууны хийгээд хууль зүйн ач холбогдол бүхий эрхтэй ч үүрэгтэй ч" гэж тайлбарлажээ. /тайлбар хийсэн Д.Дашцэдэн/

**2.Эрх зүйн мэдлэгийн товч толинд:**

"**Нэр төр**" бол бие хүний талаар нийгмийн зүгээс өгч буй тодорхой үнэлэлт бөгөөд түүний нийгмийн бодит шинж юм. Бие хүний нэр төрийг түүний үйл ажиллагаа, үйл хэрэг үзэл бодлоор тодорхойлно.

**Алдар хүнд** нь бие хүний өөрийн үнэлгээнд илэрхийлэгдэнэ. Энэ үнэлэлт бол бие хүний ухамсар дахь бодит зүйлийн тусгал байдаг ч түүнийг тусгайд нь авч үздэг. Иймд нэр төр алдар хүндийг хооронд нь салгахгүйгээр авч үзэх ёстой. Өнөө үед нийгмийн ёс суртахууны зарчим иргэд, байгууллагын нэр төр, алдар хүндийг хамгаалах явдал нийгэм улс төрийн өндөр ач холбогдолтой юм. Иргэд, байгууллагын нэр төр, алдар хүндийг

гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотлож чадахгүй бол уг мэдээг няцаахыг дээрх иргэн буюу байгууллага шүүхэд шаардах эрхтэй. Хэрэв дурьдсан мэдээ хэвлэлд нийтэлсэн бол зохих няцаалтыг хэвлэлээр дамжин гүйцэтгэнэ. Бусад тохиолдолд няцаалт хийх журмыг шүүх мэдээ тараасан аргыг харгалзан тогтоодог.

**3.Я.Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар"** номонд:

**-Алдар:** 1.Нэрийн хүндэтгэл

2. Олонд тарсан дурьдсан нэр /алдар хүнд/

3. Үнэгүй бөгөөтөл хууран бадруулсан цуурхал

**-Нэр алдар:** 1.Ногдсон үүргээ нэр төртэй биелүүлэх.

**4.Академич С.Нарангэрэлийн "Англи-Монгол-Орос хууль зүйн толь"** номонд:

**Нэр төр**- доброе имя

**Нэр хүнд**-авторитет честь

**Алдар хүнд**-достоинства

**Ёс суртахуун** –мораль

**Зан суртахуун**-нравстенность

**Нэр алдар**- репутация гэж орчуулжээ.

**5.ОХУ-ын Иргэний эрх зүйн сурах бичигт**:

"**Алдар хүнд** гэдэг нь нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, ертөнцийг үзэх үзэл, зан чанарын илэрхийлэлд үндэслэсэн тухайн хүний субъектив, хувь хүний өөрийн үнэлэлт юм.

**Нэр төр** гэдэг нь нийгмээс иргэн хүнд, түүнчлэн хуулийн этгээдэд хандаж буй харилцаан дээр түшиглэсэн хувь хүний /объектив/ дүгнэлт юм" гэжээ.

**Албаны нэр хүнд** гэдэг нь нийгэмд эзлэх байр суурь мөн чанарын үнэлгээн дээр түшиглэсэн хохирсон гэх этгээдийн үзэл санаа юм хэмээн тодорхойлсон байна.

**6.ОХУ-ын хуульч Галина Араповын "Нэр төр сэргээх талаар хууль тогтоомж-Европын шүүхийн хууль цааз"** илтгэлд:

**Нэр төр**-Хүн төрөхөөсөө үхэх хүртлээ өөртөө өгсөн үнэлгээ.Тодруулбал хувь хүн,хамт олон,нийгэм төрөөс иргэн,хуулийн этгээдэд өгч буй зүй ёсны үнэлгээ.

**Алдар хүнд**-Нийгэм олон нийт тухайн хүнийг хэрхэн хүлээж авч

байгаагийн илрэл.Тухайлбал нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн байдал, хөдөлмөрийн үр шимээр хүртэх хүртээл, тухайн цаг үед бүтээсэн хөдөлмөр, бүтээл тэмцлээрээ үнэлэгдэж буй үнэлгээ. Нэр төрийн адил хүн бүрт байдаггүй.

**Нэр хүнд**-Хувь хүнд хандах хандлага нь нэр хүндээр илэрнэ.

**Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд** хэмээх ойлголтуудыг шүүхийн практикт нэг мөр болгох үүднээс Нийслэлийн шүүхээс 1999 онд зөвлөмж гаргажээ. Энэхүү зөвлөмжид:

**Нэр төр** гэдэг нь: "Иргэн болон хуулийн этгээдэд хувь хүн, хамт олон, нийгэм, төрөөс өгч буй ёс зүйн үнэлгээ юм. Энэ утгаараа нэр төр нь иргэн, түүнчилэн хуулийн этгээдэд нийгмийн зүгээс өгч буй үнэлэлт бөгөөд нийгмийн бодит шинжийн нэг хэсэг болж байна" хэмээжээ.

**Алдар хүнд** гэдэг нь: "Иргэн болон хуулийн этгээд нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн байдал, нийгэм ард түмэнд хөдөлмөрийнхөө үр шимээр хүртэх хүртээл, тухайн цаг үед бүтээсэн хөдөлмөр тэмцэл, ертөнцийг үзэх үзлээрээ үнэлэгдэж буй үнэлгээ юм. Алдар хүнд нь нэр төрийн адил бүх хүнд байдаггүй, цөөн хүнд оногдох хөдөлмөр, авьяас, азтай явдлын илрэл бөгөөд нийгэм, олон түмэн төрөөс үнэлэмжийн янз бүрийн аргаар өгдөг, хувь хүн хуулийн этгээдийн хүслээр болдоггүй онцлогтой".

**Ажил хэргийн нэр хүнд** гэдэг нь: "Иргэн ба хуулийн этгээд нь нийгэмд оршин тогтнож, байр суурийа олж, үйл ажиллагаагаа явуулахдаа бүтээлч хөдөлмөрөөрөө тухайн нийгмийг цогцлон хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэрт нь хувь хүн, ард түмэн, нийгэм төрөөс өгч буй үнэлэмж юм. Аливаа хүн, ажил мэргэжлийн дагуу хөдөлмөрлөж, үр шимийг нь хайрлан хамгаалж, түүндээ хүч хөдөлмөр, авьяас, аз хийморь бүх зүйлээ зориулсан нь тухайн хүний нэр төр, алдар хүндийг нь бусдад гарган харуулдагаараа ажил хэргийн нэр хүнд илэрдэг учир нэр төр, алдар хүндэд тулгуурлан сүүлд гарч ирдэг ойлголт ажээ" хэмээн дүгнэсэн байна.

## Гурав. Нэр төр, алдар хүндийг эрх зүйгээр хамгаалахтай холбогдсон олон улсын эх сурвалж

Хүний хамгийн халдашгүй ариун нандин зүйлийн нэг бол нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд билээ. Үүнийг хуульчлан хамгаалах асуудал

дэлхийн улс орнуудад ч харилцан адилгүй арга замыг туулж иржээ. Тэдгээрийг судалж үзэхэд дэлхий дахинд Олон улсын конвенцын хэм хэмжээгээр, дотооддоо Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль, эрх зүйн актуудаар баталгаажуулж ирсэн байна.Тэдгээрээс 1948 оны арванхоёрдугаар сарын 10-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан **"Хүний эрхийн түгээмэл тунхаглал"** нь нэр төр, алдар хүндийг эрх зүйгээр хамгаалахтай холбогдсон олон улсын дагаж мөрддөг гол эх сурвалж болж байна.

**Уг тунхаглалын оршил хэсэгт:**

"Хүн төрөлхтөний гэр бүлийн бүх гишүүнд угаас заясан **нэр төр** болон тэдний тэгш, салшгүй **эрхийг хүлээн зөвшөөрөх** нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөнийг иш үндэс болгон, хүний эрхийг үл тоомсорлох, басамжлах нь зон олны жигшлийг төрүүлсэн балмад үйлдэлд хүргэнэ"...хэмээн онцолоод ...Нэгдсэн Үндэстний Байгууллагад нэгдсэн улс түмэн **хүний үндсэн эрх бие хүний нэр төр, үнэ хүндийг сахин хамгаалах"**-ыг чухалчилж "гишүүн улс орны ард түмэн, тэдгээр улсын эрх мэдэлд байгаа нутаг дэвсгэр дээр оршин суудаг ард олны аль алинаар нь зохих ёсоор зөвшөөрүүлэхийг" Ерөнхий Ассамблейгаас зарлан тунхагласан байна.

**Тунхаглалын тавдугаар зүйлд**: **"Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, хүний ёсноос гадуур эсхүл нэр төрийг нь доромжлон харьцах, шийттэхийг хориглоно"** гэжээ. Тунхаглалын наймдугаар зүйлд: "Үндсэн хууль, бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй " гэж заасан юм. Үүнийг дээрхи тунхаглалын хоёрдугаар зүйлд: **"эрх зүй буюу олон улсын статус ямар ч байлаа гэсэн эрх зүйгээр хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах эрхийн үндэслэл"** болно хэмээн баталгаажуулжээ.

Мөн **тунхаглалын арван хоёрдугаар зүйлд:** "Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нууц, эсхүл **нэр төр, алдар хүндэд нь дураар халдах ёсгүй. Тэгж оролцох, тийнхүү халдах гэвэл хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй"** хэмээн нэр төр, алдар хүндийн эрх зүйн дархлааг тунхагласан байна.

Тунхаглалын хорин хоёрдугаар зүйлд

"...**нэр төрөө хамгаалах**, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй

шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын талын эрх дархаа тухайн орны хүчин чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны нөөц бололцоонд нийцүүлэн эдлэх **эрхтэй**"-г тунхагласан нь хүн нэр төр, алдар хүндээ эрх зүйгээр бүрэн хамгаалуулах түүхэн сурвалж болсон байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний үндсэн эрх бүр хүн бүрт тодорхой үүрэг буй болгодог. Тухайлбал **хүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй бөгөөд хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хүндэтгэн үзэх үүрэгтэй**"-г заaж өгчээ. Энэ бүгдийг хураангуйлан хүний үндсэн үүргийг **Тунхаглалын 29-р зүйлд** "Хүн бүр нийгмийнхээ өмнө тодорхой үүрэг хүлээх бөгөөд гагцхүү нийгэм л бие хүний чөлөөтэй, өв тэгш хөгжлийг хангана. Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг хууль зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон хязгаарлалтад л захирагдана. Эдгээр эрх, эрх чөлөөг НҮБ-ын зорилго зарчимд харшуулан эдлэх ёсгүй" гэж тус тус заасан байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1966 онд баталж Монгол Улс 1974 онд нэгдэн орсон **Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт** нь нэр төрийн иргэний эрх зүйн олон улсын хамгаалалтын гол эх сурвалжын нэг болж байна.

Нэгдсэн Үндэсний байгууллагын дүрэмд тунхагласан зарчмуудын дагуу хүн төрөлхтөний **гэр бүлийн бүх гишүүнд угаас заяасан нэр төр** болон тэдний тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс болохыг харгалзан улс гүрэн бүр хүний эрх, эрх чөлөөг бүх нийтээр хүндэтгэн сахих явдлыг хөхүүлэн дэмжих, хувь хүн бүр бусдын өмнө үүрэг хүлээхийн зэрэгцээ эрхийнхээ төлөө тэмцэх учиртайг уг пактын оршил хэсэгт заажээ.

Энэхүү Пактын аравдугаар зүйлийн нэгд "**Эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр өөртэй нь хүнлэг, бие хүний хувьд угаас заясан нэр төрийг нь хүндэтгэн, хүн ёсоор хандах эрх эдэлнэ**", арван долдугаар зүйлийн нэгд "Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох,...**нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй**",

арван есдүгээр зүйлийн гурвын "а"-д "**Бусдын эрх, алдар хүндийг хүндэтгэх**", хорин дөрөвдүгээр зүйлийн хоёрт "**Хүүхэд төрмөгцөө нэн даруй**

**бүртгүүлж, нэртэй байх ёстой"** гэж тус тус заасан байна.

### Дөрөв.Монгол Улсын Үндсэн хууль дахь нэр төр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалт

Монголчуудын өвөг дээдсийн үнэлэмжийн ёсоор "Түмэн бодисын охь, мянган амьтны манлай болсон" хүнийг дээдэлж, түүний нэр төр,алдар хүндийг хүлээн зөвшөөрч эрхэмлэсэн нь 1992 оны ардчилсан шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалын нэг хэсэг юм.

Улсын анхдугаар их хурлаар 1924 онд батлагдсан Монгол Улсын **Анхдугаар Үндсэн хуульд** нэр төр,алдар хүндтэй холбоотой тухайлсан заалт ороогүй ба "Сонгох сонгогдох эрхийн тухай" дөрөвдүгээр бүлгийн гучинтавдугаар зүйлийн 5-д "Эд хичээх зэргээр нэрийг гутаах явдлыг үйлдэж зарга шүүх газраас ял шийтгэгдийг" аливаа хурлын төлөөлөгчөөр сонгох сонгогдох эрхгүй болохыг зааж өгчээ.

**1940 оны Үндсэн хуулийн** аравдугаар бүлэгт "Ард иргэний үндсэн эрх, үүргүүд"-ийг зааж өгсөн ч нэр төр, алдар хүндтэй холбоотой тухайлсан заалт оруулаагүй байна.

**1960 оны Үндсэн хуулийн** долдугаар бүлэгт "Иргэдийн үндсэн эрх ба түүнийг хангах баталгаа"−г зааж өгсөн ч нэр төр, алдар хүндтэй холбоотой тухайлсан заалтыг мөн л оруулаагүй явж иржээ.

Гэтэл хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах асуудал нь эдүгээгийн хөгжилтэй орнуудад XYII−XYIII зуунд хаант засгийн эсрэг өрнөсөн тэмцэл, хувьсгалын явцад тэр үеийн нийгмийн тэргүүний хүчнээс өнө эртний сэтгэгчдийн дэвшүүлсэн үзэл санааг гүнзгийрүүлэн бэхжүүлснээс үүдэлтэйг хууль зүйн ухааны доктор Б.Чимид Үндсэн хуулийн үзэл баримтлалтай-холбогдуулан бичсэн өгүүлэлдээ онцлон тэмдэглэжээ.

Манай улс 1961 онд НҮБ-ын бүрэн эрхт гишүүний нэг болж уг байгууллагаас баталсан "Хүний эрхийн түгээмэл тунхаглал", 1974 онд албан ёсоор нэгдэн орсон "Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт" зэрэг олон улсын бусад гэрээ бичгүүдийн хүлээн зөвшөөрсөн атлаа өмнөх Үндсэн хуулиуддаа тодорхой тусгаагүй байв. Шинэ Үндсэн хууль 1992 онд л энэ байдлыг өөрчилж хүнийг иргэний нийгмийн харилцааны төв, улс орныхоо хувь заяаны жинхэнэ эзэн болгож, Монгол орныхоо улс төрийн

уур амьсгалыг олон улсын жишигт нийцүүлэхэд томоохон алхам хийснийг судлаачид зүй ёсоор үнэлсэн билээ.

Монгол Улсын **1992 оны Үндсэн хуулийн "Хүний эрх, эрх чөлөө"**-г тунхагласан хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 13-д "Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, **нэр төрийг нь доромжилж болохгүй**" хэмээжээ. Мөн зүйлийн 13 дахь хэсэгт ийнхүү хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хуульчлан бэхжүүлсэн бөгөөд зөвхөн **нэр төр** төдийгүй хүний бие, эд хөрөнгө, хувийн болон гэр бүлийн нууц, захидал харилцаа, орон байрны халдашгүй эрхийг албан тушаалтан болон бусад хүмүүсийн дур зоргоороо аашлан халдах явдлаас хамгаалах асуудлыг Үндсэн хуулийн хэмжээнд баталгаажуулжээ. Энэ нь хүний нэр төрийг эрх зүйгээр хамгаалах үндэсний хэмжээний гол эх сурвалж болоод зогсохгүй "Хүний эрхийн түгээмэл тунхаглал", "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт"-ын үзэл санаатай нийцэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14 дэх хэсэгт "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ...эрхтэй", 17 дахь хэсэгт **"Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална"** хэмээжээ.

Мөн хуулийн 17-р зүйлийн хоёрт Монгол Улсын иргэн **"Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх"** үүрэгтэйг заасан байна.

### Тав.Нэр төр, алдар хүндийн хамгаалалт хуульчлагдсан байдал

Нэр төр,алдар хүндийг хамгаалах асуудал манай улсын Эрүүгийн болон Иргэний хуулиудад хэрхэн тусаж ирснийг өөр хооронд нь харьцуулан жишиж судлах нь чухал ач холбогдолтой юм.

**1926 оны Иргэний хуульд** нэр төр, алдар хүндийг хамгаалах асуудал тусгагдаагүй бөгөөд харин хоёрдугаар бүлгийн 53 дугаар зүйлд "Аливаа төрөгсдийг дансанд тэмдэглүүлэх тухайн хэргийг төрсөн өдрөөс эхлэн хоёр

сарын дотор мэдүүлэн гүйцэтгэвээс зохино" хэмээн заасан нь "Хүүхэд төрмөгцөө нэн даруй бүртгүүлж,нэртэй байх ёстой" гэсэн 1966 оны Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын үзэл санаатай цаг хугацааны өмнө ч гэлээ тохирч байсан байна.

Үүний дараа **1952 онд батлагдсан Иргэний хуульд** тухайлсан заалт ороогүй орхигджээ. Харин **1963 оны Иргэний хуулийн** зургадугаар зүйлд "**Нэр төр, алдар хүндийг хамгаалах**" тухай анх удаагаа тодорхой заалт оржээ. Түүнд "**Иргэн, буюу албан байгууллагын нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол уул мэдээг няцаахыг дээрх иргэн буюу албан байгууллага шүүхэд шаардах эрхтэй.**

**Хэрэв дурьдсан мэдээг хэвлэлд нийтэлсэн бол зохих няцаалтыг хэвлэлээр дамжуулан гүйцэтгэнэ. Бусад тохиолдолд няцаалт хийх журмыг шүүх тогтооно.**" хэмээн заажээ.Энэ нь манай Иргэний хуульд хүний эрхийг хамгаалах талаар орсон дэвшилтэт заалт юм.

**1994 онд батлагдсан Иргэний хуулийн** шинэчилсэн найруулгын долдугаар зүйлд " **Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах**" талаар тодорхой заалт оржээ. Энэ хуулиар өмнөх хуулийн зохицуулалтад байгаагүй "ажил хэргийн нэр хүндийг хамгаалах" асуудал шинээр орж ирсэн байна. Уг зүйл нь гурван хэсгээс бүрджээ. Тухайлбал:

1.Иргэн, хуулийн этгээд өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаагдсан гэж үзвэл уг мэдээг няцаалгах, ийнхүү гутаагдсанаас учирсан гэм хорыг... арилгуулахыг... шаардах эрхтэй.

2.Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол учирсан гэм хорыг арилгах үүрэгтэй.

3.Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаснаас ...учирсан гэм хорын хэмжээ, арилгах аргыг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх тодорхойлно. /Энэ зүйлийг 1999 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулжээ/

Мөн **Иргэний хуулийн 392 дугаар зүйлд "Эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах"** арга замыг дараахь байдлаар хуульчилжээ.

1.Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй

бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан эд хөрөнгийн бус гэм хорыг мөнгөн буюу бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ.

2.Шүүх эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга, хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар зэргийг харгалзан, нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох ба мэдээ тараасан уг хэлбэрээр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан   этгээдэд үүрэг болгоно гэжээ.

2002 онд батлагдсан шинэ Иргэний хуулийн **21 дүгээр зүйлд " Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах"** заалт улам бататгагдан оржээ. Уг зүйлд "Иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг хориглохоор заасан бөгөөд иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр,хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслэлээр няцаах үүрэг хүлээхээр заажээ.

Мөн бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол няцаах үүрэг хүлээхээр хуульчилсан байна.

Түүнчлэн хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй аж.

Нас барсан этгээдийн нэр, нэр төр,алдар хүндийг гутаасан, эсхүл түүний хувийн нууцтай холбоотой мэдээг өвлөгчийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд тараасан бол хариуцлага хүлээх заалт шинээр оржээ.

Монгол Улсын 1921 оноос хойшхи **Эрүүгийн хуулиудад** нэр төр, алдар хүндийн эсрэг гэмт хэргүүдийг хэрхэн оруулсныг судалж үзэхэд:

**"БНМАУ-ын 1926 оны Шүүх цаазын бичиг"**-т "Бусдыг элдвээр доромжлох ба алдар нэрийг нь гутаах" тухай хориннаймдугаар бүлгийг оруулсан байна. Энэ бүлгийн 195 дугаар зүйлд " Бусдын нэр алдрыг гутаах зүйлийг олонд тунхаглан зарласан явдал уулаас үнэн болох буюу улсыг ба ард түмний хэрэгт тустай болбол ял үл хэлэлцэнэ" хэмээгээд 196 дугаар зүйлд нь "Бусдын нэр алдрыг худал хуурмагаар, цуу үг тарааж гутаасныг ялласан тогтоолыг нөгөө этгээдээс хүсэх аваас олонд зарлаж болно" гэж заасан байна.

**1929 оны Шүүх цаазын бичгийн** хориндолдугаар бүлэгт " Бусдыг элдвээр

доромжлох ба **алдар нэрийг нь гутаах**" нь гэмт хэрэг болохыг тодорхойлоод 199 дүгээр зүйлд "Бусдын нэр алдрыг гутаах зүйлийг олон дор түнхаглан зарласан явдал уулаас үнэн болох буюу улсын ба ард түмний хэрэг дор тустай болох аваас ял үл хэлэлцэнэ" хэмээгээд 200 дугаар зүйлд "Бусдын нэр алдрыг худал хуурмагаар, цуу үг тарааж гутаагсдыг ялласан тогтоолыг нөгөө этгээдээс хүсэх аваас олонд зарлаж болмой" хэмээн заасан байна.

**1934 оны Шүүх цаазын бичгийн** зургадугаарт анх удаа "Хүний бие ба эрүүл мэнд, эрх чөлөө, **нэр алдарт харшлах** гэмт хэргүүд" гэсэн бүлэг оруулсны дотор 138 дугаар зүйлд нь "Бусдын нэр алдрыг гутаах аливаа худал хуурмаг мэдээ зориуд цуурхан тараасан бол 300 төгрөг хүртэл торгох ял шийтгэвэл зохино. Тийнхүү бусдын нэр алдрыг гутаах худал хуурмаг мэдээг бичиг хэвлэлд хэвлүүлэн гаргаж тараасан бол 6 сар хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх буюу 300 төгрөг хүртэл торгох ял шийтгэвэл зохино" хэмээн хуульчилжээ.

**1942 оны Эрүүгийн хуулийн** долдугаар бүлэгт "Хүний бие, эрүүл мэнд ба эрх чөлөө хийгээд **нэр алдарт харшлах** гэмт хэргүүд" -ийг хуульчилжээ. Энэ хуулийн 172 дугаар зүйлд ""Бусдын нэр алдрыг гутаах аливаа худал хуурмаг мэдээ зориуд цуурхан тараасан байвал 500 төгрөг хүртэл торгох ял шийтгэнэ" гэж өмнөх хуулийн торгуулийн хэмжээг 200 төгрөгөөр ихэсгэн тогтоожээ.

Тийнхүү бусдын нэр алдрыг гутаах ямар нэгэн худал хуурмаг мэдээг бичиг хэвлэлд хэвлүүлэн гаргаж тараасан байвал нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажлыг хийлгэх буюу 1000 төгрөг хүртэл торгож шийтгэвэл зохино" хэмээн мөн л хариуцлагын санкцийг чангаруулсан байна.

**1961 оны Эрүүгийн хуулийн** гуравдугаар бүлэгт "Иргэдийн амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө ба **нэр алдарт харшлах** гэмт хэргүүд" –ийг оруулжээ. Мөн хуулийн 92 дугаар зүйлд ""Бусдын нэр алдрыг гутаахаар худал хуурмаг мэдээ зориуд тараавал нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх эсхүл олон нийтийн арга хэмжээ авахуулна.

Худал гүтгэлэг хэвлэлд нийтлэх буюу бусад аргаар тараасан, эсхүл гүтгэлгийн хэрэгт урьд шийтгэгдсэн этгээд үйлдвэл хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэнэ.

Бусдыг хүнд гэмт хэрэгт холбогдуулж гүтгэвэл 4 жил хүртэл хугацаагаар

хорьж шийтгэнэ" хэмээн хариуцлагын санкцийг мөн л чангаруулж тогтоосон байна.

**1986 оны Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйлд** "Бусдын нэр төр,алдар хүндийг гутаасан илт худал гүжирдлэг тараасан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу мөн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх,арван мянгаас тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Гүтгэлгийг хэвлэлд нийтлэх буюу бусад аргаар олшруулан тараасан, эсхүл нэргүй захидлаар ирүүлсэн буюу гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл 25000-гаас 150000 хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэсэн бол 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэжээ.

**2OO2 оны Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлд** "Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-иос 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-3 сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Гүтгэлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд тараасан, эсхүл доромжлох гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 3-6 сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэснээс хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 151-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 2-5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан байна.

Эрүүгийн шинэ хуульд гүтгэх гэмт хэргийн тухай заахдаа гүтгэлгийг зөвхөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан тохиолдолд гэмт хэрэгт тооцох, бас хариуцлагыг нь өмнөхөөс үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэхээр тогтоожээ.

Гүтгэлэг, доромжлол нэр төртэй холбоотой манай хуулийн заалтуудад мэдээллийг нягтлах эрхийг баталгаажуулаагүй байна. Мөн нэр төрд нь халдсан мэдээллийг худал, хортой, буруу болохыг нотлох тухай тодорхой заалт алга байна.

Нэр төр сэргээлгэхээр гаргасан нэхэмжлэлийн хариуд сэтгүүлч болон хэвлэл, мэдээллийн байгууллага тухайн хэргийг үнэн бодитойгоор шударга ёс, олон нийтийн эрх ашгийн төлөө сурвалжилсан, шударга тайлбар өгсөн зэрэг үндэслэлээр өөрийгөө өмгөөлөхийг зөвшөөрөх нь олон улсын жишигт бүрэн нийцэж байгаа юм.

Ардчилсан нийгэмд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө баталгаажсан байх ёстой ч хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хамгаалах үүднээс шаардлагатай хязгаарлалтуудыг нарийвчлан тусгаж өгөх нь чухлыг 2000 оны 2 дугаар сарын 29-нөөс 3 дугаар сарын 1-ний өдрүүдэд Лондон хотноо зохиогдсон "Гүтгэлгийн эсрэг хууль"-ийн талаархи семинарын гол зарчим байсан байна. Гүтгэлгийн эсрэг хуулийн гол зорилго нь нэр хүндээ бууруулуулж хохирсон иргэн нэхэмжлэл гаргах эрхтэй ч албан хаагчийн буруутай үйл ажиллагааг зүй ёсоор шүүмжилсэн, хээл хахуулийг ил гаргасан тохиолдолд гүтгэлгийн эсрэг хуулийг хэрэглэхийг хориглосон байна.

Түүнчлэн зарчмын хувьд эрүүгийн хуулиас гүтгэлгийн эсрэг заалтыг хасаж Иргэний хуулиар зохицуулах хэрэгтэйг гүтгэлгийн эсрэг заалтууд эрүүгийн хуулиндаа хэрэглэж байгаа орнуудад зориуд анхааруулсан байх юм.

Иймд манай Эрүүгийн хуульд цаашид дараах нөхцлүүдийг харгалзан өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага байна. Үүнд:

1.Нэг талын нэр төр гүтгэгдсэн гэх гомдол шаардлага нь эргэлзээтэй, нотлох баримт бүрэн бус бол хэнийг ч гүтгэлэг, доромжлолын эсрэг хуулиар ял шийтгэж болохгүй.

2.Няцааж байгаа зүйл нь худалташаа болох нь нотлогдоогүй, санаатай хуурамчаар үйлдсэн буюу худал ташаа болохыг мэдсээр атал бодлогогүй мэдээлсэн эсвэл нөгөө талд зориуд хор уршиг учруулахаар тусгай зорилготой гүтгэж доромжилсон нь нотлогдоогүй бол гэмт хэрэгт тооцохгүй.

3.Гүтгэгдсэн гэх тал өндөр байр суурьтай өөрөөр хэлбэл төр засгийн албан тушаалтан байсан ч тэдний өмнөөс гүтгэлгийн эсрэг хэрэг үүсгүүлэхээр хэн нэгэн санаачлага гаргасан бол түүнийг хүлээж авахгүй байх.

4.Хорих, сэтгүүл зүйн эрхийг нь хасах, хэт их торгууль тавих буюу Эрүүгийн хатуу ял шийтгэл хариуцлагыг гүтгэлгийн гэмт хэргийн субъектэд оногдуулахгүй байх.

## Ашигласан ном:


1. И.Дашним "Чингисийн хаант улсын төр,хууль цааз" УБ 1997

2.Ч.Нямсүрэн "Эрх зүй,төрийн ерөнхий онолын зарим асуудал" УБ 1995 он

3.С.Лувсанбалдан, Сумъяабаатар нарын "Монгол хэлний ойролцоо үгийн товч толь" УБ 1966

4.Эрүүгийн хуулийг тайлбарласан УДШ-ийн Бүгд хурлын тогтоолуудын эмхэтгэл. УБ 1995

5.Г.Эрдэнэ-Очир "Зарим зүйр цэцэн үгийн товч тайлбар"УБ 1983

6.Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүд /1924-2002/, УБ 1998

7.Д.Алымбизар Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт УБ 1998

8.Иргэний хуулиуд /1926,1952,1963,1994,2002/, нэмэлт, өөрчлөлтүүд 2-р боть.УБ 2002

# МОНГОЛ УЛС ДАХЬ ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭД ХӨРӨНГИЙН БУСАД ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮНДСЭН ШИНЖ

*Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн албаны бүртгэлийн хэлтсийн дарга Г.Цэцээ*

1.Монгол Улс дахь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
2.Монгол Улс дахь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн эрх зүйн зохицуулалтын онцлог

## 1.Монгол Улс дахь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл

Монгол Улсын шинэ Үндсэн хууль 1992 онд батлагдаж, өмчийн олон хэлбэрийг чөлөөтэй тэгш хөгжүүлэх баталгааг бий болгосон нь манай улсад эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн харилцаа дэлхий нийтийн нийтлэг чиг хандлагын дагуу хөгжих эрх зүйн үндэс суурь болсон билээ.

"Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай" Монгол улсын анхны хууль 1997 оны 1 дүгээр сарын 9-д батлагдав. Энэ хууль гарах цаг үед банкууд иргэд, хуулийн этгээдүүдэд зээл олгодог, олгосон зээл нь эргэн төлөгдөх ямарч баталгаа байхгүй байсан. Иргэд, хуулийн этгээд өөрийн өмчийн эрхийг баталгаажуулах, түүнийг төрөөс хамгаалах тодорхой систем байхгүй байлаа. Нэг эд хөрөнгийг хэд хэдэн банкинд давхар барьцаалж, зэрэг зээл авдаг, авсан зээл нь барьцааны эд зүйлийн бодит үнээс хэд дахин их байх явдал гарч байснаас олгосон зээлийн барьцаа баталгаагүй байхаас гадна зээлийн барьцааны эд зүйлийг хэт өндөр үнэлэн авсан, эсвэл чанар байдлаа амархан алддаг зүйл авснаас зах зээлд борлогдохгүй, борлогдсон ч маш бага үнээр зарагддаг байдлаас болж банкны төлөгдөх найдваргүй зээлийн хэмжээ ихсэж, энэ нь улс орны эдийн засагт асар их сөрөг нөлөө үзүүлж байв. Нөгөөтэйгүүр шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа явагдаж байх хооронд зээлдэгчид зээлийнхээ барьцаа хөрөнгийг

нуух, худалдах, бусад шилжүүлэх зэргээр банкны төлбөрөөс зайлсхийж чаддаг байв.

Энэ бүхнээс үүдэн Монгол Улсын эдийн засгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд эд хөрөнгө барьцаалан зээл олгох асуудлыг нарийвчлан зохицуулах, зах зээл өндөр хөгжсөн орнуудын жишгээр эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийг улсын бүртгэлд бүртгэн баталгаажуулах шаардлага зүй ёсоор тавигдсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 42 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газрыг байгуулжээ. Агентлаг байгуулагдаж, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагаа эхлэх бэлтгэл ажил хангагдсаны үндсэн дээр 1997 оны 7 дугаар сарын 9-нд анхны бүртгэл хийгдсэн түүхтэй.

1997 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр батлагдсан Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хууль нь 4 бүлэг, 24 зүйлтэй, хуулийн зорилт нь 1/ Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа төрийн болон орон нутгийн зориулалттай өмчид хамаарахаас бусад үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэх, 2/ үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлох, 3/ үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг баталгаажуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэхүү хууль нь Монгол улсад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн харилцааг харилцааг бодитойгоор хэрэгжүүлж, энэ үйл ажиллагааг зөв чиг хандлагатайгаар хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Энэ хуулинд Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа төрийн болон орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарахаас бусад газар, газраас салгамагц зориулалт, эдийн засгийн агуулгаа алдах барилга байгууламж, тарьц суулгац, олон наст ургамал зэрэг бодит болон хийсвэр аргаар хэмжиж болохуйц тодорхой хил хязгаартай эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэнэ гэж заасан байсан бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэх эд хөрөнгийн шинж чанарыг үүгээр тодорхойлсон. Нэг талаас газар бүхэлдээ төрийн өмчид байсан, үл хөдлөх эд хөрөнгийн харилцаа сонгодог утгаараа хөгжөөгүй, нөгөө талаас иргэд, хуулийн этгээдийн эд хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах хэрэгцээ шаардлагын үүднээс дан газар дээрхи объектыг бүртгэж байсан бөгөөд жижиг ТҮЦ, павильон, хувийн жижиг сууц зэрэг харьцангуй бодит үнэ өртөг багатай, удаан оршин тогтнох шинж чанаргүй, өөрөөр хэлбэл жинхэнэ утгаараа үл хөдлөх эд хөрөнгөд хамаарахааргүй эд хөрөнгийг үл хөдлөх эд хөрөнгөд тооцож бүртгэж байсан нь

одоо зарим нэгэн бэрхшээл учруулахад хүргэж байна. Хууль хэрэгжсэн цаг хугацаанд төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө үндсэндээ бүртгэгдээгүй бөгөөд үүнийг бүртгүүлэх бодит хэрэгцээ шаардлага гараагүй гэж ойлгож болох боловч энэ нь цаашид зах зээлийн нийгмийн хөгжлийн шаардлагаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдэх шаардлагатай болно гэж үзэж байна.

Энэ хуулиар үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдээлэл нь хуулиар хориглосноос бусад нөхцөлд нээлттэй байх зарчмыг тодорхойлсон боловч бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа шүүх, цагдаа зэрэг төрийн эрх бүхий байгууллагаас бусад этгээд нь заавал “мэдүүлэг” гаргаж бүртгэлийн байгууллагад хандахаар зохион байгуулсан, “мэдүүлэг”-ийг зөвхөн өмчлөгч буюу түүний хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч гаргаж байхаар зохицуулснаас өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн мэдээлэл авах боломж үнэн хэрэгтээ хаалттай байсан байна.

Мөн хуулинд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд тусгах зүйлүүд /хуулийн 12 дугаар зүйл/ болон гэрчилгээ олгох /хуулийн 13 дугаар зүйл/ тухай хуульчилж өгсөн байсан бөгөөд түүнд тухайн үл хөдлөх эд хөрөнгийн үнийг тусгахаар заагаагүй боловч бүртгэлийн мэдүүлэгт тухайн үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ, үнэлгээг тогтоосон эрх бүхий байгууллагын баримт бичгийг хавсаргана /хуулийн 9 дүгээр зүйлийн 5-ын 2/, бүртгэлийн байгууллага нь кадастрын хэмжилт, үнэлгээнд хяналт тавих үүрэг бүхий албатай байж болно /хуулийн 7 дугаар зүйлийн 4/-гэж тус тус заасан байлаа. Энэ нь хуучнаар Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар нь үнэлгээнд хяналт тавих үүрэг бүхий албатай байж, бүртгүүлж буй хөрөнгийн үнэлгээнд хяналт тавьдаг, энэ үнийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон гэрчилгээнд тусгаж өгдөг зохицуулалт болсон байв. Тэр нь зөвхөн улсын бүртгэлийн хураамжийн хувь хэмжээг тогтооход хэрэглэгдэхээс өөр бодитой ач холбогдолгүй байсан гэхэд болно. Бүртгэлийн үйл ажиллагаа эхэлсэн эхний жилүүдэд иргэд, аж ахуйн нэгжүүд барьцаанд тавих үүднээс үл хөдлөх эд хөрөнгөө өндөр үнэлүүлэх сонирхолтой байсан бол одоо банк, санхүүгийн байгууллагууд барьцаа хөрөнгийн үнийг гэрээгээр тохиролцож, өөрсдөө тогтоодог болов. Ингэснээр тухайн хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд тусгасан үнээс тооцож үл хөдлөх эд хөрөнгийн татвар оногдуулдаг болов. Харин үүнтэй холбоотойгоор үнийг бууруулж бүртгүүлэх сонирхол ажиглагдаж байна.

Ийнхүү эрх зүйн зохицуулалтын хувьд зарим нэгэн шийдвэрлэвэл зохих

асуудлууд байсан боловч үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагаа харьцангуй богино хугацаанд зөв чиг хандлагатай хөгжиж, өнөөдөр нийгмийн зайлшгүй хэрэгцээ болсон байна.

Одоогоор манайд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн зорилго нь чухам юу болохыг тодорхойлсон баримт бичиг, эрх зүйн акт байхгүй байгаа нь энэ харилцааг зохицуулсан хуулийн /өөрөөр хэлбэл, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулийн, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн/ зорилт нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны зорилго, зорилт мэтээр ойлгогдоход хүрч байгаа юм.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн актууд, тэдгээрийг хэрэгжүүлж буй арга механизм, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны нийгэмд үзүүлж буй үйлчлэл зэргээс үндэслэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн зорилго нь Монгол улсын эдийн засгийн харилцааны эрх зүйн орчинг боловсронгуй болгож, түүнийг зөв гольдролд оруулан хөгжүүлэх, нэн ялангуяа банк, санхүүгийн системийн шинэчлэлт, тогтвортой байдалд түлхэц үзүүлэх, үүнтэй уялдан газрыг иргэний болон эдийн засгийн харилцаанд оруулах, эд хөрөнгө өмчлөгч иргэн, хуулийн этгээд түүгээрээ иргэний эрх зүйн харилцаанд оролцоход нь эрх зүйн хамгаалалт, баталгаажуулалттай болгон тэдний эрх ашгийг хамгаалахад оршиж байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны гол агуулга нь өмчлөгчийн өмчлөх эрхийг төрөөс баталгаажуулж, эд хөрөнгийн эрхийн харилцаанд оролцогчдыг болон нийгмийг мэдээллээр хангах, үүний үндсэн дээр тэднийг эдийн засгийн эрсдлээс хамгаалж, арилжааны найдвартай байдлыг хангах явдал байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

## 2.Монгол Улс дахь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн эрх зүйн зохицуулалтын онцлог

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай 1997 оны хуулийг шинэчлэн найруулж, "Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль"-ийг 2003 оны 6 дугаар сарын 19-ний өдөр батласан байна. Энэ хуулиар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг өмнөхөөс улам илүү нарийвчлан зохицуулж өглөө.

УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан «Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр»-ийн 3-ын 17-д «Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг баталгаажуулах үүднээс түүний бүртгэлийн эрх зүйн зохицуулалтыг зах зээлийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно» гэж заасан. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эд хөрөнгийн харилцааг зохицуулах суурь хууль болох Иргэний хуулийг шинэчлэн найруулж 2002 оны 1 дүгээр сард батласан бөгөөд түүнээс салбарласан гол гол хуулиудыг түүнд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай болсны нэг нь Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль юм. Иргэний хуульд баталгаат ипотек, ипотек өмчлөгчид шилжих, ипотек болон шаардлага шилжих, улсын бүртгэлд бичигдсэн тэмдэглэл үнэн зөв байх, улсын бүртгэлд бүртгэлтэй эрхийн дараалал зэрэг шинээр нэмэгдсэн, шинэчлэн найруулагдсан зохицуулалтууд тусгагдсан байна.

Түүнчлэн 2002 онд батлагдсан Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн холбогдох заалтууд болон газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгэхтэй холбоотой эдийн засгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн шинэ шинэ зохицуулалт хуульд нэмж тусгагдсан нь шинэтгэлийн гол агуулга болжээ.

Энэ хуулиар улсын бүртгэлийн үйл ажиллагааны зохицуулалтад зарим нэг зарчмын өөрчлөлт орж, эрхийг улсын бүртгэлд бүртгэх талаар тусгайлсан зохицуулалтууд нэмэгдсэнээрээ өмнөх хуулиас дэвшилттэй болсон билээ. 1997 оны хуулийг 2003 оны хуультай харьцуулан үзэхэд дараахь шинэчлэл, өөрчлөлт харагдаж байна. Үүнд:

Шинэ хуулиар зохицуулах харилцааг Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд хуульд бүртгэхээр заасан эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийг улсын бүртгэлд бүртгэж баталгаажуулахтай холбогдон үүссэн харилцаа байна гэж тодорхойлсон. Үүнээс үзэхэд өгүүлэн буй бүртгэл нь эд хөрөнгөтэй холбоотой эрхийн улсын бүртгэл байна гэдэг нь тодорхой бөгөөд эд хөрөнгөтэй холбоотой ямар ямар эрхийг улсын бүртгэлд бүртгэхийг тодорхойлж, ямар эрхийг хэрхэн яаж бүртгэх талаар тодруулж заасан байна.

Төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнийг төрийн байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхгүй, харин төрийн өөрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхтэй холбоотой, хуульд эрхийн улсын бүртгэлд бүртгэхээр заасан бусад эрхийг төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын албан ёсны тодорхойлолтыг

үндэслэн эрхийн улсын бүртгэлд бүртгэхээр зохицуулсан.

Хууль буюу гэрээнд тусгайлан заасан бол хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрхийг бүртгэхээр заасан.

Мөн хуульд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн зарчмыг:

- бүртгэлийн талаарх мэдээлэл нээлттэй байх,
- бүртгэл үнэн зөв байх,
- бүртгэл нэгдсэн байх - гэж тодорхойлсон бөгөөд эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэх талаар мөн тодорхой зохицуулалтууд оржээ.

Түүнчлэн эрхийн улсын бүртгэлийн талаар мэдээлэл авсан этгээд уг мэдээллийг ашиглан тухайн эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулсан бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээхээр заасан нь мэдээлэл нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой юм.

Эрхийн улсын бүртгэгчээр ямар шаардлага хангасан иргэнийг ажиллуулах болон түүний эрх үүргийг тодорхой болгожээ.

Өмнө мөрдөж байсан Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар мэдүүлэг гаргагч үнэн зөв мэдүүлэг гаргах үүрэг хүлээдэггүй, харин бүртгэлийн байгууллага нь мэдүүлгийг хянах үүрэгтэй байхаар зааснаас мэдүүлэг гаргагч худал мэдүүлэг гаргаснаас үүсэх үр дагаврыг бүртгэлийн байгууллага хариуцахад хүргэйг өөрчилж, мэдүүлэг гаргагч нь мэдүүлгээ үнэн зөв гаргах үүрэгтэй байх, хэрэв буруу мэдүүлэг гаргасан бол үүний улмаас бусдад учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй байхаар зохицуулсан байна.

Мөн хуульд мэдүүлэг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг тодорхойлж, эдгээрээс бусад үндэслэлээр мэдүүлэг хүлээн авахаас татгалзахыг хориглосон байна.

Эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл, урьдчилсан тэмдэглэл хийх үндэслэлүүд, тэмдэглэл хийсний үр дагавар, тэмдэглэлийг өөрчлөх үндэслэл зэргийг илүү тодорхой болгож өгсөн.

Хуульд дундаа хэсгээр өмчлөх үл хөдлөх хөрөнгийн тодорхой хэсгийг өмчлөх эрх өөр этгээдэд шилжсэнийг бүртгэх талаар шинэ заалт нэмэгдсэн бөгөөд үүнд дундаа хэсгээр өмчлөх бусад этгээдийн давуу эрхийг хангах талаар тодорхой заалт орсон.

Түүнчлэн эрхийн улсын бүртгэлд бүртгэх асуудлыг шийдвэрлэх хугацааг нарийвчлан тодорхойлж өгсөн нь үйлчилгээний чанар, шуурхай байдлыг хангахад

чухал ач холбогдолтой болжээ.

Бүртгэлийн байгууллага тухайн улиралд банкны зээлд барьцаалагдсан үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг Монгол банкинд, шинээр бүртгэгдсэн болон өмчлөгч нь өөрчлөгдсөн үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг Үндэсний татварын газарт улирал бүрийн сүүлчийн сарын 25-30-ны хооронд гаргаж өгөхөөр хуульчилсан байна.

Хуулийг хэрэгжүүлэх явцад цаашид үүсэж болох зарим нэгэн асуудлуудын талаар авч үзье.

Шинэ хуульд өмчлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөгч нь хуулийн этгээд бол түүний нэр, оршин байгаа газар, тухайн үл хөдлөх хөрөнгийн хэмжээ, байршлын талаархи мэдээллийг мэдээлэл авахыг хүссэн иргэн, хуулийн этгээдийн бичгээр гаргасан хүсэлт, иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн төлөөлөгчид бичгээр олгосон итгэмжлэлийг үндэслэн зохих төлбөртэйгээр гаргаж өгөх бөгөөд мэдээлэл авсан этгээдийн хүсэлтээр мэдээлэлд дурдсан зүйлд холбогдох хэсгийг зохих төлбөртэйгээр хуулбарлан өгч болно гэж заасан байгаа нь эрхийн улсын бүртгэлийн талаархи мэдээлэл нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэх чухал алхам болсон боловч энэ нь зарим нэг учир шалтгааны улмаас жинхэнэ утгаараа хэрэгжиж, эд хөрөнгийн эрхийн харилцаанд оролцогчид болон зах зээл дээр сонирхогч этгээдэд хэр ач холбогдолтой мэдээлэл байх нь одоогоор эргэлзээтэй гэж үзэхээр байна. Юу гэвэл манайд үл хөдлөх хөрөнгийн хаяг, индексжилт туйлын хангалтгүй, зарим газар бараг байхгүйтэй адил. Үүний улмаас хэн нэгэн этгээд өөрийн сонирхсон үл хөдлөх хөрөнгийнхөө хаягийг хараад түүний дагуу эрхийн улсын бүртгэлээс мэдээлэл авах боломж мөн байхгүйтэй адил. Нөгөө талаас эрхийн улсын бүртгэлтэй холбоотой ямар нэгэн үйлчилгээ хийлгэхийг хүссэн этгээд бүртгэлийн байгууллагад мэдүүлэг гаргах бөгөөд уг мэдүүлгийг зөвхөн өмчлөгч нь гаргана гэсэн ойлголт бий.

Эрхийн улсын бүртгэл, түүний үндсэн дээр олгож буй гэрчилгээ нь тухайн эрхийн баталгаа болж байгаа гэсэн үүднээс бүртгэлийн байгууллага нь шууд эрх олгогч мэтээр зарим субъектууд ойлгож, аливаа эрсдлийг бүртгэлийн байгууллагад хариуцуулах гэсэн сонирхол бий болж магадгүй байдал ажиглагдаж байгаа юм. Тухайлбал, барьцаа хөрөнгийн бүртгэл хуульд заасан үндэслэлээр /Өөрөөр хэлбэл, бүртгэлийн байгууллагад хамаарахгүй үндэслэлээр/ хүчингүй болох тохиолдолд барьцаалагч нь бүртгэл хийж, гэрчилгээ олгосон, барьцааны

эрхийг бүртгэж баталгаажуулсан гэсэн үндэслэлээр эрсдлээ бүртгэлийн байгууллагад хариуцуулахыг оролдох, нотариатаар гэрчлэгдсэн гэрээ хэлцлийн үнэн зөвийг бүртгэлийн байгууллага хянах үүрэгтэй мэтээр ойлгож, түүний үр дагаврыг хариуцуулах зэрэг асуудлууд гарч байна. Үүнээс үүдэн бүртгэлийн байгууллага энэ эрсдлээс өөрийгөө хамгаалах зорилгоор өөрийн үндсэн чиг үүрэгт хамаарахгүй асуудалд хэт анхаарах /өөрөөр хэлбэл нотариатын гэрчилсэн гэрээ хэлцлийн үнэн зөвийг давхар хянах, эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэр үндэслэлтэй эсэхийг хянах гэх мэт/ хандлага гарч болзошгүй байна. Энэ нь нэг талаас бусдын хариуцлагыг бүртгэлийн байгууллага үүрэх, нөгөө талаас үйл ажиллагааны давхардал, хэт төвлөрлийг бий болгох, нэлээд их чирэгдэл, хүнд суртлыг үүсгэж болох талтай.

Түүнчлэн Иргэний хуульд эрхийн улсын бүртгэлд бүртгэлтэй эрхийн дараалын талаар тодорхой зохицуулалт байгаа, Эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд ипотекийг бүртгүүлсэн дараалал гэсэн ойлголт байгаа. Энэ зохицуулалт хуучин Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хуульд ч мөн байсан. Гэвч практик дээр нэг талаас барьцаалагч буюу үүрэг гүйцэтгүүлэгч тал нь ихэнхдээ эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг барьцааны баталгаа болгож авдаг, нөгөө талаас үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой аливаа гэрээ хэлцлийг эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэл болгож хийдэг, хуулинд нотариатаар гэрчлүүлэхээр заасан гэрээ хэлцлийг нотариат гэрчлэхдээ мөн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэл болгодог зэргээс шалтгаалан үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхтэй холбоотой 1-ээс илүү эрх бүртгэгдэх боломж хязгаарлагдмал байна гэж үзэх үндэстэй юм.

Ийнхүү хуулийг хэрэгжүүлэх явцад гарч болох зарим нэгэн асуудлуудыг шийдвэрлэх нь дан ганц эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллагын төдийгүй төрийн бодлого, судлаачид, мэргэжлийн байгууллагууд болон, төрийн эрх бүхий байгууллагуудын ч анхаарлыг татах асуудал мөн болно.

# МОНГОЛ УЛСАД ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХИЙН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛ

*Хууль зүйн шинжлэх ухааны*
*доктор, профессор О. Амархүү.*

## I. Уламжлал, түүхэн тойм

Газар өмчлөх эрхийн асуудал бол газрын харилцаа үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох тулгуур цэг мөн. Өөрөөр хэлбэл газрыг эзэмших, ашиглах эрх зүйн харилцаа өмчлөх эрхээс шууд үүсмэл байдаг.

Газар өмчлөлийн асуудал аливаа улс оронд дан ганц эдийн засгийн утгаар биш, улс төрийн утгаараа илүү хурц асуудал болсоор ирсэн түүхэн томоохон үзэгдэл юм.

Монгол орны хувьд энэ асуудал нүүдлийн соёл иргэншлээс улбаалсан ихээхэн онцлогтой, судлаач, эрдэмтдийн бүтээл туурвилд ч өнөө хэр нэгэн шийдэлд хүрч чадаагүй нь тод мэдрэгдэж, маргаантай асуудал байсаар байна.

Монголд газар хэний өмчид байв гэдэг түүхэн асуудлыг судлан үзэхэд энэ талаар эрдэмтэд, судлаачид хоёр өөр үзэл баримтлалаар санал бодлоо илэрхийлжээ. Тухайлбал, Монголд 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын ялалт хүртэлх түүхэн үеийн турш газар нь **засаг, засаг бус ноёдын хувийн өмч байсан, дараа нь улсын өмч болсон** гэсэн нэг үзэл баримтлал, нөгөө нь Монголд газар хэзээ ч, ямар ч анги, бүлгийн хувийн өмч байсангүй, **гагцхүү ард нийтийн хөрөнгө, улсын өмч байсаар** ирсэн гэсэн үзэл баримтлал юм.

Газар хувийн өмч байсан гэсэн үзэл баримтлалыг түүхийн тулгар ном зохиолууд хийгээд зарим судлаач эрдэмтдийн бичиж тэмдэглэснийг сөхөн үзвэл:

БНМАУ-ын түүхийн гурав дахь удаагийн хэвлэлд "Нүүдлийн эрчимгүй мал аж ахуйн өөрмөц хэлбэр нь нүүдлэх явдлыг зохицуулах, ерөөс нүүж буух нутгийг эрхлэн захирах зэргээр феодалаас газрыг өмчлөх өвөрмөц хэлбэр бий

болгож билээ" гээд "Монголын бүх газрыг хувьд өмчлөх эрхийг устгасан шийдвэрийг Ардын түр засгийн газар 1921 оны тандугаар сарын 21-нд гаргажээ" гэж бичжээ.[1]

МАХН-ын түүх номд: "Феодалууд бэлчээр нутгийг өмчилж байв", "Хувьсгалын анхны жилүүдэд...феодалын газар бэлчээрийн өмчийг устгаж", "Анхдугаар Үндсэн хуульд газар, түүний бүх баялагийг улсын өмч болгохоор заав" гэж тэмдэглэжээ.[2]

"Монгол ардын хувьсгалын түүх" гэдэг номонд "Манжийн ноёрхлын үед монголын газрыг манжийн хаан ерөнхийд нь мэдэж, монголын засаг ноёд үе залгамжлан өмчилж байсан... автономийн үед монголын феодалууд газрыг дангаараа өмчлөх болсон... Харин хошууны засаг ноёд өөрийн эзэмшилт газар нутгийг хүн амын хамтаар үе залгамжлан үр хүүхэддээ шилжүүлэх эрхтэй байсан учир түүнийг өмчлөгчид нь байжээ" гэж бичээд "...хувьсгал эхлэн явагдаж байсан бүр тэр үед ч газрыг улсын өмч болгох асуудал хэлэлцэгдэж байв. Энэ чухал үзэл санаа нь ...хувьсгал ялснаас хойш удалгүй биелэлээ олсон билээ", "газрыг улсын болгосон явдал бол... феодалын эсрэг газрын бодлогын тод илрэл байжээ" гэж дурдсан байна.[3]

Академич Ш.Нацагдорж агсан "Монголын феодализм... бусад улсынхтай нэг адил феодализмын үндэс нь газрын өмч байв", "Манж нарт эзлэгдэхийн өмнө Монголд газар феодалын бүрэн өмч байв" гэж бичсэн байна.[4]

Хуульч эрдэмтэн С.Жалан-Аажав "Феодалууд газрыг бүрэн өмчилж байлаа", "Монголд газрыг хувийн өмч болгож байгаагүй гэдэг ямар ч үндэсгүй... газар дээрх феодалын өмч нь хууль цаазад холбогдолтой зүйл болж хамгаалагдсан нь эргэлзээгүй юм" гэжээ.[5]

---

[1] Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх. УБ., 1984, 146, 369-р тал
[2] Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх. УБ.,1985, 8, 105, 112-р тал
[3] Б.Ширэндэв. Монгол ардын хувьсгалын түүх. УБ. 1969, 73, 279, 385-р тал
[4] Ш.Нацагдорж. Ар Монголд гарсан ардын хөдөлгөөн. УБ., 1966, 9-р тал.
[5] С.Жалан-Аажав. Халх журам бол Монголын хууль цаазны эртний дурсгалт бичиг. УБ., 1958, 84-85-р тал.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор И.Дашням нар Монголын нууц товчооны 207, 219-д Хорчид, Сорхон шард газар нутаг хуваарилан эзэмшүүлсэн тухай дурдсаныг "... газар нутаг өмчлүүлэх асуудал байсан"[6] гэж үзсэн бол Э.Амирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд нар "Нэгэнтээ бэлчээр нутгийг овог, аймгууд хувааж өөр өөрсдийн мэдэлдээ авдаг байсан учир чухамдаа XII-XIII зууны үед монголчууд газрыг хувьдаа өмчилж байсан хэмээн хэлж болох үндэстэй юм" гэжээ.[7]

Өгүүлэл бичигч миний бие ч гэсэн нам, улсын түүх, нэрт эрдэмтдийн бүтээл, 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын эхэн үеийн түүхэн баримт, хууль зүйн актуудыг тухайн үед нарийвчлан тунгааж эс чадсаны улмаас монголын феодалын нийгэмд газрыг хувьдаа өмчилж байсан, түүнийг ардын хувьсгалын ялалтын үр дүнгээр улсын өмч болгосон гэсэн дүгнэлт хийж байсан билээ.[8]

Дээр дурьдсан баримтууд Монголд 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын ялалт хүртэлх хугацаанд газар хувийн өмч байсан гэж үзсээр ирсэн хуучин үзэл баримтлалын илэрхийлэл болж байгаа юм.

Гэтэл судлаачид өнөөдөр асуудалд өөрөөр хандаж, Монгол оронд газар хэний ч **хувийн өмчид байгаагүй, гагцхүү улсын өмч байсаар ирсэн** гэсэн үзэл баримтлал дэвшүүлэн тавьж, түүнээ нотлон тайлбарлаж байгаа нь цөөнгүй байна. Ийм үзэл баримтлал түүхэн хугацааны хувьд "социализмын", "зах зээлийн харилцааны" аль алинд нь нэр хүндтэй эрдэмтэд, судлаачдын дунд байсаар ирсэн, харин олон ургальч үзэл нээлттэй болсон сүүлийн жилүүдэд илүү үндэслэл сайтай судлагдах, бичигдэх болсон юм. Тэдгээр баримтыг иш татья.

Бүр 1933 онд В.А.Рязановский эртний монголчууд газрыг хувьдаа өмчилнө гэдгийг мэддэггүй байв гэж тэмдэглэжээ.[9]

Академич Н.Ишжамц агсан Монголын нэгдсэн төр байгуулагдмагц бүх газар нутаг тэр даруйгаа хааны буюу улсын өмч болжээ. Чингис хаан монголын газар

[6] И.Дашням нар. Эзэн Богд Чингисийн "Их засаг". 1995, 47-р тал.
[7] Э.Амирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд. Монгол хууль. 1997, 16-р тал.
[8] О.Амархүү. Хүрээлэн байгаа орчныг хамгаалах төр, эрхийн онолын зарим асуудал. УБ, 1979, 56-58-р тал болон БНМАУ-ын Газар эзэмшилийн эрх зүй. УБ, 1989, 10-15-р тал үзнэ үү.
[9] В.А.Рязановский. Великая Яса Чингис хаана. Харбин, 1933, 66-р тал.

нутгийг өөрийнхөө хувийн өмч боллоо гэж тунхаглан зарласан тухай мэдээ түүхэнд үгүй гээд цааш нь "XIII зууны дундуур Монголд феодалын газар эзэмшил улсын өмч ба ноёдын эзэмшлийн хэлбэрээр бүрмөсөн бүрэлдэн тогтсон гэжээ."[10]

Академич Ч.Далай XII зууны эцэс XIII зууны эхэн үеийн Монголын нийгэм, эдийн засгийн байдалд дүн шинжилгээ хийхдээ "... мал хэдий хувийн өмчид байсан боловч бэлчээр нутаг, ус аймаг, овгийн өмч хэвээр байлаа.

Зогсоо зайгүй нүүдэллэж байсан малчин ард түмэн тогтмол нутагт суурьшин газрыг хувийн өмч болгон эзэмших боломжгүй байж. Бас тэгээд газрыг хувьд өмчлүүлэхээс Монголын хаад, ноёд ихэд болгоомжилж хааны буюу улсын мэдэлд байлгасаар байжээ"[11] гэж үзсэн байна.

Түүхийн ухааны доктор Г. Сүхбаатар агсан "Газар ба БНМАУ-ын тусгаар тогтнол" гэсэн өгүүлэлдээ: "2200 жилийн өмнөх Хүннү улсын үеэс эхлэн XVII зуун хүртэлх хоёр мянга шахам жилийн турш газрыг улсын өмчид, хааны дээд эрх мэдэлд, малыг хувийн өмчид байлгаж байжээ" гэж бичжээ.[12]

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Т.Сэнгэдорж "Манай оронд газар нь өмчлөлийн жинхэнэ утгаараа иргэдийн хувийн өмчид байж чадаагүй, харин улсын өмчид байсан. Иргэд түүнийг эзэмших, эдлэх эрхтэй байжээ хэмээн үзэж байна"[13] гээд "...Монголын Их хаад газрыг үр удамдаа буюу шадар туслагчиддаа хуваан өгч байсныг тэдний хувьд өмчлүүлж байсан мэт ойлгох тал байна. Энэ нь бидний бодлоор мөн л газрыг эзэмшүүлж байсан өвөрмөц хэлбэр бөгөөд харин шууд утгаараа өмчлүүлж байсан гэж үзэхэд бэрхтэй юм " гэж бичжээ.[14]

О.Амархүү бичээр газрын өмчийн асуудалд нэлээд дагнасан судалгааны ажил хийж, "Монголын нэгдсэн төр улс үүсэн тогтносон тэр үеэс эхлээд нийгмийн тогтолцооны бүх үе шатыг дамжин өнөөгийн нийгмийн байгуулалтын үеийг хүртэлх бүхий л түүхэн хугацаанд манай оронд газар ноёд язгууртны ч, хувь иргэний

[10] Н.Ишжамц. Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ, 1974, 77, 79-р тал.
[11] Ч.Далай. Их Монгол Улс /1206-1260/ дээд дэвтэр, УБ., 1994, 34-35-р тал.
[12] "Ардын эрх" сонин. 1991-11-7. №195.
[13] Т.Сэнгэдорж. Байгаль орчныг хамгаалах эрх зүйн асуудал: уламжлал, шинэчлэл. Докторын зэрэг горилсон диссертаци. 1994. 68-р тал.
[14] Т.Сэнгэдорж. Газрын харилцааны эрх зүйн зохицуулалт. УБ., 1997, 53-р тал.

ч аль алиных нь хувийн өмч байсангүй, харин улсын буюу төрийн өмчид байж, ард нийтийн хөрөнгө болсоор ирсэн юм" гэсэн дүгнэлтэд хүрчээ. Тэрээр энэхүү дүгнэлтэд хүрэх болсон судалгааны материал, тэдгээрт хийсэн дүн шинжилгээ, үзэл бодлоо сүүлийн үед бичсэн бүтээлүүддээ тодорхойлсон байна.[15]

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Н.Лүндэндорж "Монголчуудын өмчлөх эрхийн үзэл сэтгэлгээний уламжлал, шинэчлэл" судалгааны өгүүлэлдээ монгол орны газар өмчлөл, эзэмшлийн нийгэм, эдийн засаг, хууль цаазын агуулга, хэлбэрийг төрийн үйлдвэрлэлийн арга зонхилдог "Азийн үйлдвэрлэлийн арга"-тай нийт уялдуулан авч үзээд, энэ үйлдвэрлэлийн аргын нэг гол онцлог нь газрыг хувь хүмүүст өмчлүүлэхгүй, харин зөвхөн эзэмшүүлж, төр дээд өмчлөгч байдагт оршино гэсэн Маркс тэргүүтэй сэтгэгчдийн үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр "Монголчууд түүхэндээ газар нутгийг хэн нэгэнд өмчилдөггүй байсан" гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.[16]

Эдгээр эрдэмтдийн санал бодол, дүгнэлтийг эргэцүүлэн үзвэл, тэд Монгол оронд газар хувийн өмчид байгаагүй, зөвхөн улсын өмч байсан гэсэн үзэл баримтлалд нэгдэж байгаа нь ойлгомжтой.

Монгол орны газар өмчлөлийн асуудлыг эрдэмтэд, судлаачид ийнхүү эсрэг, тэсрэг хоёр талаас авч үзээд байгаа нь уг асуудалд дагнан гүнзгийрсэн /функциональ/ судалгаа хийгдээгүй, газрын өмчийн тухай "дашрамд" тэмдэглэн өгүүлэх төдий байснаас шалтгаалсан бололтой. Тиймээс уг асуудлыг нарийвчлан судлах хэрэгцээ, шаардлага тулгарч байгаа нь ойлгомжтой. Сүүлийн үед энэ асуудлаар илүү сонирхох болсныг илчлэх илтгэл, өгүүлэл зэрэг судалгааны материал багагүй нийтлэгдсээр байгаа нь онол, практикийн үлэмж ач холбогдолтой, бас олзуурхууштай.

Монгол оронд газрыг феодалууд хувьдаа өмчилж байсан гэх үзэл баримтлалыг дэвшүүлэх бодит учир шалтгаан бас байсан гэж хэлж болно. Тийм учир шалтгааныг тухайн нөхцөл байдлын доорхи 6 хүчин зүйлээр тайлбарлаж болох талтай.

---

[15] О.Амархүү. Байгал орчныг хамгаалах монгол зан заншил, хууль цааз. (Уламжлал, шинэчлэлийн асуудал) УБ.2000, 54-69-р талд болон зохиогчийн бичсэн Монголын орчин цагийн экологийн эрх зүй. УБ. 2004, номын 282-292-р талд үзнэ үү.

[16] Н.Лүндэндорж. "Шихихутуг" сэтгүүл. 2004, 57-62-р талд.

- Марксизм-ленинизмийн сургаалыг үзэл суртлын гол зэвсгээ болгосон нэг намын бодлого, дүгнэлтээс гажихаас болгоомжилсон;
- Монголд газрын харилцаа суурьшмал соёл иргэншил бүхий орнуудынхтай адил хурц тод хөгжөөгүй учир аль илүү үзэл суртаачлагдсан тэр талыг хатуу баримталж болох бололцоо байсан;
- Монгол оронд нүүдэлчдийн соёл иргэншил олон зуун жилээр тогтнож, хөгжиж ирсэнтэй шууд холбоотойгоор нийгмийн бүлгүүдийн хооронд газар өмчлөлийн биш, харин газрыг үе залгамжлан эзэмшиж ашиглах харилцаа илүү хөгжсөн үндэсний онцлогийг дөвийлгөн гаргахыг төдийлөн эрмэлзэлгүй байсан;
- Газар өмчлөх, эзэмших эрхийн харилцааны хувьд хууль зүйн шинжлэх ухааны өөр хоорондоо холбоотой хэдий ч эцсийнхээ үр дүнгээр ялгаатай хоёр ойлголтыг ялган салгаж үзэх талаар төдийлөн анхаарал тавиагүй;
- Аймаг, хошуу мэт засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хуваарилалтыг, өөрөөр хэлбэл засаг ба засаг бус ноёд, сүм хийдийн тэргүүн нарын эзэмшил газар нутгийг газар өмчлөлийн хэлбэр мэтээр үзсэн;
- Монгол төрийн эртний хууль цаазны эх сурвалжуудыг төдийлөн сайн хайхралгүйгээр бэлчээр, ус, хадлангийн талбайг эзэмшиж ашиглах маргааныг газар өмчлөх эрх булаалдсан тэмцэл мэтээр андуурч байсан зэргийг нэрлэж болох юм.

Монгол орон түүхийнхээ туршид газрыг гагцхүү усын өмч, ард нийтийн хөрөнгө байлгасаар 1992 оны Үндсэн хуультай золгосон гэж хэлж болно. Үүнийг Монгол орны эдийн засаг, хууль цааз, төрийн удирдлага гэсэн гурван тулгуур асуудлын онцлогийг илтгэсэн түүхэн эх сурвалжууд тодорхой харуулж байна. Тэр бүхнийг нарийвчлан судлах нь л өнөөдөр чухал юм. Энд жишээ болгож хууль зүйн зөвхөн нэг баримтыг дурдвал: Монголд газар хувийн өмч байгаагүй юм бол 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын ялалтын дараахан Ардын Түр Засгийн газар газрыг хувьд өмчлүүлэхгүй байх тухай шийдвэрийг яагаад зориуд тусгайлан гаргаж байсан бэ гэдэг асуудлаар эрдэмтэд, судлаачид санал нэгдээгүй хэвээр байгаа юм.

Ардын Түр Засгийн газрын 1921 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 19 дүгээр хурлын тогтоолд: "Манай монгол хязгаар дотор бүхий газар ус

болбоос монгол ард түмний хөрөнгө мөний тул Монголын орон нутгийг (газрыг О.А) энгийн дотоод, гадаадын хүн нар миний хэмээн түрэмгийлэн эзэрхэхийг манай Монголын Ардын Засгийн газраас үүнээс хойш зогсоохоор зөвлөн тогтов" [17] гэж заажээ. Энэ бол газрын асуудлаар гаргасан анхны маш чухал эрх зүйн акт мөн бөгөөд түүнд үндэсний ардчилсан хувьсгалын эхнээс газрын харилцааны асуудлаар төрөөс баримтлах бодлого тодорхойлогдсон юм. Дурдсан шийдвэрт "газар ус бол Монголын ард түмний хөрөнгө мөн", түүнийг "миний хэмээн түрэмгийлэн эзэрхэхийг ... зогсоох" тухай зориуд онцлон заасан нь **нэгдүгээрт**, газар усыг хувьд өмчилж байгаагүй, **хоёрдугаарт**, цаашид ч өмчлүүлэхгүй, дур зоргоор эзэмшүүлэхгүй гэсэн давхар давхар утга санааг эрх зүйн хэм хэмжээний хэлбэрт оруулан бататгасан гэж үзэж болно.

Ардын Түр Засгийн газрын дээрх шийдвэрийн утга санааг улам нарийвчлан гүнзгийрүүлж, газар төдийгүй байгалийн бүх баялагийг хамруулан БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн нэгд: "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ой мод, ус ба мөн тэдгээрийн баялагууд бол эрт цагаас наաш ард нийтийн хөрөнгө байсаар ирсэн зан суртал нь чухам одоогийн ард улсын ёсонд нийлэлцэх тул энэхүү хөрөнгө бүрнээ ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно"[18] гэж тов тодорхой заасан байна. Үүнээс үзэхэд, газар Монгол оронд "эрт цагаас наաш ард нийтийн хөрөнгө байсаар ирсэн" зан заншлын уламжлалтай, хувьд өмчлүүлж, өмчилж байгаагүй, ийм уламжлалаа хувьсгалын шинэ нөхцөлд ч цаашид халгалан үлдээхээр Үндсэн хуулиараа бататган тунхаглажээ гэдгийг энэхүү баримт тод гэрчилж байна. Харин хувийн өмч байсныг халсан гэх ямар нэг агуулга ажиглагдахгүй байгаа юм.

Монгол оронд газрыг хувьд өмчилж байх нийгэм, эдийн засгийн бодит боломж бүрдээгүй, тийм байдал ч байгаагүй гэсэн санааг улам тодруулахын тулд доорхи гурван асуудалд судалгааны анхаарлыг илүүтэй төвлөрүүлэх ёстой гэж үзэж байна.

**Эдийн засгийн төлөв байдал.** Нүүдэлчин монголчуудын нийгмийн эдийн засгийн үндэс нь газар биш, мал сүрэг, мал аж ахуйн үйлдвэрлэл байсан. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл нь бэлчээр нутаг байв.

[17] МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1920-1940, УБ., 54-р тал.
[18] "БНМАУ-ыг Их, Бага Хурлын тогтоол, Үндсэн хууль, Тунхагууд" УБ., 1956, 30-р тал.

Ингэхлээр мал сүргийг газар-бэлчээр нутгаас салангид авч үзэх үндэслэлгүй. Гэхдээ Монголын мал, газар хоёрын харилцан шүтэлцээ их өвөрмөц шинжтэй.

Монголд мал сүрэг нийгмийн бүлгүүдийн аль алиных нь хувийн өмчид байсаар ирсэн. Харин газар тийм байсангүй, аль ч бүлгийн эзэмшил, ашиглалтад байсан, өмчийн хувьд зөвхөн улсад байжээ. Өмчийн энэ хэлбэр өнөөг хүртэл газрын харилцаанд зонхилох хэмжээгээр хадгалагдан уламжлагдсаар байгаа гэж үзэж болно.

Гэтэл суурин соёл иргэншил бүхий улс оронд газар өмчлөлийн асуудал үүнээс эрс өөр байсныг нотлох оролдлого хийх хэрэггүй нь ойлгомжтой.

Монголын нүүдэлчин ардуудын үйлдвэрлэлийн гол арга, технологи нь цаг улирлын байдлыг дагаж ус, бэлчээрийн сорогог сайныг сонгож аж төрдөг байдалд тулгуурладаг байсан. Тэгэхдээ төр, захиргааны нэгжийн эрх мэдлээ хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн өөрийн захиргааны дотор төдийгүй өөр аймаг, хошууны нутаг дэвсгэрт хүртэл чөлөөтэй нүүдэллэн нутаглаж мал аж ахуйн үйлдвэрлэлээ эрхэлдэг байсан. Энэ байдал өнөөг хүртэл уламжлагдан ирсэн юм.

Монгол оронд газар тариалан тогтвортой хөгжөөгүй, хот, суурин төвлөрч барилга байгууламж барьж суурьшдаггүй, аж үйлдвэрийн салбарууд хөгжөөгүй зэргээс хамааралтайгаар монгол хүнд газрыг хувьдаа өмчлөх үзэл, сэтгэлгээ төлөвшөөгүй өвөрмөц онцлог бас бий. Үүнтэй холбоотойгоор газрыг өмчлөх биш, харин үр удам дамжин эзэмшиж ашиглах үзэл, сэтгэлгээ л илүүтэй төлөвшсөн гэж хэлж болно. Тиймээс ч Монголчууд нүүдэлчин амьдралынхаа хүрээнд жилийн дөрвөн улирлын алинд нь ч нутаг бэлчээрийг язгууртан ч, ардууд ч үр удам дамжин өвлөж тогтвортой эзэмшин ашиглаж ирсэн түүхэн баримт, зан заншил зөндөө буй. Энэ бол газар нутгаа эзэмшин ирсэн нүүдэлчдийн соёл иргэншлийн зан заншлын хэм хэмжээгээр тогтож хэвшсэн уламжлал юм. Харин эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулсан өмчийн хэлбэр биш.

Зан заншлын ийм уламжлалыг дагаж нутаг бэлчээр, хадлангийн талбайн маргаан гардаг, түүнчлэн засаг ноёд, сүм хийдийн мал сүрэг ус, бэлчээрийн аль сайныг эзэлж, ард олны мал сүрэг бэлчээрээр гачигдлаа гэсэн маргаан бас гардаг байв. Үүнийг газар өмчлөлийн маргаан мэтээр үзэх үндэслэлгүй билээ. Учир нь газар үнэхээр л ноёд, язгууртны хувийн өмч байсан юм бол тэр өмчийг булаалдан маргаан гарах хууль зүйн үндэслэл байхгүй, жишээ нь

ноёдын хувийн өмчийн мал сүргийг авна гэсэн маргаан гардаггүйтэй агуулгын хувьд адил юм. Харин газар нь бүх нийтийн эзэмшилд байсан учраас л маргаан гарах бодит үндэслэл нь болж байсан байна.

Монголын нийгмийн бүлгүүд газрыг зөвхөн эзэмшин ашиглаж байсан учраас газрыг худалдах, худалдан авах ойлголт болон газрын рентийн тухай асуудал ч огт байсангүй. Ардуудаас биет зүйл, мөнгөөр авч байсан татвар нь газрын рентийн ямар нэг хэлбэр биш, хүн амын орлогын татварын ердийн нэгэн илрэл болж байв. Тийм татвар нь зөвхөн мал, түүний ашиг шим, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтынх л байсан болохоос бэлчээр ашигласных биш байв.

Энэ бүхнийг эрэгцүүлэн үзэхэд, Азийн үйлдвэрлэлийн аргын онцлог нь газрыг хувьд өмчлүүлдэггүй, зөвхөн эзэмшүүлэн ашиглуулж, харин дээд өмчлөгч нь гагцхүү төр байдаг явдал Монгол оронд төлөвшин тогтсон тухай, үүнээс улбаалан монгол үндэстэнд бүрэлдэн тогтсон үеэсээ эхлэн хувийн өмчийн, тэр дотроо газрын өмчийн үзэл, сэтгэлгээний уламжлал байгаагүй гэж үзсэн[19] шинжлэх ухааны доктор, профессор Н.Лүндэндоржийн санал, бодолтой бивээр нэг байгаа бөлгөө.

**Хууль цаазны төлөв байдал.** Монголд газар хувийн өмч байсан гэж үзэх хууль цаазны түүхэн эх сурвалж ерөөс байсангүй, харин улсын өмч, нийтийн эзэмшил ашиглалтад байсныг хуульчилсан баримт олонтоо тааралдана.

Монголын төрт ёсны эртний хууль цааз болсон Их засаг, Алтан хааны цаазын бичиг, Монгол-Ойрадын хууль, Халх журам, Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг зэргээс авахуулаад Монгол улсын анхны болон дараа дараачийн Үндсэн хуулиудад газар нь байгалийн бусад баялагийн хамт улсын өмч, ард нийтийн хөрөнгө байж, түүнийг зөвхөн эзэмшин ашиглаж байсан гэдгийг ил тод заасаар ирсэн аж.

Зарим тодорхой жишээ дурдвал, Монгол-Ойрадын хуульд хаад, ноёдын ан гөрөө хийх газар нутгийг тусгайлан заж, түүнийг энгийн ардуудаас хамгаалах заалт байгаа нь хаад, ноёд газрыг өмчлөгч биш байсныг улам илүү тод харуулж байгаа юм. Хэрэв тэд газрыг өмчлөгч байсан бол төрөөс тэдний ан гөрөөний

[19] Н.Лүндэндорж. Монголчуудын өмчлөх эрхийн үзэл сэтгэлгээний уламжлал, шинэчлэл. "Шихихутуг" сэтгүүл. 2004, 57-62-р талд.

газрыг хуулиар тусгайлан зохицуулалт хийх шаардлага байхгүй нь ойлгомжтой. Түүнчлэн манай эртний хууль цаазны эх сурвалжуудын нэг нь болсон Их Юаны нэгтэрхий хуульд "Их хааны захирганы бүх газар нутаг" гэж онцлон заасан байдаг. Энэ нь төр улсаа удирдан жолоодож байсан их хаан улсынхаа газар нутгийг улсаа төлөөлж удирдан мэдэж байх тухай заалт юм. Харин өмчлөх тухай асуудал биш ээ.

Халх журам, Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг Монголд газар хувийн өмчид байгаагүйг мөн л нотолно. Халх журмын 126, 127-р зүйлд хүрээний орчмын газрыг тусгай хамгаалалтад авч, уг газраас хуурай, нойтон мод огтлох, ан амьтан агнахыг хориглож, гурван этгээдийн элч гарган хянаж байх тухай заалт бий. Хэрэв хүрээ хийдийн газар нь хутагт хувилгаадын хувийн өмч байсан бол түүнийг хамгаалах асуудлыг хуулиар ийнхүү тусгайлан зохицуулж, бүх нийтээр дагаж мөрдөх журмыг төрөөс хуульчлан тогтоох хэрэгцээ байгаагүй нь тодорхой. Түүнчлэн Халх журмын 124-р зүйлд нутагтаа ноёдын өргөө барих газраас бусад газарт аль тааламжтайгаар нутаглаж байх эрхийг хувргийн шавь нар, хийдийн сахиулчдад олгож байхаар заасан нь хувийн өмч бишийг бас нотолно.

Худаг ус ч гэсэн газрын нэг адил улсын өмчид байсан. Харин түүнийг он удаан жил буюу өөрийн хөдөлмөрөөр засч тохижуулан эзэмшиж байсан эзний нь эрхийг бусдын дур зоргын эзэмшлээс хамгаалах тухай заалт Халх журмын 173-р зүйлд орж, хүний шинэ ухсан, зассан усыг булаацалдаж хэрүүл маргаан үүсгэвэл хязаалан мориор торгож байх тухай өгүүлсэн байдаг.

Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичигт болон тухайн цаг үеийн бусад эрх зүйн актад газар, байгалийн бусад баялаг улсын өмч мөн болохыг маш тодорхой тусгаж байжээ. Жишээлбэл, хууль зүйлийн бичгийн "Түшмэлийн засаг" хэмээх Арвадугаар, "Битүү хулгах нь" хэмээх Тавин нэгдүгээр дэвтэрт алт, мөнгө, элс зэрэг байгалийн баялгийг хариуцан хамгаалж байх үүргийг харьяа засаг, түшмэл нарт оногдуулж, тэд хариуцлага алдаж уг баялгийг бусдад хулгайлуулсан, түүнчлэн өөрөө удирдаж сэм ашиглавал хулгайлсан гэж үзэж тус тус хатуу шийтгэл оногдуулж байхаар хуульчилжээ.

Түүнчлэн "Газль татвар" хэмээх Арван гуравдугаар, "Сангийн аму" хэмээх Арван хоёрдугаар дэвтэрт монголын олон хошуу, шавийн нутаг гадаад хүмүүс малын бэлчээр, хашаа байшингийн газрыг түрээс эзэмшин эдэлж газль татвар төлж, түүнийг улсын санд оруулж байх, алваа орон нутгийн эрхэм сүлд бүхий

газар болон малын бэлчээрт харшгүй газарт сангийн аму тариалах, тариалангийн газрын нэр, хэмжээг зургаар гаргаж Сангийн яамнаас зөвшөөрөл авч хяналтад нь ажиллаж байх тухай тус тус заажээ. Мөн "Нутгийн хэргийн хууль" хэмээх Дөчин тавдугаар дэвтэрт бүх засаг хошуудын нутаг дэвсгэрийн хил заагийг нарийн тодорхой зургаар гаргаж, овоо тэмдэг тавьж Дотоод яамнаас хянан баталж байх, Богд Жавзандамба хутагтын шавь нарт тусгайлан газар нутаг зааж хувиан олгохгүйгээр халхын дөрвөн аймгийн олон засаг хошууны нутагт дуртайг үзэж нутаглах эрх олгосон тухай заасан байна.

Богдын Засгийн газар Монгол нутагт XIX зууны сүүлчээр байгуулагдсан Монгол, Оросын хамтарсан "Монголор" алтны уурхайг үргэлжлүүлэн ажиллуулах тухай гэрээг 1912 онд байгуулж, олборлосон нийт алтны 16,5 хувийг алтаар нь буюу рублиэр улсын санд нийлүүлж байх, мөн Оросын худалдаачдад алтны уурхай нээх эрх олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэж байх журам тогтоосны гадна байгалийн баялгийг ашиглах, хамгаалах, захиран зарцуулах эрхийг гагцхүү Засгийн газраас эрхлэн мэдэж байх эрх, үүргийг нарийвчлан заасан "Монгол улсын дотор алт, мөнгөний зэрэг олон зүйлийн уурхай нээх дүрэм"-ийг 1913 онд баталж мөрдүүлжээ. Түүнчлэн 1916 онд "Монгол улсын хөрөнгийг захирах газар"-ыг тусгайлан байгуулж, түүний дүрмийг батлан мөрдүүлсэн байна. Уг дүрэмд "Тус улсын байгалийн бүх баялаг, ой мод, ус элдэв уурхай, ашиглаж буй ба мөн ашиглаж болох сул газар цөм Монгол улсын хөрөнгө мөн" гэж заасан байна.

Түүхэн баримт сэлт, хууль цаазны түүхэн эх сурвалжуудаас үзэхэд Монгол оронд газар, түүний баялаг хувийн өмчид байгаагүй учраас 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын ялалтаар газрын реформ хийгээгүй, харин газар нь уламжлал ёсоор урьдын адил улсын өмч хэвээр байна, хувьд өмчлүүлэхгүй гэдгийг дахин баталгаажуулж, бүх нийтэд зарлан тунхаглажээ.

Газар улсын өмч байсаар ирсэн төрийн энэхүү түүхэн уламжлалыг Монгол улсын 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиар төдийгүй шинэ нийгмийн байгуулалтын 1992 оны хуулиар залгамжлуулан баталгаажуулсан юм. Харин шинэ Үндсэн хууль төрийн өмчийн газраас зөвхөн Монгол Улсын иргэнд газар өмчлүүлж болох эрх зүйн хэм хэмжээг төрийн түүхэнд анх удаа тогтоов. Үүнийг үндэслэн Улсын Их Хурал 2002 онд "Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай" түүхэн цоо шинэ хуулийг батлан мөрдүүлжээ. Энэ талаар өгүүллийхээ II хэсэгт товч өгүүлэх болно.

**Төрийн удирдлагын төлөв байдал.** Монголын газрын харилцааны асуудлыг түүхэн үе шатуудад төрөөс удирдаж ирсэн баримт сэлтүүд олонтаа байгаа бөгөөд тэр нь газар өмчлөл улсынхаас өөрөөр байж чадаагүйг илтгэн харуулах хууль зүйн бас нэг томоохон нотолгооны нэг мөн.

Их Монголын эзэн хаан Чингисийн эрх мэдлээ хэрэгжүүлэх нутаг дэвсгэр нь Хянганы нуруунаас Алтайн уулс хүртэлх 1600 км, Байгаль нуураас Түмэн газрын Цагаан хэрэм хүртэлх 960 км өргөн уудам байсан түүхтэй. Энэ нь бас улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах хил хязгаар нь болж байжээ.

Өргөн уудам газар нутагт төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж улс орноо удирдан жолоодох их үйл хэргийг омтгойдолгүйгээр гүйцэлдүүлэхийн тулд Чингис хаан нэгдсэн улсынхаа төрийн удирдлага, засаг захиргаан зохион байгуулалтыг үндсэнд нь цэргийн зохион байгуулалттай адилаар аравт, зуут, мянгат, түмэд гэж ангилж, мянгат, түмэдийн удирдагч ноёдыг төрийн бодлого боловсруулах, шийдвэрлэх, гүйцэтгэх эрх үүрэгтэйгээр ажиллуулж байсан бөгөөд тэдний эрх мэдлээ хэрэгжүүлэх газар нутгийг хуваарилан эзэмшүүлэн олгож байжээ.

Дашрамд дурдахад, доктор (Sc), профессор Н.Лүндэндорж "Чингис хаан таалал төгсөхийн өмнө ууган монголын газар нутгийг ууган хөвгүүн Тулуйд, эзэлсэн бусад нутаг орныг бусад хөвгүүддээ соёрхох буюу хувь өмч болгон хуваан өгсөн тухай түүхийн баримт бий"[2] гээд тухайн баримтын талаар өгүүлсэн байна. Үүнтэй санал нэгдэх боломжгүй гэж үзэж буй. Учир нь дурдсан түүхэн баримт нь газрыг **"хувь өмч"** болгон өгсөн хэрэг хараахан биш, харин удидлага-захиргааны эрх мэдлээ хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийг **"соёрхсон"** буюу хуваарилан зааглаж эзэмшүүлсэн тухай баримт гэж үзэж буйд оршино.

Монголын хэмжээлшгүй эрхт хаадын үеэс эхлэн хэмжээт эрхт Богд хаант засгийн үед ч газрын харилцааны асуудал төрийн удирдлагын нэг гол бүрэлдэхүүн хэсэг нь байсаар ирсэн түүхтэй. Нэг үгээр хэлбэл газар нутгийг гагцхүү улс гүрний эзэн хааны эрх мэдэлд байлгаж, төрийн удирдлага, зохицуулалтаар газрын харилцааны бүхий л асуудлыг дээрээс дор хүртэл босоо шугаман тогтолцоогоор шийдвэрлэж, түүнийгээ амьдралд ягштал баримтлан хэрэгжүүлж иржээ.

---

[2] Н.Лүндэндорж. "Шихихутуг" сэтгүүл. 2004, 58-59-р тал

Монголын газрын харилцааны төрийн удирдлага түүхийн хувьд ерөнхий удирдлага нь төвдөө, өөрөөр хэлбэл эзэн хаанд, гүйцэтгэх засаглалын удирдлага нь нутаг дэвсгэрийн эрх баригч засаг ноёдод тус тус төвлөрч байв.

Газрын харилцааны хувьд төрийн удирдлага иймэрхүү хэлбэртэй байх нь зүй зохистойг Монголын төрийн уламжлалт үйл ажиллагаа харуулж чадсан учраас өдгөө ч залгамж шинж чанараа хадгалсаар байна. Монгол Улсын Үндсэн хууль, байгаль орчны хуулиудад газар, байгалийн бусад баялаг төрийн өмчид байх, тэрхүү өмчийг ямар нэг хэлбэрээр задлах, газар, байгалын бусад баялагийг эзэмших, ашиглах, хамгаалах үйл ажиллагааг удирдлагын нэг цэгт, өөрөөр хэлбэл төрд төвлөрүүлж, нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагын оролцоог өргөтгөж, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтыг хууль тогтоох аргаар шийдвэрлэж байх зачим, горим тусгалаа олж баталгаажсан юм.

Түүхийн бодит байдалд тулгуурлан Монгол орны газар өмчлөлийн маргаантай асуудалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Түүхийн хүрээлэн, түүхч нэрт эрдэмтэд уг асуудалд өмнөхөөсөө тэс өөрөөр хандсан шинэ үзэл баримтлалыг дэвшүүлэх болов. Тодруулбал шинэчлэн бичсэн Монгол Улсын Түүхийн таван ботийн Тавдугаар ботид газар тариалан эрхлэх ардуудад газрыг түрээсгүйгээр олгох арга хэмжээ авсныг цохон дурдаад цааш нь "Газартай холбоотой бусад асуудлуудыг ч нэгэн адил шийдвэрлэж, засаг ба засаг бус ноёдын газрыг үе улиран эзэмших эрхийг устгав. Шавийн дүрмээр Богд ба тамгатай хутагт, шавь нар аль дуртай газраа бэлчээр сонгон нутагладаг байсан онцгой эрх ч нэгэн адил үгүй болов[21] гэж бичжээ. Энд "газрыг үе улиран **эзэмших эрхийг** устгав" гэсэн нь "**өмчилж**" байгаагүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэрэг төдийгүй, газрын өмчийн талаархи онол, арга зүйн асуудалд нэгдсэн хариу өгсөн гэж хэлж болно.

## II. Монголд газар өмчлөх эрхийн шинэчлэлийн тойм

Нэгэнт газар өмчлөлийн асуудлыг түүхэн талаас нь авч үзсэн болохоор түүхийн нэгэн зурвас үе болсон зах зээлийн эдийн засгийн харилцааны шинэ нөхцөлд Монгол оронд газрын өмчийн талаар ямар шинэчлэл хийгдэж

[21] Монгол Улсын түүх. Тавдугаар боть (XX зуун), Улаанбаатар, 2003, 142-р тал

байгааг, өөрөөр хэлбэл газар өмчлөх эрхийн цоо шинэ асуудлыг товч боловч дурдах нь судалгааны чухал ач холбогдолтой.

Шилжилтийн эдийн засагтай Монгол орны хувьд газрын шинэчлэл тулгамдсан асуудлын нэг мөн. Монгол улс газрын шинэчлэлээр туршлага багатай, богино зам туулсан орон. Тиймээс үндсэндээ шинэ зүйл гэж хэлж болно. Газрын шинэчлэл янз бүрийн улс оронд янз бүрийн цаг үед хийгдэж байсан, олон ч бэрхшээлтэй тулгарсаар ирсэн сургамж бүхий түүхэн асуудал юм.

Төв болон зүүн Европын төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж буй орнуудын хувьд ч энэ асуудал өнөө хэр бүрэн шийдэгдээгүй байна. Гэхдээ газрын харилцаан дахь даяаршлын ерөнхий чиг хандлага, жишгийн дагуу өөр өөрийн өвөрмөц арга хэлбэрээр явж байна.

Монголын төр, засаг газрын шинэчлэлийн асуудалд ардчилал, зах зээлийн шинэ нөхцөлийн бүр эхэн үеэс анхаарч, эрх зүйн орчныг нь бүрдүүлэх дэс дараатай арга хэмжээ авсаар байна. 1992 онд баталсан Монгол Улсын шинэ Үндсэн хууль газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж, өмчлөгчийн эрхээ тодорхой хязгаарын дотор эдэлж байх эрх зүйн цоо шинэ хэм хэмжээг баталгаажуулав.

1994 онд баталсан Газрын тухай хууль газрын харилцааны шинэчлэлд монголчуудын уламжлал, түүнийг дагаж тогтсон дэг журмыг үндэслэн хоёр шинэ алхам хийсэн. Нэг нь газрыг эзэмшиж ашиглах харилцаанд иргэд өрх (гэр бүл)-ийн нэгжээр оролцож байх, нөгөө нь иргэд газрыг 60 хүртэлх жилийн, дахин сунгалт тутамд 40 хүртэл жилийн урт хугацааны эзэмшил ашиглалтад авах эрх эдлэж байхаар хуульчилсан явдал мөн. Гэхдээ 60 хүртэл жилийн доод хязгаарыг хуульд тусгаагүй учир хэрэг дээрээ урт хугацааны эзэмшил, ашиглалт болж чадахгүй дутагдалтай байв. Энэ дутагдлыг 2002 онд шинэчлэн баталсан Газрын тухай хуулиар арилгаж, газар эзэмшиж ашиглах хугацааны доод хязгаарыг Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд 15 жил байхаар тогтоосон нь нэг том ололт болов.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг 2002 онд шинээр батлаж, түүнийг 2003 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа нь шинэчлэлийг гүнзгийрүүлсэн цоо шинэ алхам, газрын харилцааны хөгжлийн шинэ үе шат болов.

Үндсэн хууль, Газрын тухай болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль нь эрх зүйн мөн чанар, агуулгаараа газрын өмчийн эрхийг уян хатан авч үзэх боломжийг шинээр нээж өгсөн. Ийм үзэл баримтлал газрын өмчийн эрхэд бусад эд хөрөнгийнхөөс илүү өвөрмөц, ялгамжтай хандах онол, практикийн үндсийг баталгаажуулж өгөв. Шууд утгаар нь хэлбэл, Монголд газар нь төрийн өмч, хувийн өмчийн хэлбэртэй байж болохыг хуульчилсан. Үүгээр монголын газрын харилцааны хөгжлийн түүхэнд шинэ үе шат эхэлсэн. Энэ нь газрын төрийн өмчийн монополийг задалсан хэрэг мөн.

Газар өмчлөх төрийн монополийг задлах арга хэлбэр олон янз байдаг. Тэгэхлээр төрийн газар өмчлөх эрх халдашгүй дархан биш гэдэг нь ойлгомжтой. Түүнд зарим хэлбэрээр өөрчлөлт оруулж болно. Жишээ нь, газрыг төрийн өмчөөс салгаж өөр субъектын өмч болгон тасалж өгөх, түүнчлэн төр өмчийнхөө эрхийг үндсэнд нь хадгалаад газрыг урт удаан хугацаагаар эзэмшүүлэх, уг хугацааны туршид эзэмшигч нь өмчлөгчийн эрхээр газар дээрээ ажиллах, хамгийн товчоор хэлбэл "урт хугацаагаар эзэмшихийг өмчлөх эрхтэй адилтган үзэх" хууль зүйн бололцоо олгох арга хэлбэрийг нэрлэж болно. Ийнхүү Монголд төрөөс газар өмчлөх монополь эрхийг хоёр арга замаар задалсан нь судлаачдын анхаарлыг зүй ёсоор татах учиртай.

Газрыг төрийн, орон нутгийн /муниципаль/ буюу өөрөө удирдах байгууллагын, хувь хүний, хамт олны өмчлөлд шилжүүлэх арга Ази, Европын ихэнх оронд зонхилж байна. Харин Монголд үүнээс өөр. Зөвхөн Монгол Улсын иргэнд газрыг түүний өмч болгон олгох, мөн Монгол Улсын иргэн, Монгол Улсын хуулийн этгээдэд газрыг урт хугацаагаар эзэмшүүлэх гэсэн хоёр арга хэлбэрийг хэрэглэж байна.

Энэхүү хоёр арга хэлбэрийг зах зээлийн эдийн засгийн нөхцөлд нэлээд улс орон алийг нь ч хуульчлан хэрэглэж байгаа бөлгөө. Энэ нь газрын өмчийн хуучирсан хэлбэр солигдож, халагдаж байгааг бидэнд анхааруулж байгаа үйл явц мөн.

Газрыг урт хугацаагаар эзэмшүүлж ашиглуулахын давуу тал нь эдийн засгийн ашиг сонирхлын хувьд ч, эрхийн статусын хувьд ч хоорондоо нягт уялдаа бүхий давуу тал олонтой гэж хэлж болно.

Урт хугацааны эзэмшил нь эдийн засгийн дор дурдсан давуу талтай учир эзэмшигчийн ашиг сонирхолд илүү нийцтэй болдог.

- Үл хөдлөх хөрөнгийн нэгжийг бий болгодог
- Тэр хөрөнгөөрөө баталгаажуулж зээлжих эрх эдэлдэг
- Газарт урт хугацааны хөрөнгө оруулалт хийж, өгөөжийг нь нэмэгдүүлж, удаан хугацаанд илүү ашиг олох боломж бүрддэг
- Гэзар, хөрсний эвдрэлээс хамгаалах хэрэгцээ сонирхол илүүтэй бий болж, байгаль хамгаалах соёлтой орчин төлөвшдөг
- Газрыг эдэлж ашиглах тогтвортой зориулалт бий болж орон сууц, хашаа, барилга байгууламж барих, жижигхэн цэцэрлэгтэй болох, мөн жижиг фермерийн аж ахуй хөгжүүлэх сонирхол бий болдог.

Гэтэл богино буюу түр хугацааны газар эзэмшилд эдийн засгийн болон эрх зүйн ийм боломцоо олддоггүй тул нийгэм, төр, газар эзэмшигч субъектын аль алиных нь эрх ашиг, сонирхолд тааламжтай нөлөө үзүүлэхгүй.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль нь аливаа улс орон өөрийн харьяат иргэнд газар өмчлүүлж өгдөг олон улсын жишигт нийцсэн, тийм түвшинд хүрсэн гэж үзэж болно. Үндсэн хуульд заасан "иргэн" гэсэн үг нь хүн бүр гэсэн санаа огт биш, харин хүний иргэний харьяаллыг заасан хууль зүйн онол, практикийн чухал ач холбогдолтой томъёолол мөн. Тиймээс Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэхдээ хүн тус бүрт биш, харин гэр бүлээр нь /өрхөөр/ субъект болгож байх нь шинжлэх ухааны үндэслэл бүхий шинэчлэл болсон юм. "Гэр бүл" гэдэг бол нийгмийн бүтцийн анхан шатны нэгж мөн. Газар өмчлөх эрхийн субъектээр энэхүү нэгжийг сонгон авсан нь зөв шийдэл болжээ. Гэр бүлийн дотор хичнээн гишүүнтэй ч байсан тэдний хэрэгцээнд өмчлүүлэх гэр, байшин, хашааны газар нь амьжиргаанд нь адил тэгш нөлөө үзүүлнэ. Гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгийг бий болгоно. Энэ бүхэн нь Монгол Улсын Иргэний хуулийн "Гэр бүлийн хөрөнгийн эрх" гэсэн 126-133 дугаар зүйлийн үндэслэлүүдтэй агуулгаараа нийцэж байна.

Хэрэв гэр бүлийн гишүүн бүрт газар өмчлүүлнэ гэх юм бол гэр бүлийн хамтран өмчлөх дундын өмч /ИХ-ийн 126 зүйл/-ийн хууль зүйн утга агуулга алдагдана. Өөрөөр хэлбэл газар өмчлөлийн хууль нь Иргэний хуультай зөрчилд орж амьдралд хэрэгжүүлэх боломцоо үгүйсгэгдэнэ. Маргаан гарсан тохиолдолд шүүхээс түүнийг шийдвэрлэх эрх зүйн үндэслэл суларна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд заасан "гэр бүл" гэсэн томъёолол нь Гэр бүлийн тухай хуультай харьцуулан судлахад "буруу зөрүү" ойлголт төрүүлж байгаа тухай зарим эрдэмтэд, судлаачид тэмдэглэн

хэлж байгааг анхааран үзэх ёстой зүйл мөн. Бидний үзэж байгаагаар газар өмчлөлийн хууль дахь "гэр бүл" гэсэн томъёоллын утга агуулга нь гэр бүлийн эрх зүйн харилцааны зохицуулалтад авч үздэг гэр бүлийн ойлголтыг "цэврээр" илэрхийлсэн биш бололтой. Харин монголчуудын аж ахуй эрхлэж ирсэн уламжлалт нэгж болсон "айл-өрх" гэсэн утга агуулгыг хадгалсан хэмээн үзэж болохоор байна. Иймээс уг хуульд орсон "гэр бүл" гэснийг "айл-өрх" гэсэн утгаар ойлгож хэрэглэх талаар Монгол Улсын Дээд шүүх тайлбар гаргах нь зүйтэй гэж бодогдоно.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд газрыг иргэнд гэр бүлийн хэрэгцээнд, аж ахуйн хэрэгцээнд гэсэн хоёр үндсэн зориулалтаар, зохих хэмжээтэйгээр өмчлүүлэхээр заасан. Гэр бүлийн хэрэгцээний газар нь гэр, орон сууцны хашаа барих, аж ахуйн хэрэгцээний газар нь үйлдвэр, үйлчилгээний объектын болон газар тариалан эрхлэх зориулалтын газар юм. Энэ бол Монголын газар өмчлөлд шинээр бий болсон эдийн засаг, хууль зүйн хамгийн таатай нөхцөл, боломж бүхий шинэчлэл гэж үзэж болно. Үүний үндсэн дээр иргэд газар хэмээх үл хөдлөх хувийн өмчтэй болж, түүнийгээ өөрөө өмчлөх, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх эдэлнэ.

Түүнчлэн гэр бүлийн хэрэгцээний газрыг өрхөөрөө дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх хэлбэрээр өмчилж болохыг хуулийн 20 дугаар зүйлийн 1-ийн 4-т зааж зөвшөөрчээ. Энэ нь монголчууд эцэг эх, үр хүүхэд, ах дүүс, садан төрлөөрөө айл аймаг хамт явж амьдарсаар ирсэн уламжлалт зан үйлийг харгалзан үзсэн шинэчлэл бөгөөд ингэснээр хууль амьдралд ойр, аж төрөх үндэсний онцлог шинжийг харуулан хадгалсан гэж үзэж болно.

Газар өмчлөлийн хуулийн 19.1.2, 19.1.3, 19.1.4-т заасныар гэр бүлийн хэрэгцээний газрыг иргэд нэг удаа үнэгүй өмчилж авна. Харин газар тариалангийн болон аж ахуйн бусад зориулалтаар өмчилж авах газрыг /хуулийн 19.1.5, 19.1.6, 19.1.7/ үнээр нь худалдаж буюу дуудлага худалдаагаар худалдаж авна. Энэ нь ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэж, ашгийн төлөө ажиллах аж ахуйн нэгжийн хувьд зах зээлийн нийтлэг журмаас үүдэлтэй шударга ёсны зарчимд үндэслэжээ гэж үзэж болохоор байна.

Харин гэр бүлийн хэргцээний газрын хувьд энэ зарчмаас өөр үзэл баримтлалыг сонгожээ. Хүн амын амьжиргааны төвшин доогуур байгаа өнөөгийн нөхцөлд иргэддээ гэр бүлийнх нь хэрэгцээний газрыг үнэгүй

өмчлүүлэх нь тэднийг "газар" хэмээх үл хөдлөх эд хөрөнгийн шинэ нэгжтэй болгох эдийн засаг, хууль зүйн чухал ач холбогдолтой. Урьд нь малчдад малыг, иргэдэд орон сууцыг үнэгүй хувьчилж өгсөн нь үр дүнгээ өгч байгаа туршлага дээрээ үндэслэн газар өмчлөлийг шийдвэрлэсэн манай орны бас нэг онцлог болов.

Газар өмчлөлд хийсэн шинэчлэлийн өөр нэг чухал тал нь **өмчлүүлэх газрын байршлыг зөв сонгоход онцгой анхаарал тавьж** хуульчилсан явдал мөн. Өгүүлэн буй асуудлыг засаг захиргааны нэг нэгжийн нутаг дэвсгэрийн дотор хэрхэн сонгож тогтоох вэ? Хэрэв засаг захиргааны өөр нэгжийн нутаг дэвсгэрийг сонгох бол хэрхэн шийдвэрлэх вэ? гэсэн хоёр арга хэрэглэхээр хуульчлагджээ гэж үзэж болно. Үүнтэй холбоотойгоор газар өмчилж авах иргэний оршин суугаа засаг захиргааны харъяаллыг уг иргэний газар хэмээх өмчөө байршуулах нутаг дэвсгэрийг сонгон авах эрхтэй хутган ойлгож болохгүй.

Газрыг өмчлүүлж байгаа нь энэ гэж хэн хүний хүссэн, сонгосон газрыг өгөөд байж болохгүй нь ойлгомжтой. Газар бол экологи, эдийн засаг, улс төрийн ач холбогдлоороо бусад эд хөрөнгөтэй адил хандаж болдоггүй онцлогийг угаас өөртөө агуулан хадгалсаар ирсэн өвөрмөц материаллаг баялаг юм.

Ганцхан улс төрийнх нь ач холбогдлыг товчоор нэрлэх юм бол газар нь аливаа улс орны нутаг дэвсгэрийг бүрдүүлж, төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг батагтган харуулж, улс орны аюулгүй байдлыг хангаж хамгаалах нэг нөхцлийг бүрдүүлж өгдөг. Зөвхөн энэ утгаараа л гэхэд газрыг эзэмших, ашиглах, өмчлөх харилцааны эрх зүйн зохицуулалт төрийн бодлогын төвд ямагт байсаар ирсэн, байх ч ёстой нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим байдаг, түүнийг улс үндэстэн бүхэн сахиж хүндэтгэнэ. Тиймээс ч "Монгол Улсын хилийн доторхи бүх газар нь өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран газрын нэгдмэл сан мөн" гэж Газрын тухай хуулийн 9.1-д хуульчилжээ.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэхдээ уг газрын байршил нь тухайн иргэний оршин суугаа засаг захиргааны нэгжийн буюу өөр нэгжийн нутаг дэвсгэрийн аль алинд нь байж болохоор шийдвэрлэсэн нь зүйтэй юм. Энэ тухай "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-д тодорхойлжээ. Уг хуулийн 3 дугаар зүйлд:

- Нийслэлд бүртгэлтэй иргэн нийслэлд буюу аль ч аймаг, сумын газарт;
- Дархан, Эрдэнэт хотод бүртгэлтэй иргэн тухайн хотдоо буюу нийслэлээс бусад аль ч аймаг, сумын газарт;
- Дээрх 1, 2-т заснаас бусад иргэд нийслэл, Дархан, Эрдэнэтээс бусад аль ч аймаг, суманд газар өмчлөн авч болохоор заасан.

Хуулийн энэ заалт иргэний оршин суух газрын харьяаллыг хязгаарласан хэрэг биш, харин иргэний газар хэмээх өмч хаана байршиж болохыг улсынхаа нутаг дэвсгэрт нэлээд чөлөөтэй, өргөн хүрээнд байхыг зөвшөөрч хуульчилсан чухал арга хэмжээ болжээ. Ялангуяа бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, чөлөөт бүсийн өнөөгийн нөхцөлд иргэд "газар"-ын өмч, түүнээс салгавал эдийн засгийн болон зориулалтын ач холбогдлоо алддаг барилга байгууламж мэтийн үл хөдлөх эд хөрөнгөө илүү үр ашигтай зах зээлд илүү ойртуулан байршуулах хууль зүйн таатай боломж олгосон шинэчлэл гэж үзэж байна.

**Газрын шинэчлэлийн бас нэг онцлог нь уг өмчлөлд хамрагдах нийгмийн бүлэглээс үлдэж хоцрох ямар нэгэн бүлэглэл байхгүй гэж** үзэхээр байна. Баталгаа нь "Монгол улсын иргэн" гэж томъёологдсонд оршино. Холбогдох хууль тогтоомжид заасан журмаар иргэний хүчин төгөлдөр бичиг баримт бүхий Монгол Улсын харьяат, эрх зүйн бүрэн чадамжтай /18 насанд хүрсэн/, өрх айл толгойлсон нь албан ёсны бүртгэлтэй нөхцөлд гэр бүлээрээ газрын өмчийн эрх олж авах эрх зүйн бололцоо нээлттэй боллоо.

Өмчийн аль ч хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсад, төрийн албан хаагчид, оюутан, сурагч зэрэг суралцагсад, малчид, тариаланчид, ажилгүйчүүд гэх мэт нийгмийн ямар ч бүлэглэлд хамрагдаж байгаа иргэн гэр бүлээрээ хуульд заасан журмаар "газар" хэмээх үл хөдлөх эд хөрөнгөтэй байж болох эрх зүйн боломж шинээр хуульчлагдсан нь шинэчлэлийн нэг ололт гэж үзвэл зохино. 1992 оны Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 3-д: "**Иргэд** хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно" гэж заасан. Энэ нь мөн чанартаа улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалтай холбоотой төрийн бодлогоос үүдэлтэй.

Монгол оронд хийгдэж буй газар өмчлөлийн шинэчлэл цаашид улам боловсронгуй болж хөгжих нь эргэлзээгүй. Зөвхөн нэг зүйлийн хувьд даруй өөрчлөн шийдвэрлэвэл зохих асуудлыг хөндвөл:

Монгол Улсын иргэнд гэр бүлийнх нь хэрэгцээнд зориулан нэг удаа үнэ төлбөргүй газар өмчлүүлэх төрийн чухал бодлого, арга хэмжээг илүү өргөн хүртээлтэй болгох шаардлагатай байна. Тухайлбал, газрыг үнэ төлбөргүй өмчлүүлэх хугацааг хуульд 2005 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүртэл байхаар заасныг цааш сунгаж 2008 он болгохоор хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй. Газар өмчлүүлэх ажил хот, хөдөөд их удаашралтай байгаа, нөгөө талаас иргэд газар өмчлөх шинэ үйл ажиллагаанд туршлага, мэдлэг дутаж байгаа зэрэг бодит нөхцөл байдлыг зайлшгүй харгалзан үзэх ёстой.

Түүнчлэн залуу үеэ, залуу гэр бүлээ халамжлан анхаарч амьдрал ахуйд нь туслалцаа дэмжлэг үзүүлж, газар хэмээх үл хөдлөх хөрөнгийг эхлээд үнэ төлбөргүй олгох үүднээс хуульд бас өөрчлөлт оруулмаар байна. Жишээ нь, "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай" хуулийн 1 дүгээр зүйлд заасан "Гэр бүлийнхээ хэрэгцээнд нэг удаа үнэ төлбөргүй газар өмчилж авах Монгол Улсын иргэдийн гэр бүлийн бүртгэлийг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг баталсан өдрөөр тооцно" гэсэн хугацааг /энэ нь 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр/ сунгаж, тэрхүү гэр бүлийн бүртгэлийг наад зах нь 2008 оны 5 дугаар сарын 1-нийг хүртэлх өдрөөр тооцохоор өөрчилбөл залуучуудад ч, иргэнийхээ бүртгэлийг цэгцэлж чадаагүй иргэдэд ч илүү ач тустай болно. Ингэснээр газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлөн авах эрх эдлэх боломцоо хугацааны хувьд 3 жилээр сунгагдана.

Энэ мэтээр газрын өмчийн эрхийн шинэчлэлд янз бүрийн хязгаарлалтын арга саамыг аль болохоор арилгахаар гүнзгийрүүлэх нь улс орны эдийн засгийн хөгжил, хүн амын амьжиргааны өсөлтөд багагүй ач холбогдол үзүүлнэ.

# МОНГОЛЫН ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ ТҮҮХЭН ХӨГЖИЛ

*Философийн ухааны доктор, хууль зүйн шинжлэх ухааны доктор профессор Н.Лүндэндорж,*
*Хууль зүйн ухааны доктор Б.Баярсайхан*

Монголчуудын газрын эрх зүйн харилцааны онол-түүхийн эх сурвалжийг "газар-улсын үндэс" гэсэн төв азийн эртний өвөг улсуудын төрийн философитой холбон авч үзэх ёстой гэж бодож байна. Ийнхүү авч үзэж байгаагийн үндэс нь энэ философи манай үеийг хүртэл утга чанараа алдаагүй халгалагдан үлдэх байгаль түүхийн үндэстэйд оршино. Тэр үндэс нь азийн үндэстнүүд **оршин тогтнох арга болж байсанд** агуулагдмой.

Үндэстний оршин тогтнох аргыг агуулсан сургаал, номлол, философи өнө мөнхийн настай байх нь зүй ёсны хэрэг бөгөөд түүний утга чанарыг ухаарч ойлгох, уламжлан хөгжүүлэх, судалж шинжлэх, нарийвчлах асуудал нэн чухал юм. Энэ асуудал монголд хир зэрэг нарийн бодлого, технологитой явж байгаа тухайд судлаач бидний хувьд барьцтай хэлэх зүйл тун хомс байгааг нуумааргүй байна.

Тэгэхлээр, монголын газрын эрх зүйн харилцааны түүхэн хөгжлийн асуудал бол зөвхөн субьект, обьектын харилцааны зохицуулалтын хэм хэмжээний асуудлаар хязгаарлагдахгүй, монгол **үндэстний оршихуйн хөгжлийн** асуудал юм. Үндэстний оршин тогтнож ирсэн оюун соёлын дархлааг өдгөө зөв үнэлж, ойлгож, эдүүгээчилж, төрийн төв бодлого байлгаж чадвал төр улс бат бөх оршиж, хууль цаазын барилгын үндэс суурь зөв тавигдана гэж хэлж болно.

XIX зууны дунд үеэр олон улсын судлаачдын судалгааны эргэлтэд шинээр орж ирсэн "азийн үйлдвэрлэлийн арга" бол "газар-улсын үндэс" гэсэн өвөг монголчуудын төрийн философийг задлан шинжлэх, **монголын газрын эрх зүйн харилцааны** дотоод зүй тогтлыг тайлбарлах нэлээд үндэслэл бүхий үзэл баримтлал гэж бидний хувьд бодож байна.

К.Маркс тэргүүтэй сэтгэгчид, судлаачид ази дорно дахины улс орнуудын улс төр, эдийн засаг, эрх зүйн бүтцийг судлах явцдаа газрыг хувь

хүмүүст өмчлүүлдэггүй, төрийн үйлдвэрлэлийн арга зонхилсон өвөрмөц үйлдвэрлэлийн арга байгааг олж илрүүлсэн байна. Үүнийг азийн үйлдвэрлэлийн арга гэж нэрлэсэн билээ. Энэ үйлдвэрлэлийн аргын нэг гол онцлог-газрыг хувь хүмүүст өмчлүүлэхгүй, харин зөвхөн эзэмшүүлж, төр дээд өмчлөгч байдагт оршино[1]. К.Маркс энэ санаагаа улам тодруулж "Дорно дахины бүх үзэгдлийн үндэс-тэнд газрыг хувьд өмчлөх хэлбэр байгаагүйд оршино гэж Берьне үзэж байсан нь түмэн зөв. Энэ-дорно зүгийн тэнгэр огторгуйг танин мэдэх жинхэнэ тохирсон түлхүүр мөн"[2] гэж 1853 онд Ф.Энгельст бичсэн захидалдаа тэмдэглэсэн байна. Ф.Энгельс ч бас ийм үзэлтэй байсныг түүний К.Маркст бичсэн захидал нь нотолдог. Тэрхүү захидалдаа ази-дорно дахинд газар төрийн өмчлөлд байдгийн шалтгааныг газрын хөрсний бүтэц, онцлогоор тайлбарласан байдаг. Өөрөөр хэлбэл, бидний дээр тэмдэглэсэн газар төрийн өмчлөлд байх газар зүйн хүчин зүйлийг тодорхойлсон хэрэг юм. Үүнээс улбаалан азийн үйдвэрлэлийн аргын бусад онцлог тодордог. Газар нэгэнт төрийн өмчлөлд оршдог учраас бие даасан томоохон өмчтөн, газрын эзэд төрдөггүй, улмаар нийгэм ашиг сонирхолын ялгаралд орж, индивидуализм, аминч үзэл, бие даасан байдал, чөлөөт эрх үүсэж хөгжих боломцоог төрийн бат цул нэгдэл, хүчирхэг байдлыг хадгалах, хангах зорилгоор хязгаарлаж байдаг[3]. Энэ нь зөвхөн эрх баригчдын улс төрийн ашиг сонирхол, тогтсон ёс заншил төдий зүйл байгаагүй бололтой. Энэ нь дорно дахины иргэншил, соёл, түүнийг нөхцөлдүүлсэн газар зүйн хүчин зүйлтэй олон талаар холбоотой болохыг хожмын судалгаа мөн нотолж байгаа юм. Үүнийг газрын эрх зүйн харилцааны субъект, объект, агуулгад ч туссан байх нь зүй ёсны хэрэг юм.

Ази дорно дахины орнуудын газар нутаг өргөн уудам, мөн цөлөрхөг, үржил шим таруухан, ус дутагдалтайн улмаас хамтын хүчээр, төрийн оролцоотойгоор шийдвэрлэх асуудал олон байхаас гадна Плано Карпини ажиглаж тэмдэглэснээр Дунайн мөрнөөс алс наран мандах зүг хүртэл үргэлжлэх Скифи нутгийг эзэмшиж байсан монголчууд гэхэд л байнгын

[1] К. Маркс "Формы, предшествующие капиталистическому производству". С.15
[2] К.Маркс, Ф.Энгельс. Соч., Т.28, С.215
[3] Н.Лүндэндорж. "Төр, эрх зүйн сэтгэлгээний чиг хандлага" УБ., 2002, 261-262 дахь тал
[4] Н.Лүндэндорж. "Төр, эрх зүйн сэтгэлгээний чиг хандлага" УБ., 2002, 261-262 дахь тал

суурьшсан нутаг газар гэж байгаагүй, цаашдаа тэнд энд суурьшина гэдгийг мэддэггүй[4] байсан учраас ус ургамлын төлөөх тэмцэл, зөрчил ч мөн байнга гарч байсан байна. Байгалийн энэ нөхцөл байдал нь газар төрийн өмчлөлд байх нэг шалтгаан болж байсан мэт санагдана. Тийм учраас ази дорно дахинд өмчлөлийн агуулга хамтын хөдөлмөрийн үр дүнгээс хамаарч байсан учраас газар дахь төрийн өмчлөл нь төрийн эрх мэдлийн гол үүрэг, үзэгдэл гэж хэлж болохоор байна.

Газрын дээд өмчлөгч нь төр байдаг тогтолцоонд газрын эрх зүйн харилцааны субьект болох хүн ард нь багтаж буй нийгмийн бүлгийнхээ хүрээнд газрыг эзэмших, ашиглах, хамгаалах харилцааг л голчлон хөгжүүлж ирсэн байна.

Азийн үйлдвэрлэлийн аргын энэ онцлогоос хамаарч ази-дорно дахины орнуудад газрын эрх зүйн харилцаа европ дахин шиг хөгжөөгүй учраас түүнд тулгуурлан хөгждөг хүний эрхийн бусад институтууд ч аажим алгуур, хожим хөгжиж эхэлсэн билээ. Энэ л иргэншлийн хүрээнд монголчууд тэнгэр эцэг, газар эх хэмээх эрхэмийн дээд ёсыг дагаж, газар нутагтайгаа зөвхөн эзэмших, ашиглах харилцааг буй болгож, дээд өмчлөгчийг төр засаг хэмээн дээдэлж тийм байх ёстой хэмээн бодсоор өдий хүрчээ. Гэвч энэ урт түүх утга учиртай байсан нь эргэлзээгүй.

Тэгэхлээр, монголын газрын эрх зүйн харилцааны түүхэн хөгжилд газрыг хэн өмчилж байсан бэ гэдэг асуудал ихээхэн чухал байр суурь эзэлнэ. Үүнээс газрын эрх зүйн харилцааны шинж чанар, хөгжил шууд хамаарна. Тийм учраас газрын эрх зүйн харилцааны нэг чухал институт болох газар өмчлөлийн асуудал монголд хэрхэн байсныг монголын болон гадаадын судлаачид ихээхэн маргаж ирсэн юм. Тухайлбал, Академич Ч.Далай[5], Н.Ишжамц[6], Г.Сүхбаатар[7], Т.Сэнгэдорж[8], О.Амархүү[9], В.А.Рязановский[10] нарын эрдэмтэд монголд газрын хувийн өмчлөл байгаагүй гэдгийг тал бүрээр нотолдог юм. Харин Академич Ш.Нацагдорж, С.Жалан-Аажав, И.Дашням, Э.Авирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд нарын эрдэмтэд газрыг хувьд өмчилж

[5] Ч.Далай. "Их Монгол улс (1206-1260) дэд дэвтэр" УБ., 1994, 34-35 дахь тал.
[6] Н.Ишжамц. "Монголд нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь" УБ.,1974, 77 дахь тал
[7] Г.Сүхбаатар. Газар ба БНМАУ-ын тусгаар тогтнол "Ардын эрх" сонин, 1991, №11-7, №195.
[8] Т.Сэнгэдорж. "Газрыг харилцааны эрх зүйн зохицуулалт" УБ., 1997, 53 дахь тал.
[9] О.Амархүү. "Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил, хууль цааз" УБ., 2000, 59 дэх тал.
[10] В.А.Рязановский. "Великая Яса Чингис-хана". Харбин, 1933, С.66

байсан гэж зохиол бүтээлдээ дурьдсан нь бий. Феодалын газрын өмч, феодалуудын газар эзэмшин захирах явдал тодорхой он цаг, орон зайд үүсч хөгжсөн бөгөөд мал өмчлөх явдал үүсч, дараагаар нь феодалын газар өмчлөх ёсон тогтсон байна"[11] гэсэн эдгээр судлаачдын дүгнэлт хууль эрх зүй судлалын үүднээс төдийлөн нотлогдохгүй байгааг тэмдэглэж байна.

Мал, газар хоёр салгашгүй зүйл учраас нэг нь өмчлөгдөж, нөгөө нь өмчлөгдөхгүй байх нь ихээхэн ээдрээтэй үзэгдэл боловч газар өмчлөлийн сонгодог ойлголтын үүднээс болон газар-улсын үндэс гэдгээс эхтэй газрын дээд өмчлөгч нь төр гэсэн монголын нүүдэлчдийн төр ёсны ерөнхий үзлийн үүднээс монголчууд газрыг өмчилж байсан гэдгийг хууль зүйн хувьд гэрчлэх бололцоо хараахан байхгүй юм.

Одгоо монголын судлаачдын дунд газрыг зөвхөн төр өмчилж байсан гэдэг үзэл баримтлал илт давамгайлах болсон байна. Бид ч энэ тал дээр байгаа бөгөөд монголчууд түүхэндээ газар нутгийг иргэд өмчилдөггүй байсныг, нэгдүгээрт, төвөөс зугтах хүчийг сааруулж төрийн нэгдмэл байдлыг хадгалах түүхэн шаардлагатай, хоёрдугаарт, нүүдлийн мал аж ахуйн технологи нь газар нутгийг хувьд өмчлүүлэхийн эсрэг бодлого явуулахыг нөхцөлдүүлж байсан гэж үзэж байна. Нөгөө талаас хөрсний бүтэц, ургамлын даац ч нүүдэллэн амьдрахыг нөхцөлдүүлсэн нь лавтай.

Гэвч түүхийн явцад газар нутгийг хувь хүмүүст өмчлүүлэх явдал Чингис хааны насан өөд болохын өмнөөс эхэлсэн гэж зарим эх сурвалжид тэмдэглэсэн явдал бий. Чингис хаан таалал төгсөхийн өмнө төв монголын газар нутгийг өөрийн хөвгүүн Тулуйд, эзэлсэн бусад нутаг орныг бусад хөвгүүддээ хувь өмч болгон хуваан өгсөн тухай түүхийн баримт бий. Үүнээс өмнө монголчуудын түүхэнд ийм явдал гарч байгаагүйг төрийн их зөвлөх Елюй Чуцайгийн үг нотолдог. Тэрээр Чингис хааныг хөвгүүддээ газар нутгийг хуваан өмчлүүлэх шийдвэр гаргасанд ихэд харамсан газар нутгийг үе улируулан эзэмшүүлж болохоос биш, хувь өмч болгож яаж болох вэ? Ингэхлээр л яваандаа төвөөс тэмүүлэх хүчин давамгайлж, улс гүрэн задрахын үндэс тавигддаг юм хэмээн хоолой нь зангирч, нулимс дуслуулах

[11] Мөн ном. 31 дэх талаас үзнэ үү.
[12] Н.Ишжамц. "Улсын бага хурлын дарга, гишүүдэд бичсэн захидал" /Ерөнхийлөгчийн тамгын газрын архив. ХН-52, III боть. 246-247-р тал

хэлж байсан гэдэг[12]. Гэхдээ энэ нь хөвгүүдийнхээ хувьд өмчид биш улсад нь хуваан өгсөн хэрэг байж болох юм.

Харин Чингисийн төрд онцгой гавьяа байгуулсан хүмүүст газар нутгийг хувь өмч болгон өгч байгаагүй, харин эзэмшүүлэх онцгой эрх олгож[13] байсан бололтой. Хэрэв урьд өмнө газар нутгийг хувь өмч болгож өгч байсан бол Елюй Чуцай Чингис хааныг үр хүүхэддээ эсвэл улсад нь өмч болгон өгсөн үйлдэлд яахан харамсах билээ.

Монголчуудын хууль цаазын дурсгалуудад үл хөдлөх хөрөнгө, түүний гол обьект болох газрыг хувь хүнд өмчлүүлэх талаар ямар нэгэн заалт байхгүй байгаа нь газар нутгийн дээд эзэн нь төр байсны нотолгоо юм. Үл хөдлөх хөрөнгийг өмчлөхийн төлөө монголчууд төдийлөн чармайдаггүй байсан нь төрийн дээд өмчлөлийн зүйл гэж үзэхээс илүү нүүдлийн мал аж ахуйн тенологи нь тийм хэрэгцээ шаардлагыг ч бас нөхцөлдүүлээгүй байж болох юм. Ийм учраас монголын газрын эрх зүйн харилцааны түүхэн хөгжлийн ихэнхи үе уг харилцааны үндсэн обьект болох газрыг хувь хүмүүст өмчлүүлдэггүй тогтолцоонд хөгжиж ирсэн онцлогтой юм.

Монгол дахь газар эзэмших, ашиглах, хамгаалах харилцаа "газар-улсын үндэс", "төр-газрын дээд өмчлөгч" гэсэн ерөнхий зарчмын хүрээнд ***уламжлалт, социалист*** гэсэн хөгжлийн замыг туулж, өдгөө хөгжлийн ***шинэ үедээ*** орлоо гэж бид үзэж байна.

Энэ харилцаа уламжлалт үедээ гол төлөв тогтсон ёс заншил, сүсэг бишрэлд тулгуурласан заншлын хэм хэмжээнд үндэслэн газар, түүний баялгийг хайрлаж хамгаалахад чиглэж байсныг хууль цаазын түүхэн эх сурвалжуудын дурсгалууд харуулж байна.

Монголын хаад зарлиг гаргаж өөрийн нутаг, газрыг дархалж байсны зэрэгцээ газрын хөрс, бэлчээр, өвс ургамалыг гал болон зүй бус ашиглалтаас хамгаалахаас гадна эзэн суусан орны нутаг газрыг ч цэргийн агтны хөл, хөсгөөс хамгаалах талаар ихээхэн анхаарч байсан түүхэн баримт байгаа юм.

Тухайлбал, Хар татаарын хэргийн товчид зааснаар "Их засаг" хуулинд: "Бэлчээрийг эвдсэнийг хүндээр шийтгэнэ. Овс ногоорсон хойно газрыг нүхэлсэн ба гал алдаж бэлчээрийг шатаасныг нэгэн гэрийг алмой"

[13] Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан "Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал" УБ., 1997, 74-р тал

гэж заснаас харагдана. Гуулин улсын түүхээс олдсон "Их засаг" хуулийн олдворт: "Цэргийн захирагч хийгээд түшмэл түшээ нарын хатуу цаазлах зүйл болвоос харьяа цэргийн дарангуй суух хийгээд цэрэг хөдлөх, цэргийн агт өнгөрөн одох газар, хааны зарлигаар дархалсан газраас гадна шинээр дагасан нутаг газар малыг олноор хурааж иргэдийн газрын үр тариаг гишгүүлэн давтах буюу жимсний мод, ялам модыг идүүлэх..."-ийг цаазалж байсан байна.

Мөн "Усанд гараа дүрэхийг хориглож, ус хутгахын тулд ямар нэгэн сав суулга хэрэглэж байх"[14] /Макризын олсон хэсэг/ Их засаг хуулийн заалт, Английн түүхч Гарольд Лембийн Чингис хааны хуулинд "Цэргийн байлдааны бэлтгэлийг хангаж байхын тулд өвөл болгон их авыг хийж байвал зохино. Эл шалтгааны учир гуравдугаар сараас аравдугаар сарыг хүртэл буга, гөрөөс, туулай, хулан болон зарим төрлийн шувуудыг хэн бугай ч алж үл болно"[15] **/энэ заалт монголын хууль цаазын судалгаанд өмнө нь дурдагдаагүй шинэ мэдээ болно/** зэрэг нь байгалийн төрөл зүйл, ан амьтныг бусниулах, хороох нь байгалийн тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлнө гэхийг шууд илэрхийлэхээсээ өмнө ус бол ариун зүйл, үр төлтэй амьтныг агнах нь нүгэл, лус савдаг хилэгнэнэ гэсэн зан заншил, сүсэг бишрэлийн үүднээс зохицуулсан заншлын эрх зүйн хэм хэмжээ гэж үзэж болох юм.

Тэгэхлээр, энэ үеийн газрын эрх зүйн харилцааны агуулга нь байгалийн төрөл зүйлийг хүндэтгэл ёслол, бэлэгдэл, ёс заншил, сүсэг бишрэлийн үүднээс зөв эзэмших, ашиглах, хамгаалах, өмчлөл, эзэмшлийн гол обьект болох газар нутаг нь академич асан Ш.Нацагдорж гуайн судалснаар Чингис хааны үед урьд янз бүрийн овгийн мэдэлд байгаад монголын нэгдсэн төр байгуулсны дараагаар монголын эзэн хааны өмч болж хувирсан мянганы нутаг, хааны ургийн гишүүдэд хишиг болгож өгсөн харьяат газар, онцгой гавьяа үйл бүтээсэн шадар хүмүүст эзэмшүүлэхээр өгсөн шагналын[16] гэсэн гурван зүйл бүхий байсан бололтой.

Чингис хааны үед зарим хүнд газар нутаг дархлан олгох, "түшээ", "инж", "соёрхол" хэмээх газар нутаг шагнадаг байсан нь цаашид нутаг бэлчээр дэх газрын эрх зүйн харилцааны эзэмшлийн хэлбэрийг

---

[14] Рязановский В.А. "Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм". "Их засаг" хууль. /Орч. Ч.Баатар, Н.Лүндэндорж/ УБ., 2000. 71 дэх тал
[15] Гарольд Лемб. "Дэлхийн эзэн Чингис хаан" УБ., 2003. 167 дахь тал.
[16] Ш.Нацагдорж "Монголын феодализмын үндсэн замнал". УБ., 1978, 58 дахь тал

гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чухал түлхэц болсон мэт санагдана. Төрд гавьяа байгуулсан хүмүүст газар нутгийг **дархлан** соёрхлог бол өөрт түшиг тулгуур болсон шадар хүмүүст **"түшээ"** хэмээх газар нутгийг, Чингисийн удмын хүмүүст **"инж"** хэмээх газар нутгийг эзэмшүүлж байсныг монголын болон гадаадын олон эрдэмтэд судалсан байна. Энэ нь цаашид мал сүргээр баян чинээлэг нийгмийн дээд давхрааныхан нийтийн нутаг бэлчээрт өөрийн эзэмшлийг өргөтгөх, тэр нь яваандаа монголын нүүдэлчдийн дунд газрын эрх зүйн харилцаанд нийгмийн дээд давхрааныхны байр суурийг бэхжүүлэх үндэс болсон байна.

Ялангуяа Юан гүрний үед хаад, ноёд ан ав хийх газар нутгийг хууль зарлигаар тусгайлан заах, тэнд жирийн хүмүүс ан хийхийг хориглож байсан нь газар нутагтай нийгмийн давхрааны эрэмбээс хамаарч ялгавартай эзэмшиж ашиглах эхлэл тавигдсан байна. Энэ үеийн өөр нэг содон үзэгдэл монголын газрын харилцаанд суурин иргэншлийн нөлөөгөөр газар тариаланг албан хэлбэрээр эрхлэх болсон /1271он/ явдал юм. Үүний учир шалтгааныг академич агсан Ш.Нацагдорж гуай эдийн засгийн агуулгатай бус харин улс төрийн агуулгатай гэж үзсэн байна. Энэ тухай тэрээр: "Юан улсын хаад монгол газар албан тариа тариулах болсон учир нь гэвэл Аригбөх, Хайду, Наян зэрэг ноёд Хубилай, Олзийт хааныг эсэргүүцэн олон жил дараалан цэрэглэсэн учир монгол нутгийг тэдний гарт алдахгүйн тулд үлэмжхэн тооны хятад цэргийг ар газар дарангуй суулгаж, хятадын заншил ёсоор тайван цагт тэднээр албан тариа тариулан, хоол хүнсийг өөрсдөөр нь нийлүүлэх арга хэмжээ авч байсантай холбоотой юм"[17] гэжээ. Гэвч энэ нь ямар ч зорилготой байлаа гэсэн газрын эрх зүйн харилцааны цоо шинэ объект илэрсэн хэрэг. 1320-иод оны үед албан тариалангийн хэрэг эрхлэх яамыг монгол газар байгуулж байсан нь тариалан эрхлэх явдал улс төрийн зорилгоор хязгаарлагдахгүй болсон мэт санагдана. Юан улсын сударт тэмдэглэснээр 4648 өрх, 60 шахам мянган га газар[18] үр тариа тарьж байсны дотор монгол цэрэг, малчид[19] бас багтаж байжээ. Гэвч 1337 онд Тогоонтөмөр хаан зарлиг буулган хойд хязгаарын элст газар маш хүйтэн гэж Монгол газрын албан тариаг татан буулгажээ. [20]

[17] Ш.Нацагдорж "Монголын феодализмын үндсэн замнал". УБ., 1978, 115 дахь тал
[18] Юан улсын судрт 6400 хувиарь газар гэж тэмдэглэсэн, нэг хувиарь газар 9.2 га-тай тэнцэнэ.
[19] "Юан улсын судар" 100 болон 26-р дэвтэр
[20] "Юан улсын судар" 41-р дэвтэр

Тэгэхлээр, газар тариалан монгол нутагт эрхлэх явдал цэрэг улс төрийн агуулгаас хальж аж ахуйн хэлбэртэй болсон нь газар тариалангийн орны эрх зүйн соёл, харилцаа, зохицуулалт нэвтэрч байсан гэж үзэхэд зүй ёсоор хүргэж байгаа юм. Харин үүний нарийвчилсан судалгаа төдийлэн хийгдээгүй байна.

"Монгол-Ойрадын хууль"-иар ихэс дээдсэд зориулан ан ховрого хийх газар нутгийг хуулиар тусгайлан тогтоож, түүнийг бусдын эзэмшлээс хамгаалж байхаар заасан бол "Халх журам"-д тухайн үеийн нийгмийн дээд давхрааны төлөөлөгчид болох лам хувраг нарын нутаглах газар нутгийг ноёдын өргөө гэр барихаас бусад газар таалалаараа сонгож нутаглахыг хуульчлан хамгаалж өгч байсан нь[21] газар эзэмшлийн субъектүүдэд нийгэмд эзэлсэн байр суурь, удам угсаанаас хамааруулан ялгавартай хандаж байсны нотолгоо юм.

Өөрөөр хэлбэл, газрын харилцааны хэм хэмжээ дэх уламжлалт харилцааны хөгжлийн явцад газрыг улс өмчлөхийн зэрэгцээ эрх мэдэл, хөрөнгө чинээ, язгуур угсаа бүхий хүмүүсийн дунд газар эзэмшлийн харилцаа бүй болох нөхцөл болсон гэж үзэж болно. Гэвч нүүдэлчдийн хувьд газрын харилцаа, түүний эзэмшлийн хэрэгсэл болох талаас үнэлж эзэмшиж, ашиглах тухай сонгодог ойлголт төдийлэн тод илрэхгүй, харин малын бэлчээр болох талаас нь малтай хамт үнэлж ашигладаг онцлогтой. Үүний нарийвчилсан судалгааг академич агсан Ш.Нацагдорж нэлээд гүнзгий хийснийг дурьдаж, үл өгүүлсүй.

Газрын эрх зүйн харилцааны уламжлалт үе дэх нэг гол онцлог газрыг малын хөлийн тоо болон ихэс дээдсийн эрх ямба өсөх хэмжээгээр эзэмших, ашиглах хүрээ нь өргөжиж, үүнийг дагаж газрын алба гувчуурын харилцаа, эрх зүйн зохицуулалт нэлээд нарийсч, суурин иргэншилтэй газар тариалангийн орны нөлөөгөөр газар ашиглах, эзэмших шинэ хэлбэр бий болсонд оршино. Гэхдээ газрын алба гувчуур суурин орныхоос ялгаатай байв.

Нүүдэлчдэд газар үйлдвэрлэлийн шууд үндсэн хэрэгсэл байдаггүй учраас газрын шууд алба гувчуур байгаагүй, харин газрыг малаар дамжуулж ашигладаг онцлогтой тул бүр Өгэдэй хааны үеэс 100 толгой малаас татвар

[21] О.Амархүү. "Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил, хууль цааз" УБ., 2000, 39, 44-45 дахь тал

авах жишиг тогтсон байна. Малыг газраас салгаж нүүдэлчдийн бусад өмчлөлийн зүйлтэй адилтгавал тэдгээрээс бас татвар авах логик гарч ирнэ. Тэдгээрээс өгүүлэн буй үед алба гувчуур авдаггүй байсныг малаас цөөн эсвэл ач холбогдол багатай гэх мэтээр л тайлбарлахгүй бол газартай холбоотой болох нь аяндаа ойлгогдоно. Гэвч энэ үеийн эрх зүйг феодалын гэсэн тодоттол өгөх бололцоо хараахан алга байна.

Учир нь газар өмчлөлийн шинэ субьект болох хамжлага, эзэн гэгч нь хууль ёсоор оршиж байсан гэдгийг нотлох баримт байхгүй бөгөөд харин газрын жинхэнэ эзэн төр л хэвээр байсан гэдэг нь улам бүр нотлогдсоор байна.

Харин Манж-Чин улсын үеэс газрын эрх зүйн харилцаа нэлээд шинэ шинэ үзэгдэл, агуулгатай болов. Монголын газрын өмчлөлийн дээд субьект нь Манжийн хааны болон солигдож албан баримтад Монголын газар нутгийг "Эзний (Манжийн хааны) албан газар" гэж нэрлэх болов. Манжийн хаан засаг захиргааны өөрчлөлт хийж, засаг ноёдод хушууны нутгийг худалдах, түрээслэх, хагалбар тариа тарих эрхгүй байв. Улсын тусгаар тогтнол алдагдаж, газар өмчлөлийн дээд субьект өөрчлөгдсөн хэдий ч нүүдэлчдийн амьдралын онцлогоор газар нутгаа эзэмших явдлыг хэрэг дээрээ төдийлөн хүчтэй хөндөөгүй, харин ч тэдний бэлчээр нутаг эзэмших эрхийг Эзэн хааны өргөмжлөл зарлигаар хуульчлан бататгаж, газар эзэмшлийн харилцааны эрх зүйн агуулга гүнзгийрсэн гэж үзэж болохоор байна.

Засаг ноёныг "Нутгийн эзэн", "Нутгийн эзэн засаг ноён" гэх зэргээр албан хэрэгт бичих нь олонтаа байв. 1877 онд Сайн ноён аймгийн засаг Үржинжавын хушууны тамгын газраас чуулган даргын газарт илгээсэн бичигт "Нутгийн доторхи өвс усыг гагцхүү уул газар орны эзэн, харъяат засаг эрхлэн шийдэхээс өөр хүнд огт мэдэл чадалгүй" гэж дурьдсан нь засаг ноён харъяат хошууны нутаг дэвсгэрийг ганцаараа зонхилон байсны учир холбогдлыг илэрхийлсэн хэрэг.

Манж-Чин улсын үеийн хууль цаазад газрын харилцааны эрүүгийн хариуцлагын эрх зүйн хэм хэмжээг нэлээд ангилан төрөлжүүлж, нарийсгасан нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, эрүүгийн хариуцлагын эрх зүйн хэм хэмжээг,

1. Газар эдэлбэрийн тогтоосон хэм хэмжээ зөрчих;
2. Ой хээрийн түймрийг санаатай болон санамсаргүй тавих;

3. Хууль бусаар ан хийх;
4. Хориотой ургамал түүх гэж ангилан авч үзэж болох байна. "Цаазалсан газарт хулгаж ороод булга гөрөөлөн ...баригдвал мэдсээр илгээсэн ээзд засаг ба засаг бус ван, бэйл, бэйс, гүн, засгийн тайж, тавнангууд бол есөөд сарын пүнлүү тасал. Пүнлүүгүй тайж нар, хафанчууд, харц хүн бол гурваад есөн бод ав. Гөрөөлсөн хүний бие малыг цөм хушууны алба хэрэгт зүтгэсэн улсад шагнагтун. Гөрөөлж олсон юмыг албанд оруул"[22] гэжээ.

Монголын эртний хууль цаазад хулан, тахь, буга, согоо, бодон гахай, туулай зэрэг ан амьтан агнах зохицуулалт бий. Манж-Чин улсын үеэс энэхүү гэмт хэргийн субъектэд нь үйлдэгчийг оруулахаас гадна түүнийг илгээсэн ноёдод ял шийтгэл ногдуулахаар хуульчилсан нь эрх зүйн харилцааны агуулга нэлээд нарийссаныг харуулж байна. Гэвч газар түүний дагалдах бүх баялгийн эзэн нь Манж-Чин улсын хаан байсан нь эргэлзээгүй юм.

Богд хаант монгол улсын үед байгалийн бүх баялаг, газар улсын хөрөнгө гэдгийг "Монгол улсын хөрөнгийг захирах газрын дүрэмд" заасан нь өмчлөлийн субъект монголын төрд шилжсэнийг хуульчилсан хэрэг мөн. Эл үеийн газрын харилцаа уламжлалт шинжээ хадгалахын зэрэгцээ газар, түүний баялгийг хамгаалах талаар Манж-Чин улсын үеэс засаг ноёдод өргөн эрх олгож байсан уламжлалыг бататган гүнзгийрүүлж, нутгийн захиргааны байгууллагын эрх, үүргийг ихээхэн дээшлүүлсэн байна. Мөн газар, түүний баялгийг ашиглах, алба татвар, газар зохион байгуулалтын харилцааг эрх зүйн хэм хэмжээгээр журамлахад нэлээд нарийн дэглэм тогтоож байсан байна. Тухайлбал, ашигт малтмалын болон газрын хэвлийн харилцааг[23] зохицуулах анхны оролдлого хийж байсан байна. Монгол хүн гадаадынхантай нийлж хулгайн аргаар байгалийн баялаг ашиглах[24] явдлыг журамлах, гадаадын иргэн нутаг бэлчээр ашигласны хариуд газрын гааль төлөх[25], тарилан тарих болон хошуудын нутаг газрын хэмжээг зааж тэмдэг тавих, нэр зааж, зургаар гаргах[26] зэрэг харилцааг шинээр зохицуулж эхэлсэн байна. Мөн Богд хаант монгол улсын үеэс газар, түүний баялгийг ашиглах,

[22] (МЦБ. Тавдугаар дэвтэр. 7-р зүйл. Цаазалсан газарт хүн илгээж булга, орхоодойг түүх, гөрөөлөх нь)
[23] "Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг" УБ., 1995. 214 дэх тал
[24] мөн ном. 53-54 дэх тал
[25] мөн ном. 214 дэх тал
[26] Мөн ном. 61, 180 дахь тал

эзэмших, хамгаалах харилцаанд төрийн удирдлагын институтын хэлбэр нэлээд тод илрэх болсон нь газрын болон байгаль хамгаалах эрх зүй үүсч хөгжихэд чухал алхам болсон гэж үзэж болох юм.

Тэгэхлээр, монголчуудын газрын эрх зүйн харилцаа уламжлалт үедээ эрх зүйн харилцааны үндсэн субъект нь төр буюу төрийн байгууллага гэхээсээ илүү эзэн хаад, алтан ургийнхан, эрх олгогдсон язгууртнууд, иргэд, гадаадын иргэд байсан бол объект нь мянганы болон соёрхсон, түшээ нутаг, хаад ноёдын ан ховрог хийх газар хүрээ хийд ноёд лам хувраг нарын өргөө барих газар нутаг, дархан цаазат газар байсан бол агуулга эзэн хаанаас бусад субъектын тухайд газар нутагт эзэмших, ашиглах, хамгаалах эрх, үүргээр тодорхойлогдож байсан байна.

**Монголын газрын эрх зүйн харилцааны хөгжлийн социалист үе.** XX зууны хориод онд эхэлсэн бөгөөд төрийн эрх мэдлийн хэлбэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор газрын харилцааны үндсэн субъект болон газар эзэмших, ашиглах субъектүүдийн эрх зүйн байдал өөрчлөгдөж, тэгш эрхийн зарчмыг тунхагласан байна.

Олноо өргөгдсөний арван нэгдүгээр оны дөрвөн сарын 21 буюу Европын 1921 оны таван сарын 21-ний өдөр Монгол ард улсын хэмжээт цаазат ардын засгийн эрхлэх товчооны гишүүд хуралдаж, зөвлөлдөн тогтоосон 19-р хурлын тогтоолоор "Монгол ардын үндсэн хөрөнгө болох газрыг энгийн хүмүүст хувь хязгааргүй хэрэглүүлэх явдлыг устгавал зохино"[27] гэж заасан нь газар эзэмшлийн субъектүүдийн хооронд нийгмийн давхрааны шинж чанараас хамаарч ялгавартай байсныг нийгэм журамт ёсны үүднээс халах эхлэл байв. Энэ эхлэлийг анхдугаар үндсэн хуулиар "БНМАУ-ын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ой мод, ус ба мөн тэдгээрийн баялгууд бол эрт цагаас нааш ард нийтийн хөрөнгө байсаар ирсэн зан суртаал нь чухам одоогийн ард улсын ёсонд нийлэлцэх тул энэхүү хөрөнгө бүрнээ ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно"[28] гэж улам бататгасан байна.

1940, 1960 оны үндсэн хуулиар "бүх газар, түүний хөрсөн доорхи баялаг, ой мод, гол ус, тэдгээрийн баялаг... бүхэн бол улсын өмч, өөрөөр

[27] "БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхтгэл" УБ., 1972. 18-р тал
[28] БНМАУ-ын 1924 оны Анхдугаар Үндсэн хууль. Нэгдүгээр бүлэг. Гуравдугаар зүйлийн нэг / "БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхэтгэл" УБ., 1972, 119-р тал/
[29] БНМАУ-ын 1960 оны Үндсэн хууль. Хоёрдугаар бүлэг. Аравдугаар зүйл /"БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхэтгэл"., УБ 1972, 308-р тал/

хэлбэл бүх ард түмний хөрөнгө юм"[29] гэж газрын эрх зүйн харилцааны обьектыг нарийвчлан заахын зэрэгцээ өмчлөлийн үндсэн субъектийг тодорхойлсон байна. Эдгээр үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан иргэнд газар өмчлүүлэхээс бусад газар ашиглалтын, эзэмшлийн, удирдлагын, хамгаалалтын, процессийн зэрэг эрх зүйн харилцаа бүрэлдэн тогтож, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтын иж бүрэн тогтолцоо бүрэлдэн бий болсон нь газрын болон байгаль хамгаалах эрх зүйн салбар үүсэн хөгжих нөхцөл болсон байна.

Газрын эрх зүйн харилцааны социалист үеийн нэг гол онцлог-нийгэм журамт ёсны ерөнхий үзэл санааг агуулснаас гадна газар бэлчээрийг эдлэх тухай асуудал юм. Газар бэлчээрийг эдлэх тухай ойлголт анхдугаар үндсэн хуулинд анх тусгагдаж цаашид түгээмэл хэрэглэх болсон байна. Энэхүү "эдлэх" гэдэг ойлголтын агуулга эзэмших, ашиглах ойлголттой нийцэж байгаа эсэхийг эргэцүүлэхэд зарим талаар тэдгээрийн агуулгаас арай хязгаарлагдмал шинжтэй мэт санагдана. Тийм ч учраас эзэмших, ашиглахаас зааглан, эдэлж хэрэглэх гэсэн утгаар "эдлэх", "эдэлбэр" гэсэн арай наагуур нэр томьёо хэрэглэсэн байж болох юм. Үүний нэг нотолгоо нь энэ үед газрыг эзэмших, ашиглах эрхийн гол агуулга болсон удаан хугацааны гэрээ, түрээс, хүсэлт, дуудлага худалдаа, төсөл шалгаруулалт, давуу эрхээр олгож байгаагүй нь газар иргэний гүйлгээний объект болж хэрэг дээрээ чадаагүй юм. Мөн энэ үеийн өөр нэг онцлог-газрын эрх зүйн харилцааны үндсэн субъект хэн болох тухай асуудал юм. Удаа дараагийн Үндсэн хуулинд ард түмний хөрөнгө гэж тодорхойлсон хэдий ч төр, ард түмнийх хэрэг дээрээ байсан эсэх нь эргэлзээтэй тул уг асуудал мөн бүрхэг хэвээр үлдэж байгаа юм.

Монгол улсын газрын эрх зүйн харилцааны шинэ үеийг 1992 оны Үндсэн хууль эхлүүлсэн билээ. Үүний гол үзэл баримтлал нь хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн үндэс болсон үл хөдлөх хөрөнгө, түүний үндсэн объект газрыг өмчлөх эрхийг нээж өгч газар өмчлөлийн моно зарчмаас, плюрал зарчимд шилжсэн явдал мөн. Энэ нь өнгөц харахад иргэнд газар өмчлөх нэг эрхийг нээж өгсөн мэт боловч уг чанартаа 1924 оноос хойш тунхагласан хүний эрхийн заалтууд хэрэгжих үндэс суурь болсон юм.

Төр газар өмчлөлийн харилцааны нэг субъект байхын зэрэгцээ, түүний өмчлөх объектыг хуулиар хязгаарлан зааж өгсөн нь бусад субъектын эрхийг хамгаалахад чухал алхам болов. Мөн газар эзэмших, ашиглах

харилцааны эрх зүйн агуулгыг төгс утгаар нь нээж өгснөөр газар иргэний гүйлгээний объект боллоо. Харин иргэнд газар өмчлүүлэх эрх өмчлөх эрхийн агуулгын талаас нь авч үзвэл өмчилж байгаа эсэхэд нь эргэлзэхээр зүйлүүд цөөнгүй бий. Тухайлбал, иргэнд газар өмчлүүлэх тухай үндсэн хуулийн заалт газар өмчлөх тухай хуулиар өрх болж хувирсан, өрхөөр өмчилсөн газраа монгол улсын иргэнд захиран зарцуулж болох атлаа бусдад эзэмшүүлэх, ашиглуулахдаа өөрийн хүсэл зоригийг шууд хэрэгжүүлэх эрхгүй, төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах, гадаадын иргэнтэй гэр бүл болсон монгол улсын иргэн газар өмчлөх эрхгүй зэргийг дурьдаж болно. Газрын эрх зүйн харилцааны агуулга дахь эдгээр асуудал нь монгол улсын геополитикийн онцлогоос урган гарсан төрийн ашиг сонирхолтой холбоо бүхий бодлогын асуудал байж болох юм. Нөгөө талаас хууль зүйн техникийн болон бодлогын алдаа ч байж болох юм. Энэ мэтээс үүдсэн асуудал бэрхшээл байгаа хэдий ч шинэ үеийн газрын эрх зүйн харилцаа цаашид олон улсын жишгээр нарийсан хөгжих эхлэл бий болсон нь маргаангүй юм.

Монголд газрын харилцаа монгол үндэстэн бүрэлдэж, монгол төр ёсон тогтсон тэр цагаас төр газрын дээд өмчлөгч байх байгаль, нийгэм, оюун соёлын шалтгаантай байсны улмаас эрх зүйн харилцаа нь ч түүнийг тусгаж байсан нь маргаангүй. Өөрөөр хэлбэл, газрынхаа ахуйд үйлчилсэн эрх зүйн харилцаа байсан болов уу. Монголын зуун зууны хөгжлийн явцад энэ шалтгааныг хөгжлөөр саармагжуулах хэрэгцээг хүний эрх шаардсаныг дагаж хүнийхээ ахуйд үйлчилсэн газрын эрх зүйн харилцааг хөгжүүлж эхэллээ. Энэ чанартаа газраа дээдлэх үү, хүнээ дээдлэх үү гэсэн үг. Энэ шалгуураар газрын эрх зүйн харилцаа хаашаа явж байгааг харж болох болов уу гэж бодогдоно.

# БАГШ НАРЫН АЖЛЫН ЦАГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

*Отгонтэнгэр Их сургуулийн дэд захирал,*
*хуульзүйн шинжлэх ухааны доктор (Sc.D)*
*профессор Л. Баасан*

1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд тусгагдсан зохицуулалтаас үзэхэд хөдөлмөрийн болон бусад гэрээний дагуу өөр бусдын төлөө ажил, алба хашигчид хэн боловч хуулиар тогтоосон цагийг чанд баримтлан ажиллах, тэрхүү цагийг үр ашигтай ашиглах үүрэгтэй байна. Ажилтнуудын долоо хоног, хоногт үргэлжлэх ажлын цагийн хэмжээг Монгол улсын хөдөлмөрийн хуулиар хуульчилж зохицуулах бөгөөд харин ажлын цагийн горимыг хөдөлмөрийн тухай Монгол улсын хуулийн 18-р зүйлийн 1,3-т заасныар хамтын гэрээгээр, мөн хуулийн 21,25 дугаар зүйлд заасныар хөдөлмөрийн гэрээ, контрактаар зохицуулдаг байна.

Хөдөлмөрийн тухай Монгол улсын хуулийн 70-р зүйлд "7 хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна. Ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг байна" гэж заав. Энэ нь тодорхой хугацаанд үргэлжилбэл зохих ажлын цагийн дээд хязгаарыг тодорхойлсон зохицуулалт болно. Хуулиар тогтоосон энэхүү хэмжээ хязгаарт багтаан ажлын цагийн горимыг хэрхэн тогтоох вэ? гэдэг асуудал бол албан газар нэг бүрийн тухайд авч үзэхэд хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээгээр, харин ажилтан нэг бүрийн хувьд бол хөдөлмөрийн гэрээгээр зохицуулагдах асуудал мөн. Эдгээр нь албан газар нэг бүрийн ажил, алба эхлэх, завсарлах, ажил тарах гэх мэт өвөрмөц журмуудаар тодорхойлогдоно.

Зарим судалгаа хийж үзэхэд Нийслэл Улаанбаатар хотод үйлдвэрлэлийн чиглэлтэй аж ахуйн газруудын ажил өглөө $8^{00}$ цагт эхэлж, орой $17^{00}$ цагт дуусах, ерөнхий боловсролын сургуулиудын өдрийн ээлжийн хичээл $8^{00}$ цагт эхэлж, $14^{00}$ цагт дуусгавар болох, Их сургууль, коллежийн хичээл өдрийн ээлжинд $8^{00}$, $8^{30}$, $9^{00}$ цагт, төрийн байгууллагууд /олон яамд, хууль хамгаалах байгууллагууд/-ын ажил 9 цагт эхлэх гэх мэтийн өвөрмөц журам

бий. Эдгээр нь аж ахуйн нэгж тус бүрийн ажлын онцлог, хөдөлмөрийн дотоод журмын зохицуулалттай холбоотой байна. Ажлын цагийн горимоос шууд шалтгаалан албан газрын сахилга, дэг журам үйлдвэрлэлийн үр ашигт чанарын асуудал зохицуулагдана. Улс, нийгмийн тухайн байгууллагын, хувь хүний эрх ашгийг хослуулсан шинжтэй горим нь албан газар, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх механизм болдог байна. Нэгэн жишээ дурдахад:

ШУА-ийн харъяа зарим хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд долоо хоногийн ажлын өдрийн 2 өдөрт нь өөрийн хүрээлэнд заавал ажиллах бусад цагт нь тусгайлсан графикаар ажиллах ажлын цагийн горим мөрддөг нь шинжилгээ, судалгааны ажилд тохирсон шинжтэй байна. Зүй нь ажил олгогч бүхэн энэ мэт зохистой горимыг мөрдөх шаардлагатай.

2. Хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтнуудын дотроос бүх шатны сургуульд ажиллагсад, нэн ялангуя багш нарын ажлын цаг ямар горимтой байх вэ? Тэдний ажлын цагийг яаж зохицуулах вэ? гэх мэтийн асуудал эрхзүйн нэгдсэн зохицуулалтгүй, маргаантай явж ирсэн байна. Үүнтэй холбоотойгоор их сургууль, коллеж, ерөнхий боловсролын болон бусад сургуульд тохиолдох санал үл зохицох асуудлууд нь

I. Захиргааны зүгээс бүх багш нар, нийт ажиллагсдын нэгэн адил өглөө 8,9 цагт ажилдаа ирж, орой 17$^{оо}$, 18$^{оо}$ цагт ажлаас тарах ёстой гэсэн шаардлага тавих, багшийн ажлын цагийг энэ мэтээр бүртгэж, хариуцлага тооцох;

II. Багш нар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил хожимдсон, тасалсан үед нийт ажиллагсдын нэгэн адил ажилласан цаг, өдрөөр нь тооцоолон хөдөлмөрийн хөлсийг хасах, ажил тасалсан, ажил хожимдсон багш нараас ажил тасалсан хоног, цагаар тооцоолон ээлжийн амралтыг хасах;

III. Хичээл тасалсан, ажил хожимдсон багш нар хичээлийн жилийн эцэст заавал зохих цагийг биелүүлсэн, түүгээр үл барам давуулан биелүүлсэн нөхцөлд ээлжийн амралт, шагналыг бүрэн олгох эсэх;

IY. Багш нар хичээлийн бусад цаг үед сул чөлөөтэй байх ёсгүй, сургуулиас зохиогдох ажилд захиргааны ажилтнуудын нэгэн адил оролцох ёстой гэдэг шаардлага тавих;

Y. Багш нар бол нормчилсон даалгавар бүхий ажилтан тул зөвхөн хичээлийн хуваарийн дагуу ажиллах бөгөөд хичээлийн жилд заавал зохих

цагийг нэгэнт биелүүлсэн бол хичээлийн жилийн бусад хугацаанд ажиллахгүй, харин хөдөлмөрийн хөлс цалингаа бүрэн авах тухай хүсэлт гаргах;

YI. Багш нар захиргааны ажилтнуудын нэгэн адил хуульд заасан цагийг баримтлан ажилласан боловч заавал зохих нормт цагийг хичээлийн жилийн эцэст биелүүлээгүй бол ээлжийн амралт төдийгүй кредит цагийг биелүүлээгүй цагаар тооцоолон хөдөлмөрийн хөлс хасах, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг хорогдуулан тооцоолох;

YII. Багш нарт ээлжийн үндсэн амралтыг Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд зааснаар олгох, Боловсролын хуульд буй зохицуулалтыг үүнд хамааруулахгүй байх;

YIII. Илүү цагаар хичээл заасан багшийн хөлсийг багш нарын амралт олговол зохих дундажид оруулан тооцохгүй гэх мэт болно. Эдгээр асуудлууд бол багш нарын ажил, үүргийн онцлог, тэрхүү ажил, үүргийг биелүүлбэл зохих нөхцөл, цаг хугацаа, багш нарын ажлын цагийн бүртгэл, тооцоо хийх журам, ажлын цагийн ашиглалтын журамтай холбоотой.

Боловсролын хуульд зааснаас үзэхэд багшийн ажил нь:

А. Сургалтын

Б. Хүмүүжлийн

В. Эрдэм шинжилгээ, судалгааны гэх мэт үндсэн агуулгаар тодорхойлогдохын сацуу багш нар хичээлийн жилд эсхүл тодорхой хугацаанд биелүүлбэл зохих сургалтын норм хэмжээг баримтлана. Өөрөөр хэлбэл багш нарын сургалтанд оролцох ажил нь Их сургууль, коллеж, бусад шатны сургуулиудад хичээл заах цагаар нормчлогдсон байна. Жишээ нь:

Их сургуулиудад багш нарын хичээлийн жилд гүйцэтгэх цагийг 20-24 кредитээр, ерөнхий боловсролын сургуульд долоо хоногт 20-28 цагийн хичээл заах норм тогтоох зохицуулалт бий. Энэ бол багшийн гүйцэтгэх ажил нь нормчлогдсон, хичээлийн жил дутамд дүгнэгдэж тооцоологдох үзүүлэлт болно. Энэ мэт үзүүлэлт бол хичээлийн жил, улирал бүрээр тооцоологдох ба харин багшийн өдөр тутмын ажлыг дүгнэх үйл ажиллагаатай шууд холбоогүй, түүнтэй холбох нэгдсэн механизм одоогоор байхгүй байна. Үүний улмаас багшлах ажилтнуудын ажлын цагийг конторын албан хаагчдын нэгэн адил бүртгэн дүгнэх хандлага гардаг ажээ.

Багш нар конторын албан хаагчид шиг ажлын цагийг чанд баримтлан сургууль дээр ажиллах нь багшийн хувьд ямар үр өгөөжтэй байх вэ? гэдэг

нь маргаантай байна. Багш хүн сургууль дээр дэмий сууж байхын оронд боломж бүхий орчинд зохих судалгаа хийх, эх сурвалжууд судлах, эрдэмтэдтэй уулзаж зөвлөгөө авах, сурах бичиг, гарын авлага бичих, диссертац бичих, эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөх, боловсролоо дээшлүүлэх, хариуцсан ангитайгаа ажиллах нь хувь хүнд төдийгүй улс нийгэмд үр нөлөөтэй байдгийг олон туршлагаар тодорхойлж болно.

Багш нарын ажлын цагийн ашиглалтыг тэдний ажиллах сургууль, хамт олны эрх ашиг, хувь хүний сонирхол, багш нарын хөдөлмөрийн эцсийн үр дүнтэй холбон зохицуулах шаардлагатай боловч тус улсад багш нарын ажлын цагийг эхлэх, завсарлах, бүртгэх хариуцлага тооцоолох асуудлыг нэгдсэн хуулиар, эсхүл Боловсролын яамнаас гаргасан журмаар тохируулан зохицуулах боломжгүй. Учир нь сургууль болгон өөр өөрийн онцлогтой сургалт явуулдаг, хичээллэх нөхцөл тус тусын онцлогтой байдагт оршино.

3. Багш нарын ажлын цагийг сургууль, багш аль алинд нь үр ашигтай ашиглахад дараахь механизмуудыг хэрэглэх нь чухал байна.

I. Сургууль бүрийн хөдөлмөрийн дотоод журамд

а. Захиргааны ажилтнуудын ажлын цагийн ашиглалтын журам;

б. Багш нарын цаг ашиглалт, хариуцлагын тогтолцоог нэг бүрчлэн зохицуулах шаардлагатай.

Дотоод журмаар багш нарын ажлын цагийг жижүүр бүртгэх албагүй, харин хичээлийн диспетчер, тэнхимд тооцоолох, сар бүхэнд тэдний цалинг олгохдоо өдөр тутам ажилласан цагаар биш сар бүрт заасан цаг /тооцооны хуудас/ сургууль, тэнхимийн хуваарьт ажлын биелэлтээр нь тооцоолдог байх нь чухал.

II. Багш нарын ажлыг тохируулах механизм сургуулийн болон тэнхимийн хуваарь мөн.

Төрийн өмчинд үндэслэх МУИС, ХААИС, ТИС, УБИС зэрэг олонхи сургуулиудад

А. Сургуулийн

Б. Факультетийн

В. Тэнхимийн хуваарь үйлчлэх бөгөөд энэхүү хуваарьт багш тус бүрийн хичээл заах өдөр, цаг, ангитай ажиллах, олон нийтийн ажилд оролцох цаг, номын санд суух цаг, тэнхимд суух цаг, сургуулийн захиргаанаас зохиогдох ажилд оролцох цаг, бие даалтын цаг зэргийг багтаах бөгөөд энэхүү

хуваарь  нь багш тус бүрийн эрх ашгийг илэрхийлэн хангахын сацуу багш нарын оролцоотойгоор сургууль даяар явагдах ажлыг зохицуулах зэрэг бүх талын ач холбогдолтой байна. Энэхүү хуваарь тэнхим  тус бүрээр гарахын сацуу  факультетийн хэмжээнд онцгой тохиолдолд сургууль тус бүрээр баталж мөрдөгддөг байх нь чухал байна.

Энэхүү хуваарийг  тэнхим, факультет бүр хичээлийн улирлын эхэнд баталж  мөрдөх бөгөөд түүний ач холбогдол нь

1. Багш нарын сургалт, хүмүүжил, эрдэм шинжилгээний зэрэг бүх ажлыг нэгдмэлээр тохируулж зохицуулах ач холбогдолтой. Ингэснээр багш нарын гүйцэтгэвэл зохих ажлыг  нэгдмэлээр зохицуулах нөхцлийг бүрдүүлэхийн сацуу багшлах ажилтнуудын чөлөөт цагийг ашиглан эрдэм шинжилгээ  судалгааны болон бусад үйл ажиллагааг зохион байгуулах боломжийг буй болгоно.

2.Багш нарын бие даасан байдал, чөлөөт цаг, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх.цаг хугацаа, боломцоог нэмэгдүүлнэ.

Багшийн ажлын хуваарьт бие даалтын өдөр заавал байх  нь чухал бөгөөд багш энэ өдрүүдэд эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх өөрийн эрэлт хэрэгцээт ажлыг биелүүлэх боломцоог буй болгох гэх мэт нөхцлүүдийг тусгадаг байна. Ингэснээр багш нарын хөдөлмөрийн бүтээлч, үр өгөөжит  чанарыг нэмэгдүүлнэ. Үүнийг багш нарын туурвин бичсэн эрдэм шинжилгээний бүтээл, докторант, магистрант удирдсан, эрдэмтдийг бэлтгэсэн оюутнуудад эрдэм шинжилгээний ажлын дадлага олгосон гэх мэт үйл ажиллагаануудаар тодорхойлж болно. Багш нарын ажлын энэхүү бүтээлч, үр өгөөжит чанарыг дагалдан сургууль тус бүрийн үйл ажиллагааны цар хүрээ, боловсролын салбарт эзлэх байр суурь  тодорхойлогддог байна. Үүнийг МУИС, ТИС, УБИС-ийн үйл ажиллагаагаар тодорхойлж  болно.

В.  Багш нарын ажлын хуваарь нь багш нартай хариуцлага тооцох сахилгын шийтгэл оногдуулах асуудлыг зохицуулах нөхцлийг бүрдүүлдэг. Өөрөөр хэлбэл хуваарьт заасан ажлыг хангаж биелүүлээгүй багш нар бол тухайн хуваарьт өдөр, долоо хоногийн ажилд оролцоогүй тул ажил тасалсан гэж үзэж тухайн хугацаанд оногдох хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл хөлс авах эрх аяндаа хасагдана. Багш нарын хичээллэх, олон нийтийн ажилд оролцох болон бие даан ажиллах зэрэг ажлуудын хуваарь бол багшийн ажлын онцлогтой холбоотой төдийгүй бүх шатны сургуулиудаас багш нарын ажлыг зохицуулах

хөшүүрэг болдог байна. Энэ механизмыг ашиглан Их, Дээд болон бусад сургуулиуд багш нарынхаа ажил, амралтын цагийг зохицуулах нь чухал.

Сургууль тус бүрийн хөдөлмөрийн дотоод журам, дүрэмд багш нар сургууль тэнхимээс гаргасан хуваарийг чанд баримтлаагүй тохиолдолд хариуцлага тооцох, хуваарийн дагуу багш нар тодорхой үүрэг хүлээх /бие даан ажилласан ажлынхаа тайлан гаргах гэх мэт/ асуудлыг тусгах шаардлагатай байна.

Тэнхим, сургуулиас багшийн үйл ажиллагаанд тавих хяналтыг нэмэгдүүлэх, тэнхим, факультетийн, олон нийтийн эрдэм шинжилгээний ажлын өдөртэй болж, уг өдрийг хатуу баримтлан ажил зохион байгуулах үндэслэл нь багш нарын ажлын хуваарь мөн.

Элгээр ажлуудыг давхцуулахгүйгээр зохицуулахад багшийн ажлын хуваарь ач холбогдолтой байна. МУИС болон зарим их сургууль даваа гаригийг ректорат, деканат, тэнхимийн өдөр болгон хурал ярилцлага, семинар зохион байгуулах ажлыг гүйцэтгэдэг байна.

III. Багш нарын ажлын / сургалт, эрдэм шинжилгээний ажил, олон нийтийн / үзүүлэлтүүдийг хичээлийн жил, хагас жил, улирал тутамд дүгнэдэг тооцооны систем бий болгох шаардлагатай.

Өнөө үед багш нарын ажлын гүйцэтгэлийг заасан цагаар нь тооцооны хуудас хөтөлж хичээлийн жилийн эцэст тооцоолох журам бий. Энэ нь өрөөсгөл талтай тул багшийн ажлын тооцооны дэвтэртэй болж багш нараас сар бүрт заасан цаг, эрдэм шинжилгээний ажилд оролцсон, сургалтанд оролцсон, олон нийтийн сонгуульт ажил гүйцэтгэсэн гэх мэт ажил нэг бүрийг тооцоолох журамд шилжих шаардлагатай. Энэ нь багш тус бүрийн ажилд тооцоо нэвтрээд зогсохгүй хичээлийн жил, улирал бүрт жигд ачаалалтай байх, илүү цагаар ажиллах, илүү цагийн хөлс олгох, багш нарын ажлыг хичээлийн жил, улиралд багтаан нэгтгэн шилжүүлэх /жилд заах хичээлийг хичээлийн жилийн аль нэг хэсэгт шилжүүлж бусад хугацаанд хөдөлмөрийн хөлсийг бүрэн олгож, сургалтаас бусад ажиллагаанд оролцох боломжоор хангах/, багш нарт уртасгасан амралтыг бүрэн олгох, эсхүл бүрэн амралт олгох үндэслэлгүй бол өөр ажил гүйцэтгүүлэх зэрэг зохион байгуулалтын үйл ажиллагааг хангах ач холбогдолтой байна. Багш нарын ажилд тооцооны чанд журам нэвтрүүлснээр захиргааны хяналтыг нэмэгдүүлэхийн сацуу сургалтын ажилд оролцогсдын сахилгыг бэхжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

# НЭР ТӨР, АЛДАР ХҮНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

*Шихихутуг ХЗДС-ийн багш, Хууль зүйн ухааны магистр Ц. Цэлмэг*

Миний нэр төрд халдлаа, ажил хэргийн нэр хүндийг сэвтээлээ, намайг гүтгэн доромжиллоо гэсэн үгс өнөөдөр хүн бүрийн амнаас дуулдах болжээ. Энд дурдагдаад байгаа нэр төр, алдар хүнд гэж юу болох, тэдгээрийг хууль тогтоомжоор хэрхэн хамгаалдаг, бусдын нэр төр, алдар хүндэд халдсан этгээдэд ямар хариуцлага хүлээлгэдэг болох, эрх нь зөрчигдсөн этгээд ямар эрх үүрэгтэй болон холбогдох хууль тогтоомжийн заалтыг боловсронгуй болгох талаар өөрийн бодлоо та бүхэнтэй хуваалцаж байна. Бид нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гэж бүхэлд нь ярьдагаас бус тэр бүр тусад нь авч үздэггүй.

**<u>Нэр төр</u>** гэж хүн бүрд байгалиас заясан нийгэм, ёс суртахуун, эрх зүйн шинжийг агуулсан заяамал шинж, хүн төрөхөөс үхэх хүртлээ өөртөө өгсөн үнэлгээ юм. Харин **<u>алдар хүнд</u>** нь тухайн хүний авьяас чадвар, ур ухаан, хөдөлмөрийнхөө үр дүнд амжилт гаргасаныг нийгэм, хамт олон, төрийн зүгээс үнэлж олгосон үүсмэл шинжтэй үнэлгээ, итгэл найдвар байдаг. Нэр төр нь хувь хүний салшгүй хэсэг бөгөөд нэр төрийг гутаах, алдар хүндийг бууруулах гэж ярьдаг.

Ажил хэргийн нэр хүнд нь иргэн ба хуулийн этгээд нийгэмд оршин тогтнож үйл ажиллагаагаа явуулахдаа бүтээлч хөдөлмөрөөрөө тухайн нийгмийг цогцлон хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж хамт олон, нийгэм, иргэд, төрийн зүгээс өгч буй үнэлэмж юм.

Алив хүн өөрийн хүч хөдөлмөр, авьяас билгээ ажил мэргэжилдээ бүрэн зориулсан нь тухайн хүний нэр төр, алдар хүндийг бусдад нээн харуулдагаараа ажил хэргийн нэр хүнд илэрдэг учир нэр төр, алдар хүндэд тулгуурлан сүүлд гарч ирдэг ойлголт юм. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан тохиолдолд түүнийг хамгаалах хэд хэдэн төрлийн арга, хэрэгсэл байдаг. Үүнд :

1. **Шүүхийн бус хамгаалалт**. Хууль бусаар хүний нэр төр, алдар хүндэд халдсан тохиолдолд талууд харилцан тохирч асуудлыг хуулийн байгууллага, шүүхэд хандалгүйгээр шийдвэрлэх хувилбар. Энэ тохиолдолд харилцан зохицох, буруутай тал нь уучлал гуйх, сонин хэвлэлээр залруулга, няцаалт өгөх зэрэг хэлбэрээр хохирсон тал нь нэр төр, алдар хүндээ сэргээлгэнэ.
2. **Иргэний журмаар шийдвэрлэх**. Нэр төр, алдар хүнд нь гутаагдсан гэж үзсэн этгээд шүүхэд иргэний журмаар нэхэмжлэл гаргаж хэргээ шүүхээр шийдвэрлүүлнэ. Энэ тохиолдолд буруутай этгээдэд эд хөрөнгийн хариуцлага оногдуулж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ.
3. **Эрүүгийн журмаар шийдвэрлэх**. Бусдын нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж гүтгэж, доромжилсон нь эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй бол гэмт хэрэг гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Дээрх гурван хамгаалалтын алийг сонгох нь тухайн хувь хүний эрх боловч асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх үндэслэл нь нэр төр, алдар хүнд нь гутаагдаж, эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн байх явдал юм.

Дэлхийн улс орнуудын эрүүгийн хууль тогтоомжид энэ талаар хэрхэн тусгагдсан байдлыг судлаж үзэхэд 3 бүлэгт хувааж болохоор байна.

1. Хүний нэр төр, алдар хүндийг эрүүгийн болон иргэний хуулиар хамгаалдаг улсууд. Энэ ангилалд ихэвчлэн тоталитар дэглэмтэй байсан улсууд болох ОХУ, Украйн, Беларусь зэрэг ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсууд, БНХАУ, БНАСАУ, Куба, Вьетнам зэргийг хамааруулж болно. Эдгээр оронд хувь хүн өөрийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжиллоо, гүтгэгдлээ гэж үзвэл эрүүгийн болон иргэний журмын алинаар хандахаа өөрөө шийдвэрлэнэ.
2. Зөвхөн хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан гүтгэхээс бусад үйлдлийг гэмт хэрэгт тооцдоггүй улсууд. Энэ ангилалд Европын холбооны улсууд буюу Эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудыг хамааруулж болно.
3. Нэр төр, алдар хүндийг Эрүүгийн хуулиар хамгаалдаггүй, иргэний шүүхээр асуудлыг шийдвэрлэдэг улсууд. АНУ, Их Британи,

тэдгээрийн колони байсан буюу Англо-Саксоны эрх зүйн системтэй орнуудыг энэ ангилалд хамааруулж болох юм.

Манай улсын хувьд эхний ангилалд буюу Эрүүгийн хуулиар хүний нэр төр, алдар хүндийг хамгаалдаг улсуудын тоонд хамаардаг. Одоо Монгол улсад хүний нэр төр, алдар хүндийн асуудлыг хэрхэн хамгаалж ирсэн үндэсний хууль тогтоомжийн түүхэн хөгжлийн талаар товч өгүүлье.

Анх 1926 оны шүүх цаазын бичгийн 123-р зүйлд ...аливаа хүн цуу үг тарааж, олны санааг үймүүлбээс 3 сар хүртэл хорино гэсэн бол 1929 оны шүүх цаазын бичгийн 74-р зүйлд ...бусдыг аливаа хэрэгт холбогдуулж яллуулахыг хичээж албаны газар худал хуурмагаар гүтгэн мэдүүлсэн, баримт болох зүйлийг хуурамчаар үйлдсэн бол 2 жил хүртэл хоривоос зохино. 1934 оны шүүх цаазын бичгийн 137-р зүйлд ...Алив хүнийг ам, бичгээр доромжилсон бол 150 төгрөгөөр торгоно, 138-р зүйлд ...бусдын нэр алдрыг гутаах худал мэдээг зориуд цуурхан тараасан бол 300 төгрөгөөр торгоно. 1942 оны болон 1961 оны эрүүгийн хуульд дээрх заалт өөрчлөгдөөгүй явсаар 1986 оны шинэчлэн найруулсан хуулийн 117-р зүйлд ...бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан илт худал гүжирдлэг тараасан бол 1 жил хүртэл хугацаагаар хорино, гүтгэлгийг хэвлэлд нийтлэх, бусад аргаар олшруулан тараасан, гүтгэх гэмт хэрэгт урьд нь ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол ялыг хүндрүүлнэ, 118-р зүйлд ... бусдын нэр төр, алдар хүндийг амаар, бичгээр, бусад хэлбэрээр зориуд доромжилсон бол ял шийтгэнэ гэжээ.

2002 оны шинэ эрүүгийн хуулийн 110-р зүйлд...бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр доромжилсон бол торгох болон 1-3 сар баривчлах ял шийтгэнэ. Мөн хуулийн 111-р зүйлд...хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол торгох, 1-3 сар хүртэл баривчлана, гүтгэлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан, доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн, хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэсэнээс хүнд хор уршиг учруулсан бол ялыг хүндрүүлэхээр заажээ.

Тэгвэл Монгол Улсын Иргэний хуульд энэ талаар хэрхэн зохицуулж байсан талаар сонирхоё. 1963 оны Иргэний хуулийн 6-р зүйлд...Иргэн буюу албан байгууллагын нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотлож чадахгүй бол уул мэдээг няцаахыг дээрх

иргэн, байгууллага шүүхэд шаардах эрхтэй. 1994 оны иргэний хуулийн 7-р зүйлд...Иргэн хуулийн этгээд өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаагдсан гэж үзвэл уг мэдээг няцаалгах, ийнхүү гутаагдсанаас учирсан гэм хорыг арилгуулахыг шаардах эрхтэй.

2002 оны иргэний хуулийн 21-р зүйлд...иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ. 497-р зүйлд...бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.

Мөн хуулийн 511-р зүйлд...бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотлож чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ. Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтооно гэжээ.

Нэр төр, алдар хүндийг гутаалаа гэсэн иргэний нэхэмжлэлтэй хэрэг Монгол улсын хэмжээнд 1995-1997 онд 69 гарч шүүхээр шийдвэрлэгдэж байсан бол 1998-1999 онд 140 иргэний хэрэг шүүхээр шийдэгджээ. 2000-2002 онд зөвхөн нийслэлд гэхэд л 83 хүн нэр төр, алдар хүнд, ажил төрлийн нэр хүндээ сэргээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаж байсан ба энэ төрлийн хэргийн тоо цаашид байнга өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Нэр төр, алдар хүндээ сэргээлгэхээр нэхэмжлэгчид дунджаар 5-30 сая төгрөг, дээд хэмжээ нь 450 сая төгрөг нэхэмжилсэн ба шүүх нэхэмжлэгчдийн эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг дунджаар 200,0-500,0 мян. төгрөгөөр тооцож нэхэмжлэлийг хангахаар шийдвэрлэжээ. Шүүхэд нэр төрөө сэргээлгэхээр хандсан нэхэмжлэлийн ихэнхи нь хангагддаг, эдийн бус хохирлыг мөнгөөр тооцож олгохоор шийдвэрлэдэг тул зарим хүмүүс мөнгө олох зорилгоор үндэслэлтэй, үндэслэлгүй нэхэмжлэл гаргах явдал өсөх төлөвтэй байна.

Нэр төр гутаасан, алдар хүнд буурсаны улмаас учирсан хохирлыг төлүүлэх тохиолдолд бодит тооцоо гаргах боломжгүй шахам бөгөөд хохирогч

этгээд өөрөө ямар хэмжээгээр, яаж хохирсоноо нотлох хэрэгтэй болдог. Нэхэмжлэгчийн шаардсан мөнгөний хэмжээ шүүхийн тогтоосон хэмжээнээс ямагт өндөр байдаг ба эдийн бус хохирлыг тооцох тусгай арга зүйн зөвлөмжүүд шаардлагатай нь харагдаж байна.

Нэр төр, алдар хүндэд халдаж гүтгэсэн, доромжилсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх ба гүтгэх, доромжлох хэрэг нь обьектив талаараа ялгаатай бөгөөд гүтгэх гэмт хэргийн бүрэлдэхүүн нь илт худал мэдээлэл тарааж хүний нэр, алдрыг гутаасан шинжтэй байдаг бол доромжлох үйлдэл нь бусдын нэр алдрыг олон нийтийн өмнө болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр доромжилсоны улмаас материаллаг бус хохирол учирсан байхаар илэрнэ.

Гүтгэх, доромжлох гэмт хэргийн гаралтыг Монгол улсын хэмжээнд 1997 оноос 2004 он хүртэлх хугацаанд авч үзэхэд нийтдээ 75 гэмт хэрэг /үүнээс 1997 онд 5, 1998 онд 6, 1999 онд 11, 2000 онд 9, 2001 онд 10, 2002 онд 8, 2003 онд 12 хэрэг/ бүртгэгдсэнээс 36 эрүүгийн хэргийг шүүхээр таслан шийдвэрлэсэн байна. Гүтгүүлсэн, доромжлуулсан этгээд гомдлоо эрүү, иргэний журмын алинаар нь гаргахаа өөрөө шийдвэрлэдэг бөгөөд хохирогч этгээдийн хүсэл зоригоос хамаарч нэг бол эрүүгийн гэмт хэрэг, эсвэл иргэний хэрэг болон хувирдаг.

Энэ өгүүллийн гол санаа бол гүтгэх, доромжлох үйлдлийг гэмт хэрэгт тооцохоо болих, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, энэ төрлийн хэргүүдийг иргэний журмаар шийдвэрлэх шаардлагатай гэдгийг харуулахад оршино. Гэмт хэрэг бол нийгэмд аюултай, тодорхой этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах , Эрүүгийн хууль зөрчсөн зан үйл байдаг. Тэгвэл хувь хүний эрхтэй холбоотой, нийгэмд аюул багатай доромжлох, гүтгэх үйлдлийг гэмт хэрэг гэж үзэж Эрүүгийн хуульд цаашид байлгах шаардлага байна уу, үгүй юу гэдэг асуулт урган гарна. Өөрөөр хэлбэл гүтгүүлсэн, доромжлуулсан гээд байгаа этгээд хүсвэл цагдаад өргөдлөө өгдөг, эсвэл иргэний журмаар шүүхэд хандах эсэхээ өөрөө шийдвэрлэдэг нь иргэдийн дунд мууг нь үзэх гэсэн нь эрүүгийн журмаар явдаг, мөнгө хүссэн нь иргэний журмаар заргалдаг гэсэн хэлц үг үүсэхэд хүргээд байна. Бусдыг доромжилсон, гүтгэсэн, бусад хэлбэрээр нэр төр, алдар хүндэд нь халдсан этгээд эд хөрөнгийн хариуцлага /иргэний/ хүлээвэл зохих ба үйл ажиллагаандаа дүгнэлт хийхгүй үйлдлээ үргэлжлүүлсээр байвал хуулийн этгээд /шар

хэвлэлүүд/ бол дампуурч, хувь хүн бол өөрөө нэр хүндээ алдаж мөнгөн төлбөрт унах нь хариуцлагын гол хэлбэр болох учиртай.

Өнөөгийн практикаар гүтгэх, доромжлох гэмт хэргийг шүүх шийдвэрлэхдээ гэм буруутай этгээдэд хуульд заасан ял оногдуулаад харин эд хөрөнгийн бус хохирлоо иргэний журмаар жич нэхэмжлэхийг хохирогчид зөвлөдөг. Учир нь Монгол Улсын ЭБШ хуулийн 115-р зүйлд...гэмт хэргийн улмаас зөвхөн эд хөрөнгийн хохирол хүлээсэн этгээд эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй гэсэн заалт ёсоор санаа сэтгэл, нэр төр, алдар хүндэд учирсан эд хөрөнгийн бус хохирлыг эрүүгийн хэрэгтэй нь хамт шийдвэрлэх боломжгүй бөгөөд энэ тохиолдолд хохирлын асуудлыг иргэний журмаар дахин шийдвэрлэх шаардлагатай болдог.

Гүтгэх, доромжлох үйлдлийг гэмт хэрэгт тооцсон Эрүүгийн хуулийн заалт нь эрх мэдэл бүхий албан тушаалтан, өс санамтгай нэгний бусдыг айлган сүрдүүлэх зэвсэг болж хүний эрх тэр дундаа үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг хязгаарлаж боомилох байдалд хүргэж байгаа нь дээрх өөрчлөлт хийхийн практик шаардлага болж байна. Тухайлбал : сүүлийн 2 жилийн дотор 80 гаруй сэтгүүлчийг бусдын нэр төр, алдар хүндэд халдсан гэж шүүхэд дуудсанаас 8 сэтгүүлчийг эрүүгийн ял шийтгэсэн, үүнээс 2 эмэгтэй сэтгүүлчийг /Ханддолгор, Эрдэнэтуяа/ 3-6 сараар баривчлах ялаар шийтгэсэн, 6 хүнийг бусдыг гүтгэсэн, доромжилсон хэргээр яллагдагчаар татаад байна. Иргэний ардчилсан нийгэм бүхий улсуудад энэ төрлийн хэрэг маргааныг иргэний журмаар шүүхээр шийдвэрлэдэг жишиг нэгэнт тогтсоныг дээр өгүүлсэн бөгөөд иргэний ардчилсан нийгмийг байгуулах зорилт тавьсан Монгол Улсын хувьд Эрүүгийн хуульдаа зохих өөрчлөлтийг оруулах цаг нь нэгэнт болжээ.

# ЦААЗААР АВАХ ЯЛЫН ОНОЛ ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ

*Шихихутуг ХЗДС-ийн багш, хууль зүйн ухааны магистр Б.Бат-Еровлт*

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 1-д "Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй. Монгол Улсын эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулсанаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно" гэж заасан.[1] "Цаазаар авах авах ял нь" Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн судлагдахуун мөн.[2] Цаазаар авах ялын эрх зүйн учир холбогдлыг судлаач эрдэмтэд өөрсдийн бүтээлдээ судлан тодорхойлсон ойлголтуудын нийтлэг болон ялгаатай талыг харьцуулах замаар уг ялын ойлголт, шинжийг танин мэдэх нь ач холбогдолтой юм.

Доктор профессор Г.Совд "...Цаазаар авах ял бол манай эрүүгийн ял шийтгэлийн хамгийн хүнд хэлбэр бөгөөд онц аюултай гэмт хэрэг үйлдэгчидэд оногдуулдаг албадлагын арга хэмжээ..."[3] гэж тодорхойлсон бол, академич С.Нарангэрэл /"Монгол Улсын эрүүгийн эрх зүй ерөнхий анги" 1996 он/ бүтээлдээ "Зөвхөн хүний амь насанд халдсан онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялын дээд хэмжээ"[4] гэж үзжээ. Доктор профессор С.Жанцан "Цаазаар авах ял хэрэгжих талаар эрүүгийн хуулийн хэм хэмжээ тогтоох нь хууль тогтоох дээд байгууллагын мэдэлд байх онцгой асуудал"[5] гэжээ. Дээрхи ойлголтуудыг нэгтгэж, бидний үзэж байгаагаар цаазаар авах ял гэж Монгол Улсын эрүүгийн хуулийн тусгай ангид заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буруутай этгээдэд шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор оногдуулж буй төрийн албадлагын арга хэмжээ" гэж үзэх нь зүйтэй болов уу? Цаазаар авах ял нь дараах хууль-цаазын шинжтэй байна.

1. Монгол Улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн 46 дугаар зүйлийн 2-д заасан ялын төрөл, тогтолцоонд хамаарна.

---

[1] Төрийн мэдээлэл. 1993 он №1
[2] Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн –р зүйл. Эрүүгийн хуулийн тусгай ангийн таван гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулахаар заасан байна.
[3] Г.Совд "БНМАУ-ын эрүүгийн эрх зүйн курс" УБ., 1973 он. 348, 349-р тал.
[4] С.Нарангэрэл "Монгол Улсын эрүүгийн эрх зүй" ерөнхий анги УБ., 1996 он. 111–р тал
[5] С.Жанцан "Монгол Улсын эрүүгийн эрх зүй" ерөнхий анги" УБ., 2003 он. 89-р тал

2. Шүүхээс уг ялыг чухам ямар хэрэгт хэрэглэхийг ерөнхий болон тусгай ангид заасан байдаг.
3. Гэмт хэрэг үйлдэх үед 18 насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулдаггүй.
4. Эрүүгийн хуулийн тусгай ангид цаазаар авах ял оногдуулж болох хэргийн санкцыг тодорхойлохдоо өөр төрлийн ял сонгон авч хэрэглэж болох боломжтой заасан байдаг.
5. Цаазаар авах ял оногдуулах нь нийгмийн бусад гишүүдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэм буруутай этгээдийг цээрлүүлэх зорилготой бөгөөд засан хүмүүжүүлэх зорилго агуулдаггүй онцлогтой.
6. Цаазаар авах ялыг гүйцэтгэхдээ зөвхөн эрүүгийн хуульд заасан хэлбэрээр гүйцэтгэдэг зэрэг шинжүүдтэй байж болохоор байна.

Цаазаар авах ялын эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг түүхчлэн судлан үзэхэд эртний уламжлалтай юм. МУ-ын хууль цаазны эх сурвалж болох "Их засаг" хуульд маш өргөн хэрэглэхээр заасан бөгөөд эрүүгийн цаазын 51 зүйлийн 41 зүйлд буюу 80.3 хувьд цаазаар авах ялыг хуульчилсан байдаг.[4] Харин 1921 оноос хойш эрүүгийн хууль тогтоомжийг судлан үзэхэд /1926/ БНМАУ-ын шүүх цаазын бичгийн 2-р бүлгийн 5-р зүйлийн 1-д "алах ял"-ыг хуульчилан нийт 14 гэмт хэрэгт оногдуулахаар заасан бол 1929 оны "Шүүх цаазын бичгийн 5-р зүйлд "буудан алах" ял хэмээн ялыг гүйцэтгэх аргаар хуульчилж 16 гэмт хэрэгт, 1934 оны "Шүүх цаазын бичгийн 14-р зүйлд буудан алах ялын дээд хэмжээ гэж заасан нийт 25 гэмт хэрэгт заасан ба 18 насанд хүрээгүй этгээд жирэмсэн болон нялх хүүхэдтэй эмэгтэйд цаазаар авах ял оноож болохгүй гэж хуульчилсан нь энэ талаарх эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний анхдагч болсон байна.

1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 20-р зүйлд "буудан алах ялын дээд хэмжээ" гэж тодорхойлон 44 гэмт хэрэгт оногдуулахаар заасан эдгээрийн 26 нь буюу 18 хувь нь цэргийн гэмт хэрэгт оногдуулахаар хуульчилсан байна. Үүнийг тухайн үеийн улс төр, нийгмийн байдалтай холбоотой тайлбарлавал манай улсын дотоод, гадаад улс төрийн байдал тогтворгүй, тус улс дайны байдалтай байсантай холбон тайлбарладаг. Дээрхи 1926-1942 оны Эрүүгийн хуулиудыг судлаж үзэхэд цаазаар авах ялыг туйлын

[4] Д.Алтанбазар 1921 оноос хойшхи Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт" УБ 1998 он

тодорхой санкц хэлбэрээр зааж, хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын шинжтэйгээр оногдуулахаар зааж байсан.[7]

1961 оны эрүүгийн хуулийн 18-р зүйлд "онцгой ял цаазаар авах" гэж хуульчилсан ба анх удаа "онцгой ял" гэсэн нэр томъёог хэрэглэсэн, эрүүгийн хуулийн ерөнхий ангийн ялын төрөл, системээс хасч зөвхөн "онцгой" тохиолдолд хэрэглэхээр хуульчилсан байна. Энэ талаар доктор профессор Г.Совд "цаазаар авах ял бол зөвхөн онцгой бөгөөд түр зуурын арга хэмжээ бөгөөд түүнийг хэрэглэхгүй байх явдлыг аль болохоор түргэсгэх зорилтыг тавьж байгаа нь эрүүгийн бодлогын зүй тогтол мөн"[8] гэж тодорхойлсон байна. 1986 оны 6-р сарын 28-ны эрүүгийн хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр мөн "онцгой ял" хэвээр үлдсэн бөгөөд нийт 11 гэмт хэрэгт оногдуулахаар заасан байна. Харин одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуулийн 46-р зүйлд "ялын тогтолцоон"-д цаазаар авах ялыг багтаан, үндсэн ялын чанартай хэрэглэхээр, мөн хуулийн 53-р зүйлд цаазаар авах ялыг хэрэглэх журам, хэлбэр, уучлал хүсэх эрх, цаазаар авах ялыг солих, цаазаар авах ял оногдуулж болохгүй субъектын талаар хуульчилсан байна. Цаазаар авах ялыг одоогийн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 5 гэмт хэрэг буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 81-р зүйлийн 2-т "төр нийгмийн зүтгэлтний амь бied халдах", 84-р зүйл "Хорлон сүйтгэх", 91-р зүйл "Хүнийг санаатай алах", 126-р зүйл "Хүчиндэх", 302-р зүйл "Төрлөөр устгах" гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулахаар, гэхдээ "хорих ял"-ыг сонгох санкцаар хэрэглэж байхаар хуульчилсан байна. Цаазаар авах ял оногдуулах хэргийн тоо, хүрээг эрс цөөрүүлж хуульчлах болсон шалтгаан, үзэл баримтлалыг дараах байдлаар тайлбарлаж болох юм.

1-рт: Үндсэн хуулиар тогтоосон хүний амьд явах эрхийг баталгаажуулах, ялын урьдчилан сэргийлэх ерөнхий нөлөөллийг дээшлүүлэх зорилгоор цаазаар авах ялыг ялын дээд хэмжээ болгосон. Өмнөх хуулиар уг ялыг онцгой ялд тооцож ялын төрөлд оруулдаггүй байв.

2-рт: Өмнөх эрүүгийн хуулиудтай харьцуулахад цаазаар авах ял гүйцэтгэх хэлбэрийг хуульчилж өгсөн.

---

[7] Д.Алтанбазар дурьдсан бүтээл. УБ 1998 он. 49-р тал

[8] Г.Совд "БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс" УБ. 1973 он. 350-351-р тал

3-рт: Цаазаар авах ял оногдуулсан хүн бүр дээд шатны шүүхэд давж заалдах, гомдол гаргах эрхтэй.[9] Уучлал хүсэх эрхийг олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон.

4-рт: Орчин үеийн олон улсын болон улс орны нийгэм эдийн засгийн харилцааны шинэчлэгдсэн нөхцөл байдалтай холбоотой гэмт хэргийн шинж чанар ихээхэн өөрчлөгдсөн бөгөөд энэ байдлыг харгалзан эрүүжүүлэх /криминализация-гэмт хэрэгт тооцох ёс/ эрүүгүйжүүлэх /декриминализация–гэмт хэрэгт тооцохгүй болох/ ялжуулах, ялгүйжүүлэх талаар эрүүгийн бодлогыг шинээр тодорхойлох шаардлага бодитойгоор тавигдсантай холбоотой гэж үзэж байна. Цаазаар авах ялыг байлгах эсэх асуудлаар судлаач эрдэмтэд олон нийтийн санал нэгдмэл бус байдаг.[10]

Цаазаар авах ялыг хэвээр байлгах саналтай судлаачдын гол үндэслэл нь

-Онц хүнд гэмт хэрэгтэнтэй тэмцэх чухал хэрэглүүр болдог

-Олон нийтийн санаа бодлын бодит тусгал болдог

-Ял завшуулах эрсдэл гаргадаггүй гэж үздэг байна.

Харин цаазаар авах ялыг эсэргүүцдэг хэсэг судлаачдын үзэл бодлын үндэслэл нь :

- Ихэвчлэн алдаа гаргах боломжтой байдаг.
- Ос авахад хүргэдэг.
- Хүний амьд явах эрхийн агуулгад нийцдэггүй .
- Харгис хэрцгий байдлыг илтгэдэг.
- Гэмт хэрэгтээ тэмцэхэд онцын нөлөө үзүүлдэггүй гэж үздэг байна.[11]

Дээрхи асуудлыг судлаж дүгнэх зорилгоор гадаадын зарим улс орнуудын эрүүгийн хууль дахь цаазаар авах ял түүний эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлан үзэхэд дэлхийн 68 улсад цаазаар авах ялыг хэрэглэхгүй байгаа ба 28 улсад онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл дайны цагт хэрэглэхээр заасан. Олон улсын байгууллагын судалгаагаар 1 жилд цаазаар авах ял хамгийн их оноосон 10-н улсыг жагсаахад Хятад улс-1791, Иранд-289, Нигерид-100, Саудын Арабд-53, Сингапурт-32, Египетэд-31, АНУ-31, Исменд-25, Ливид-17 байжээ.[12]

[9] С.Нарангэрэл "Монгол Улсын эрүүгийн эрх зүй" 1996 он.
[10] Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны сургаалийн чиглэлүүдээс сонгодог, хүмүүнлэг, сэйн гэгээрүүлэх чиглэлийн гол төлөөлөгчид болох Ш.Л.Монтескье, Ч.Беккариа, И.Кант нар цаазаар авах ялд шүүмжлэлтэй хандаж байсан хандлага ажиглагдаг. /Б.ЕР/
[11] С.Нарангэрэл дурсан бүтээл. УБ 1996 он
[12] Д.Алтанбазар "Цаазаар авах ялын учир холбогдол" УБ 1999. ЭШБ эмхэтгэл.

Харин ОХУ-д 1997 оны 1 сарын 1-нээс дагаж мөрдсөн эрүүгийн хуульд цаазаар авах ялыг хуульчилсан боловч төдийлэн хэрэглэхгүй байгаа нь ОХУ нь Европын улсуудын холбоонд гишүүнээр элссэнтэй холбоотой. Европын холбоонд орж буй улсуудад Польш, Түрк, Болгарт цаазаар авах ялыг хэрэглэсээр байна. Грек, Бельгид хуульчилсан боловч шүүхийн практиктаа хэрэглэдэггүй. Итали, Мальт, Испани, Их Британи эрүүгийн хуулиндаа хуульчилсан боловч зөвхөн дайны цагт хэрэглэхээр заасан байна. Зарим улс орнуудад дараах хэрэг үйлдсэн тохиолдолд цаазаар авах ял оногдуулдаг.

- Эмэгтэйчүүд-гэр бүлийн ёсноос гажсан тохиолдолд /Иран, Саудын Араб, Судан, Арабын Эммират , Мавритани/
- Биеэ үнэлэх, согтууруулах ундаа удаа дараа хэрэглэсэн тохиолдолд /Иран/
- Ижил хүйстэнтэйгээ явалдах / Иран, Мавритани /
- Садар самууныг сурталчилсан, янхны газар эрхэлсэн, зуучилсан, хээл хахууль авсан, /Хятад /
- Агаар, ус бохирдуулсан /Йемен/
- Хараал хийсэн, ховсдсон /Руанда/
- Бурхныг буруушаасан /Иран/
- Ромзаны баяраар тамхи татсан /Иран, Ирак/ зэрэг хэрэг үйлдсэн тохиолдолд цаазаар авах ял оногдуулдаг байна.

Одоогоор дэлхийн 23 оронд гэмт хэрэгтний яс үндэс, нас, хүйс харгалзахгүй цаазалдаг Элгээр орны тоонд Иран, /1990-1999 онд 13 хүүхдийг цаазаар авсан/ АНУ-ын Миссипи мужид 14 наснаас цаазаар авдаг. Флорида муж улсын шүүхийн практикт 13 настай хүүхэд цаазаар авах ял оноосон жишиг байна.[13]

Манай улс цаазаар авах ялыг эрүүгийн хуулиас 1953 оны 8-р сарын 05-ны БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 93-р зарлигаар хассан. Эрүүгийн эрх зүйн түүхэнд эхний тохиолдол болсон ба яг нэг жилийн дараа буюу 1954 онд Завхан аймгийн Улаагшин сумын иргэн Дорлигсүрэн гэгч нь, 0-10 насны хүүхэдтэй эхнэр, нөхөр нийт 6 хүний амийг хөнөөсөн ноцтой гэмт хэрэг гарсан бөгөөд түүнийг нийтийн өмнө буудан цаазалсан явдал юм. Энэ нь цаазаар авах ялыг лахин Эрүүгийн хуульд хуульчлах үндэслэл

[13] Д.Алтанбазар лурьсан бүтээл. УБ 1998 он. 49-р тал

болсон ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн практикт цаазаар авах ялыг олны өмнө гүйцэтгэсэн анхны тохиолдол болсон байна.[14]

Цаазаар авах ял хэрэглэх эсэх нь хүний амьд явах эрхийг хөндсөн хамгийн гол эмзэг ойлголт боловч нөгөө талаар тухайн улс орны эрүүгийн нөхцөл байдалтай зайлшгүй холбон үзэх асуудал юм.

Манай орны хувьд олон нийтийн санал өөр өөр байхын зэрэгцээ сүүлийн үеийн эрүүгийн нөхцөл байдалтай харьцуулан авч үзвэл уг ялыг цаашид хэрэглэх нь зүйтэй гэсэн дүгнэлтэнд хүрч болох юм. Цаазаар авах ялыг хуульчлах нь хууль тогтоох байгууллагын эрхэнд хамаарах асуудал бөгөөд дээрхи байдалд хууль тогтоогчдоос яаж хандаж байгааг авч үзье. УИХ-ын Хууль зүйн байнгын хороо 1998 оны 5-р сард болсон хурлаар гишүүн Д.Хувьтөгөлдөрийн өргөн барьсан /Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн боловч цаазаар авах ялыг хугацаагүй хорих ялаар солих боломж бүрдээгүй гэж үзсэн байна.

Иймээс цаазаар авах ялыг ард нийтийн болон хууль тогтоогчдын үзэл бодол олон нийтийн байгууллагын санал, улс орны эрүүгийн нөхцөл байдал ямар байгаа зэргийг харгалзан одоогийн эрүүгийн хуулинд хэвээр үлдээсэн гэж үзэж байна. Цаазаар авах ялтай зайлшгүй холбоотой авч үзэх асуудал бол цаазаар авах ялыг гүйцэтгэх хэлбэр, журам юм. Цаазаар авах ялыг дэлхийн улс орнуудад янз бүрийн хэлбэрээр гүйцэтгэдэг. Манай орны хувьд эрүүгийн хуулийн 53.2-т буудах хэлбэрээр гүйцэтгэхийг хуульчилсан байна. Дэлхий нийтэд судалгаанаас үзэхэд нийтлэг 7-н хэлбэрээр уг ялыг гүйцэтгэж байна.

1. Түгээмэл нь буудан алах хэлбэр юм. Энэ нь дотроо:
   а/ нэг гүйцэтгэгч ойрын зайнаас тулган буудах,
   б/ олон хүмүүс зайнаас буудах, гэсэн хэлбэрээр хэрэгждэг. Цаазаар авагдаж байгаа этгээдийг аль болох бага зовоож, тарчлаах боломж олгохгүй байхыг Олон улсын эрх зүйн актанд тусгасан байдаг.
2. Дүүжлэх: Одоогийн байдлаар 20 гаруй улс энэ хэлбэрийг хуульчилсан түүний дотор АНУ ын 7 муж улс хуульчисан боловч аль болох татгалздаг.
3. Цавчих: 1939 оны 7-р сарын 27-нд Франц улс хууль гарган хориглох хүртлээ хэрэглэж байсан.

[14] Ж.Амит "Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрхийн тамга" УБ1982 он.

4. Хийн тасалгаанд хордуулах: Ялтныг зориулалтын тасалгаанд нүүрс төрөгчийн исэл, цианы хүчлээр тунгалаг хороор хордуулдаг. /зохиосон хүн нь И.Д.Берч/

5. Үхлийн тарилга: АНУ- ын 22 муж улсад хэрэглэдэг.

6. Цахилгаан сандал: Анх зохион бүтээгч нь Эдисон. Ялтныг 1900 Вольтын хүчдэлтэй сандалд суулган тусгай аппарат ажиллуулдаг.

7. Чулуугаар цохих: Энэ арга хэлбэр нь Исламын эрүүгийн хуульд хуульчлагдсан бөгөөд чулууны том жижиг нь хүртэл нарийвчлан заасан байдаг. Цаазаар авах ялыг гүйцэтгэх хэлбэр нь тухайн этгээдийг зовоохгүйгээр хэрэглэхэд чиглэгдсэн байдаг бөгөөд НҮБ-ын 1984 оны 3 сарын 25-ны тогтоолд хэрэв цаазаар авах ялыг хэрэглэх бол тухайн этгээдийг аль болох бага зовоох хэрэгтэй гэж заасан юм.

Манайд 1926 оноос эдүгээ хүртэлх цаазаар авах ялын хэлбэрийг буудах хэлбэрээр хуульчлан ирсэн байна. Цаазаар авах ялыг оногдуулсан шүүхийн тогтоол гаргаснаас хойш биелүүлэх хүртэл хугацаанд тухайн этгээд сэтгэлийн шаналгаа амсдаг. Гэвч энэ нь цаазыг шууд гүйцэтгэх боломжгүй, ноцтой алдаа гарахаас сэргийлэх ач холбогдолтой байна. Жишээ нь: 1988 онд АНУ д Жаспер Дариныг цаазалсны дараа жинхэнэ гэмт этгээд илэрч байсан гэх мэт. Индонезид 25 жилийн дараа ялтанг цаазалсан. Японд 35 жилийн дараа 95 настайд нь 1987 онд уг ялыг гүйцэттэж байжээ. Мөн Румынд 2 жил, Грект 3 жил өнгөрвөл бүх насаар нь хорих ялаар сольдог байжээ.[15]

Манай орны хувьд цаазаар авах ял оногдуулсан этгээдэд Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар баталсаны дараа энэ тухай 10 хоногийн дотор ялтанд мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор анхан шатны шүүх улсын дээд шүүхэд амь уучлахыг хүссэн хүсэлт гаргасан бол тэр тухай тэмдэглэл ирүүлнэ. Ялтан өөрөө түүнээс хойш 7-хоногийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар уг тэмдэглэлийг хүлээлгэн өгөх тухай хуульчилсан байна.[16]

Цаазаар авах журам төрийн нууцын зэрэглэлийн маш нууц зэрэглэлд багтдаг учраас тухайлан судлах боломж бага байна. Цаазаар авах ял оногдуулсан этгээдийн гэр бүл, ойр дотны хүмүүст сэтгэлийн асар их шаналал

---

[15] ХБНГУ, Япон Австри, АНУ, Итали, Франц, Голланд улсуудын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулиуд

[16] "Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль" 2002он

зовиур авчирдаг асуудал бол цаазаар аваачсан талаар тэдэнд тодорхой мэдээлэл байдаггүйтэй холбоотой юм. Зарим улс орны практикаас үзэхэд гэр бүлийн гишүүдээс төлөөлөн байлцуулдаг, цаазалсны дараа шарилыг нь хүлээлгэн өгдөг, шашин, зан үйлийн үйлдэл хийх асуудал нээлттэй байдаг хандлага ажиглагдаж байна.

Тухайн этгээд цаазлагдах хүртлээ тодорхой хяналт, хугацааны дотор гэр бүлийн гишүүдтэйгээ цуг байх нөхцөлөөр хангаж, сүүлчийн хүсэлтээ биелүүлэх эрхтэй болохыг Голланд, АНУ-ын зарим муж улс, Франц зэрэг орны хуулиудад тусгасан байна. Иймээс хүнлэг, энэрэнгүй ёсны үүднээс цаазаар авах ял шийтгүүлсэн этгээд гэр бүлийн хүмүүстэйгээ 1 удаа уулзах хуулийн хугацаа болон шашин, шүтлэгийн зан үйл хийх боломж, сүүлчийн хүсэлтээ биелүүлэх зэрэг боломжуудыг зохицуулах нь зүйтэй болов уу. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан "Цаазаар авах ял гүйцэтгэх журам" /маш нууц зэрэглэлд байдаг/ хэнийг, хэзээ гүйцэтгэх, хаана гүйцэтгэх нь нууц байх боловч ямар журмаар гүйцэтгэх нь нууц байх шаардлагатай эсэхийг судалж, цаашид тусгайлан хуулиар зохицуулах нь энэрэнгүй ёсонд нийцэх болов уу гэж үзэж байна.

# ҮНДСЭН ХУУЛЬТ ЁС БУЮУ
# ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ТУХАЙД

*Хууль зүйн магистр Ч.Онорбаяр*

**Дотоод системчлэл:**

- Үндсэн хуулийн шүүхийн түүхэн хөгжилт, үндсэн загварууд
- Төрийн эрх мэдэл хуваарилах онол ба үндсэн хуулийн шүүх
- Үндсэн хуулийн шүүхийн хяналтын объект
- Үндсэн хуулийн шүүх ба парламент
- Дүгнэлт

1. Хүн төрөлхтөний олж цуглуулсан 200 гаруй жилийн туршлага нь "шүүхийн үйл ажиллагаа улс төрийн давалгаанаас ангид байх" үнэт зүйлсийн тогтолцоог бүтээж бүй болгосон түүхтэй. Эдүгээ үндсэн хуулийн шүүхийн загварыг хамгийн түгээмэл байдлаар нь:

А. Эх газар-европын үндсэн хуулийн шүүхийн загвар

Б. Америкийн дээд шүүхийн нэгдмэл загвар гэж хуваадаг.

1803 оноос АНУ-ын Дээд шүүхээс хэрэгжүүлж ирсэн judical review буюу шүүгч хэм хэмжээний хяналтыг хэрэгжүүлэх практик Европт анх XX зуунд нэвтэрсэн юм. Тухайлбал, 1920 онд Австрид, түүнээс хойш 1949 онд ХБНГУ-д үндсэн хуулийн шүүх байгуулагдаж, 1951 оноос ажиллаж эхэлсэн бол Францад 1956 оноос үндсэн хуулийн шүүх гэж үзэж болох өвөрмөц онцлог бүхий зөвлөлийг байгуулж ажиллуулсан байдаг. Иймд Үндсэн хуулийн түүхэнд улс орнуудын үндсэн хуулийн шүүхүүд нь хэлбэрийн хувьд ч тэр, институтын хувьд ч тэр 20-р зууны хоёрдугаар хагаст буюу нилээд хожуу төлөвшин хөгжжээ.[1] Анхлан эл санааг гаргаж ирсэн хүн бол Францын их сэтгэгч, шүүгч Монтескье юм[2].

Европын үндсэн хуулийн шүүх нь Америкийн дээд шүүхийн нэгдмэл загвараас ялгаатай. Үндсэн хуулийн шүүхийн европын загвар нь төвлөрсөн

[1] Ханс-Иоахим Иенч. Үндсэн хуулийн шүүх ардчилсан эрх зүйт төрийн зохион байгуулалтын тулгын чулуу мөн. (Монголын төр, эрх зүй сэтгүүл) 2002., №03. 24-25 дахь тал.

[2] Louis Desgraves, Montesquieu. S 342. Ulm 1992. (Дам ишлэл)

буюу цорын ганц байгууллага эрх зүйн хэм хэмжээ үндсэн хуульд нийцэж буй эсэхийг тогтоож буй явдал мөн. Америкийн үндсэн хуулийн шүүхийн загвар нь төвлөрсөн бус, харин бүх шүүх эрх зүйн хэм хэмжээ үндсэн хуульд нийцэж буй эсэх талаар дүгнэлт гаргах эрхтэй байдаг. Үндсэн хуулийн шүүхийн хэм хэмжээний хяналтыг шийдвэрлэх хэрэг, маргаантай холбоотой хэрэгжиж байгаа эсэхийг нь шалгуур болгож тодорхой(konkret normakontroll) ба хийсвэр (abstract normakontroll) хяналт гэж ангилдаг. Америкийн загварын хувьд эрх зүйн хэм хэмжээ үндсэн хуульд нийцэж байгаа эсэх нь зөвхөн тухайн хэрэгтэй холбогдож тухайн шүүх дээр шийдэгддэг (konkret normakontroll) бол европын загвар нь эрх олгогдсон төрийн байгууллага тодорхой гомдлын үндсэн дээр тухайн хэм хэмжээ үндсэн хуульд нийцэж буй эсэх талаар дүгнэлт гаргадаг (abstract normakontroll). Үүнтэй холбогдон америкийн загварын дагуу хэм хэмжээ үндсэн хуульд нийцэж буй эсэх талаар шүүхийн гаргасан шийдвэр нь ихэвчлэн зөвхөн тухайн хэрэгт оролцож буй талуудын хувьд хүчинтэй (inter partes), харин европын үндсэн хуулийн шүүхийн шийдвэр бүх нийтээрээ заавал дагаж мөрдөх (erga omnes) эрх зүйн баримт бичиг байдаг.[3]

2. Үндсэн хууль нь иргэний үндсэн эрхийн бүхий л асуудлыг үүрд мөнхийн болгон баталгаажуулж өгсөн хэм хэмжээнүүдийн оргил, ардчилсан эрх зүйт төрийн суурь зарчмуудын бүрдэл юм. Иймд төрийн эрх мэдэл хэрэгжүүлэлтийг үндсэн хуульт төрийн тогтолцоонд зарчмынх нь хувьд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудад хуваарилан тэнцвэржүүлдэг. Үндсэн хуульт ёсны онолын хүрээнд үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг тусгай институт байх эсэх талаар томоохон маргаан өрнөдөг. Тухайлбал, Карл Шмидт үндсэн хуулийн шүүхийн байгууллага нь үндсэн хуулийн уян хатан чанарыг алдагдуулдаг[4] гэжээ. Тэрбээр цааш нь "үндсэн хуулийн шүүхийг маргаан, сөргөлдөөнийг шийдвэрлэх улс төрийн зэмсэг"[5]-тэй адилтгаж, хариуцлага хүлээдэггүй, гэхдээ улс төрийн шийдвэр гаргадаг байгууллага бол дарангуйлан захирагч эсвэл эзэн хаантай адил учир

[3] З.Батбаяр. Монгол улсын үндсэн хуулийн цэц ба европын үндсэн хуулийн шүүхийн онолын харилцан шүтэлцээ, зарим улсын үндсэн хуулийн шүүхийн харьцуулалт.(Гадаадын их, дээд сургууль төгсөгчийн эрдмийн бүтээлийн эмхтгэл) УБ.,2003. 101-102 дахь тал.
[4] K.Doehring .Allgemeine Staatslehre, Heidelberg. 1991. s 194.
[5] Carl Schmitt, Das Reichsgericht als Hueter der Verfassung, in Verfassungsrechtliche Aufsaetze, Berlin 1973.,S 63, 73, 74 ff.

үндсэн хуулийн шүүх огт хэрэггүй зүйл гэж үзсэн байна.[6] Үүний эсрэг Ханс Кельзен үндсэн хуулийн хяналтын институт байх нь зайлшгүй чухал болохыг тэмдэглээд, үндсэн хуулийн шүүх байх хэрэгцээ, шаардлагыг зөвхөн хэм хэмжээний шатлал байдлаар тайлбарлахад хангалттай[7] гэжээ.

Төрийн эрх мэдлийн эдгээр байгууллагууд үндсэн хуулийг чанд мөрдөж байгаа эсэхийг хянадаг институт бий болсноор шүүх эрх мэдлийн байгууллагуудын ерөнхий хяналт бэхжиж, улам бүр хүчирхэгждэг. Үүний зэрэгцээ төрийн эрх мэдлийн хуваарилалт нь шүүхийн болон үндсэн хуулийн шүүхийн оршин тогтнох үндсэн нөхцөл болж өгдөг[8]. Иймд үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуультай холбоотой хэрэг маргаан гарсан үед үндсэн хуулийн эрх зүйг тайлбарлаж, хэрэглэх талаар эцсийн шийдвэр гаргах үүргийг ард түмнийхээ өмнө хүлээдэг. Ард түмнээс захиалга авсан үндсэн хуулийн шүүх нь төрийн бусад эрх мэдлийг хянахаас гадна, үндэсний эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх механизм болдог.

Одгоо үндсэн хуулийн шүүх нь төрийн эрх мэдлийн гурав дахь салаа мөчрийн бүрэлдэхүүн хэсэг болох эсэх нь онолын хувьд маргаантай. Энэ тухай Австрийн эрх зүйн онолч, үндсэн хуулийн шүүхийн европын загварыг үндэслэгч Ханс Кельзен "Үндсэн хуулийн шүүх нь аль нэг засаглал руу уусан орж болохгүй" гэснийг В.Кризафули "Үндсэн хуулийн шүүх нь төрийн засаглалын гурван салбарын алинд ч хамаарахгүйгээр бие даасан засаглалын хэлбэр ба энэхүү засаглалын хэлбэр нь бүх салбарт үндсэн хуулийн хяналт хамгаалалтыг хэрэгжүүлэх үүрэгтэй"[9] гэж тодотгосон байдаг. Харин ХБНГУ-ын Үндсэн хууль 92 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийг байгуулж бий болгох асуудлыг шийдвэрлэсэнээс гадна тус шүүхийг шүүх эрх мэдлийн бүрэлдэхүүнд[10] оруулсаныг профессор Х.Шоллер "Үндсэн хуулийн шүүх бол шүүх эрх мэдэлд хамаарах бөгөөд энэ нь Үндсэн хуулиар баталгаажсан эрх мэдэл хуваарилах зарчимд харшлахгүй[11] гэж тайлбарласан байна. Үндсэн

[6] Ц.Сарантуяа. Төрийн ерөнхий онол. УБ.,1998. 146 дахь тал.
[7] Hans Kelsen. Allgemeine Staatslehre. Wein., 1993. s 255.
[8] Ханс-Иоахим Иенч. Үндсэн хуулийн шүүх ардчилсан эрх зүйт төрийн зохион байгуулалтын тулгын чулуу мөн. (Монголын төр, эрх зүй сэтгүүл) 2002., №03. 26 дахь тал.
[9] З.Батбаяр. Монгол улсын үндсэн хуулийн цэц ба европын үндсэн хуулийн шүүхийн онолын харилцан шүтэлцээ, зарим улсын үндсэн хуулийн шүүхийн харьцуулалт. (Гадаадын их, дээд сургууль төгсөгчдийн эрдмийн бүтээлийн эмхтгэл) УБ.,2003. 101-102 дахь тал.
[10] Х.Шоллер. Үндсэн хуулийн шүүх гурав дахь эрх мэдлийн бүрэлдэхүүн хэсэг болох тухай.(Үндсэн хуулийн шүүх, парламент хоорондын харилцааны эрх зүйн болон ёс зүйн үндэс). Симпозиум. УБ.,1998. 127 дахь тал.
[11] Мөн тэнд. 132 дахь тал.

хуулийн шүүх нь орчин үеийн үндсэн хуульт төрийн хоёр багана болох ардчилал, эрх зүйт төрийг холбож өгдөг ба ингэснээрээ үндсэн хуулийн шүүх нь ардчилсан эрх зүйт төрийн зохион байгуулалтын тулгуу чулуу[12] юм.

3. Хэм хэмжээний хяналт тавих эрх хэмжээ, үүнтэй холбоотойгоор хэм хэмжээг хүчингүй болгох эрх хэмжээ, төрийн байгууллага хоорондын маргааныг шийдвэрлэх эрх хэмжээ, ялангуяа эрх мэдэл хоорондын маргааныг шийдвэрлэх эрх хэмжээ нь үндсэн хуулийн шүүхийг ажил үүргийнх нь хувьд үндсэн хуулийн байгууллага болгож байгаа юм.[13] Үүний зэрэгцээ Үндсэн хуулийг иргэний эрхийн хамгаалалтын найдвартай систем гэж ойлговол, төрийн эрх мэдлийн бусад байгууллагуудаас гаргасан актыг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шүүх шалгах бүрэн эрхтэй байх ёстой. Үндсэн хуульт төрийн түүхэнд "үндсэн хуулийг дээдлэх" зарчим бүрэн хэрэгжсэнээр л хуулийг үндсэн хуультай нийцэж байгаа эсэхийг хянах болжээ. [14]Чухамхүү энэ "үндсэн хуулийг дээдлэх" зарчмыг заавал баталгаажуулах нь бие даасан үндсэн хуулийн шүүхийн жинхэнэ үүрэг[15]байдаг.

Иймд парламентаас баталсан эрх зүйн акт болон тухайн улсын нэгдэн орсон эсхүл соёрхон баталсан олон улсын гэрээ үндсэн хуулийн шүүхийн хяналтын үндсэн объект болдог. Үүний зэрэгцээ үндсэн хуулийн шүүх нь хууль тогтоомжууд үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянахаас өөр бусад эрхийг эдэлдэг. Тодруулбал, үндсэн хуулийн  байгууллагууд хоорондын маргаан, сонгуулийн үйл явц, ард нийтийн санал асуулга, зарим улсуудад ерөнхийлөгчийг албан тушаалаас нь огцруулах асуудлыг хүртэл шийдвэрлэдэг. Тухайлбал, Австрийн үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн 142 ба 143 дугаар заалтыг үндэслэн Төрийн холбоо болон гишүүн улсын өндөр албан тушаалтнуудын үндсэн хууль зөрчсөн болон албан тушаалаас нь огцруулах, эрүүгийн эрх зүйн хариуцлага хүлээлгэхүйц үйлдлийг авч хэлэлцэх шийдвэр гаргах эрхтэй байдаг. Энэхүү шийдвэрийг парламентын хүсэлтийн дагуу гаргах үүрэгтэй[16]байдаг. Иймд үндсэн хуулийн шүүхийн хяналтын

[12] Ханс-Иоахим Иенч. Үндсэн хуулийн шүүх ардчилсан эрх зүйт төрийн зохион байгуулалтын тулгын чулуу мөн. (Монголын төр, эрх зүй сэтгүүл) №03.УБ.,2002.37 дахь тал. (Би энэ үзэл баримтлалыг дэмжив)
[13] Мөн тэнд. 27 дахь тал.
[14] E.-W.Bockenforde, Verfassungsgerich tsbarkeit: Strukturen, Organisation, Legitimation, NJW. 1999. 9 (12)
[15] Ханс-Иоахим Иенч. Үндсэн хуулийн шүүх ардчилсан эрх зүйт төрийн зохион байгуулалтын тулгын чулуу мөн. (Монголын төр, эрх зүй сэтгүүл) №03.УБ.,2002. 26 дахь тал.
[16] З.Батбаяр. Монгол улсын үндсэн хуулийн цэц ба европын үндсэн хуулийн шүүхийн онолын харилцан шүтэлцээ, зарим улсын үндсэн хуулийн шүүхийн харьцуулалт. УБ.,2003. 115 дахь тал.

объектийг хэм хэмжээний ба бусад гэж ангилж болох юм.

Ардчилсан эрх зүйт төрийн зарчмаар үндсэн хуулийн шүүхийн хяналтын цорын ганц шүүлтүүр нь Үндсэн хууль өөрөө болдог. Энэ нь үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийн зарчмуудаас гадуур улс төр хийхээс татгалзах ёстой гэсэн эрх зүйт төрийн суурь үнэт зүйлийг баталгаажуулдаг байна.

4. Үндсэн хууль бүхий төр нь төрийн эрх мэдлийг эрх зүйн арга хэрэгслээр хязгаарлах болон хянах гэсэн оролдлого юм.[17] Тиймээс Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуульд холбогдох аливаа маргааныг улс төрийн хувьд онцгой ач холбогдолтой байсан ч түүний суурь зарчмуудыг хэмжүүр болгон шийдвэрлэдэг. Эрх мэдэл хуваарилагдсан үндсэн хуулийн байгууллагууд нь үндсэн хуульт ёсны зарчмын дагуу тус тусын салбартаа бие даан шийдвэр гаргаж, ямар нэгэн алдаа гаргасан тохиолдолд хариуцлагаа өөрсдөө үүрдэг. Харин үндсэн хуулийн шүүх нь эдгээр эрх мэдлүүдийн хоорондын уялдаа холбоог хянаж, баталгаажуулж байдаг. Хэрэв хууль тогтоох байгууллага үндсэн хуулийн шүүхийн хяналтаас гадуур байх аваас түүний хязгааргүй эрх мэдэл ардчилсан эрх зүйт төрийн суурийг ганхуулах аюултай.

Иймд төрөөс батлан гаргасан аливаа акт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар эцсийн шийдвэр гаргах эрх парламентад биш, харин бие даасан хараат бус шүүхэд хадгалагддаг. Энэ бол үндсэн хуульт ёсны суурь зарчим. Үүний эсрэг парламент ардчилсан ёсны зарчмын тухай яриад ч нэмэргүй. Учир нь нэг талаас ардчилсан ёсны зарчим гэдэг бол парламент бусад эрх мэдэлтэй харьцуулахад давуу эрх эдэлнэ гэсэн хэрэг огт биш, нөгөө талаас төрийн бүх эрх мэдэл Үндсэн хуульд захирагдах бөгөөд олонхийн саналаар ч парламент нь Үндсэн хуулийг давж гарах эрхгүй[18]байдаг. Тэгэхлээр, үндсэн хуулийн шүүх нь эрх зүйт төрийн сүүлчийн логик үр дагавар[19] бөгөөд үндсэн хуульт ёсны гол баталгаа болдог.

**Дүгнэлт:** Үндсэн хуулийн шүүх нь шударга ёс, хуулийн ноёрхыг нийгэмд тогтоох замаар иргэний үндсэн эрхийг дархлаажуулж, улмаар төрийн эрх мэдлүүдийн хооронд тэнцвэржүүлэгч болж өгдөг Үндсэн хуулийн байгууллага юм. Тэгэхлээр, үндсэн хуулийн шүүх гэдэг бол угтаа үндсэн хуульт ёс мөн.

---

[17] Дитрих Малю. Эрх зүй, улс төрийн хоорондын харилцаанд Үндсэн хуулийн шүүхийн эзлэх байр суурь. (Үндсэн хуулийн шүүх, парламент хоорондын харилцааны эрх зүйн болон ёс зүйн үндэс) Симпозиум. УБ.,1998. 63 дахь тал.

[18] Рудольф Меллингхофф. Үндсэн хуулийн шүүх улс төр, эрдийн шүүхийн тогтолцооны зөрчилдөөний талбарт.(Монголын төр, эрх зүй сэтгүүл) УБ.,2004. 25 дахь тал.

[19] Bethge in Maunz/Schmidt-Bleibtreu/Klein/Ulsamer, BverfGG, Vorb. Rn 2

# ҮНДСЭН ХУУЛЬ БА ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ

## (Үндсэн хуулийн хяналт)

*Магистрант А.Энхбат*

Үндсэн хуулийн эрх зүйн институтиудын дотроос Монгол Улсад харьцангуй шинэ институт бол Үндсэн хуулийн хяналт буюу Үндсэн хуулийг эрх зүйн зохицуулалтаар хамгаалах асуудал юм.

Үндсэн хуулийг боловсруулж батлах нь чухал боловч түүнийг хэрэгжүүлж мөрдөн сахиж хамгаалах нь бодит Үндсэн хуультай байх үндсэн баталгаа болдог байна. Өөрөөр хэлбэл батлагдсан Үндсэн хуулийг зөрчөөд эхэлбэл хэлбэрийн төдий Үндсэн хуультай болж Үндсэн хууль үйлчлэх баталгаагүй болдог. Төр-эрх зүйн харилцаанд оролцож буй зарим субъектүүд ялангуяа улс төрчид өөрийн зорилгодоо хүрэхийн тулд хууль зөрчигдөж буй эсэхэд санаа бага тавьдаг гэсэн шүүмжлэлтэй байдал заримдаа ажиглагддаг бөгөөд Үндсэн хуулийн хязгаарлалтыг тэр бүр анхаардаггүй гэж ч ярьдаг. Иймээс эрх зүйн зохицуулалтаар Үндсэн хуулийг хамгаалах ёс бий болжээ.

Хүн төрөлхтөн эрт дээр үеэс хуулийг дагаж мөрдөх баталгааг эрж хайсаар байв. Унгарын Алтан Булльд Андрей II нэгэн нөхцөл тавьжээ. Тэр нь, энэхүү Харти-д байгаа амлалтаа би болон миний үе залгамжлагчдаас зөрчих юм бол тайж язгууртан, прелетууд миний эсрэг босох эрхтэй бөгөөд Харти-г зөрчихийг эх орноосоо урвасан хэрэг гэж шууд үзнэ-jus resisted[1] гэжээ. Энэхүү амлалт нь өнөөг хүртэл Үндсэн хуулийг амьдралд хэрэгжүүлэх баталгаа болсоор иржээ. Үндсэн хууль амлалт байх ёсгүй. Тиймээс Үндсэн хууль бодитой хэрэгжих баталгаатай байх зарчим тогтсон төдийгүй энэ нь Үндсэн хуульт ёсны үндсэн зарчим болж байдаг аж.

Үндсэн хуульт ёсонд төрийн байгууллагуудыг олон нийтийн зүгээс шууд хянах механизм хүчтэй үйлчилдэг ёстой. Тэр нь төрийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэр Үндсэн хуулийг зөрчиж буй эсэх асуудлаар иргэн гомдол гаргах эрх юм. Тийнхүү гаргасан гомдлыг ямар байгууллага хэрхэн

[1] Верховенство права. "Прогресс-Универс". М.1992. 64 дэх тал

шийдвэрлэх талаар Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаанд цогц сургааль, үзэл номлол бий. Тэдгээрийг тоймлон авч үзвэл: Үндсэн хуулийн хяналтыг дэлхийн улс орнууд дараах хэлбэрүүдээр хэрэгжүүлдэг байна. Үүнд:

1. Үндсэн хуулийг зөрчсөн эсэх асуудлаар дүгнэлт гарган Парламентад оруулдаг
2. Үндсэн хуультай холбогдох маргааныг шууд шүүхийн журмаар хянан шийдвэрлэх
3. Дээрх хэлбэрүүд холимог байх

**Эхний хэлбэрийн хувьд** Үндсэн хуулийн хяналтын зөвлөл төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын гаргасан шийдвэр Үндсэн хуулийг зөрчиж буй эсэхийг хянан шалгаж дүгнэлт гарган Парламентад оруулдаг байна. Харин уг зөвлөл авч үзсэн асуудлаараа эцсийн шийдвэр гаргадаггүй.

**Хоёрдахь хэлбэрийн хувьд** тухайн маргаантай асуудлыг шүүх хараат бус, бие даасан зарчмаар авч хэлэлцэн эцсийн шийдвэр гаргадаг. 1803 онд АНУ-ын дээд шүүхийн дарга Жон Маршал, Ж.Медисоны эсрэг У.Мерберийн хэргийг шийдвэрлэхдээ "Холбооны Үндсэн хууль бол Конгрессын ямар ч хуулиас, дээд хүчинтэй. Үндсэн хуульд нийцээгүй хууль хүчин төгөлдөр бус байна" гэж зарласнаар Үндсэн хуулийн биелэлтэд тавих дээд хяналтыг дээд шүүхийн харъяалалд анх оруулжээ.

**Гуравдахь хэлбэрийн хувьд** Үндсэн хуулийг зөрчсөн эсэх асуудлаар дүгнэлт гаргаж Парламентаар хэлэлцүүлэн Парламент эс зөвшөөрсөн тохиолдолд дахин хянан хэлэлцэж эцсийн шийдвэр гаргадаг болно.

Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаанд 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль нэг гол хувь нэмэр оруулсан юм. Тэр нь "Төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцвэржилтийн онол"-ыг суурь болгосонд оршино. Төрийн эрх мэдлийг хуваарилах, хянах, тэнцвэржүүлэх онолын зарчмын гол шинж, ач холбогдол нь ард түмний эрх, ашиг сонирхлын эсрэг засаглах хүч, түүнийг хэрэгжүүлдэг байгууллагуудыг ашиглах явдлыг гаргуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгджээ. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч салаа мөчир бүр Үндсэн хуулийг тогтвортой байлгах, түүнийг бүтээлчээр хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. Төрийн эрх мэдлийг хуваарилж, хянаж, тэнцвэржүүлэх зарчмын нэг гол үзэл баримтлал бол ард түмний эв нэгдэл, язгуур эрх ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн хөгжлийн баталгаат

нөхцлийг хангах үйл хэрэгт нэгдмэл байх үзэл баримтал юм. Энэ үүднээс дээрх 3 хэлбэрийн аль нь Монгол Улсад зохистойг авч үзэж болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн V бүлэг бүхэлдээ Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрх, үйл ажиллагааны хэлбэр, онцлогийг тодорхойлсон юм. Үндсэн хуулийн цэц нь шүүхийн зарчмаар үйл ажиллагаагаа явуулдаг, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын нэг мөн. Үндсэн хуулийн цэц төрийн эрх мэдлийн дээд түвшний байгууллага, түүний албан тушаалтан бол "эрх зүйн хэм хэмжээний акт" Үндсэн хуульд нийцэж буй эсэхэд хяналт тавих, Үндсэн хуулийг чандлан сахиулах бүрэн эрхтэй юм. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгуулага дур зоргоороо аашилж, эрх хэмжээгээ хэтрүүлэх боломжийг Үндсэн хуульт ёс, ардчилсан эрх зүйт төр Үндсэн хуулийн хэм хэмжээнд нийцүүлэн хязгаарлах эрх зөвхөн Үндсэн хуулийн цэцэд олгогдсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран долдугаар зүйлд Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно хэмээн заасан нь "бусдын хязгааргүйд тэмүүлэх эрхийг хязгаарлан" Үндсэн хуулийн хэм хэмжээ, хүрээ хязгаарт оруулах баталгааг бий болгосон хэрэг мөн. Монгол Улсын Үндсэн хууль Үндсэн хуулийн цэцэд хязгааргүй эрх хэмжээг олгоогүй бөгөөд зөвхөн Үндсэн хуулийг зөрчсөн маргаантай асуудлыг өөрөө биш иргэдийн өргөдөл, эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтээр хуулиар тодорхойлсон процедур журмын дагуу хянан шийдвэрлэх эрх хэмжээг тогтоосон байна. Эндээс үзвэл Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн хяналтыг <u>**холимог**</u> хэлбэрээр хэрэгжүүлдэг шүүхийн шинж нь давамгайлсан Үндсэн хуулийг чандлан сахиулах дээд хяналт тавих чиг үүрэг бүхий цорын ганц байгууллага юм.

ОХУ-ын эрдэмтэн К.В.Арановский "Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаа нь төрийн эрх мэдлийг хуваарилан хэрэгжүүлэх төрийн удирдлагын дээд түвшинд ажилладаг онцгой эрх бүхий хяналтын байгууллага, шүүх эрх мэдлийн нэг хэсгийг хэрэгжүүлэгч субъект мөн"[2] гэж бичсэнийг зүйтэй хэмээн үзэж байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүрэг, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд Үндсэн хууль зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх нь Үндсэн

---

[2] К.В.Арановский. Государственное право зарубежных стран. "Форум" М., 2000 146 дахь тал

хуулиар түүнд олгогдсон статус учраас Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа нь болдог.

Цэц хараат бус байна. Энэ нь Үндсэн хуулийн зөрчилтэй холбогдох маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд гадны ямар нэг байгууллага, албан тушаалтан, бусад хүмүүс, нам улс төрийн бусад хүчинд захирагдахгүй төдийгүй Үндсэн хуулийн цэц өөрийн зохион байгуулалт, үйл ажиллагааны хувьд ч хараат бус байна.

Үндсэн хуулийн цэц нь үйл ажиллагааныхаа талаар бусад байгууллагад тайлагнах үүрэггүй бөгөөд Цэцийн бүтцийг зөвхөн Үндсэн хуулиар тогтоодог өвөрмөц байгуулага юм.

Цэц Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах үндсэн зарчимтай. Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн хараат бус байдал нь Цэцийн хараат бус зарчим хангагдах нөхцөл нь болно. Цэцийн гүшүүний хараат бус байдал нь Цэцийн гишүүний тэгш эрхийн зарчмаар хангагдана. Энэхүү зарчим нь Цэцэд Үндсэн хуулийн маргааныг хянаж дүгнэлт гаргах, магадлан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй гишүүд бүгд адил тэгш эрхтэй байх хууль зүйн үндэслэлээр баталгаажсдаг. Эндээс үзвэл Үндсэн хуулийн цэц нь ардчиллыг үйл ажиллагааныхаа хэм хэмжээ болгосон байгууллага юм.

Цэцийн гишүүн үүргээ гүйцэтгэхдээ хэнийг ч төлөөлөхгүй өөрийн нэрийн өмнөөс ажиллана. Үндсэн хуулийн цэцийн гишүүн хуульд заасан байгууллага /Улсын Их Хурал, Дээд Шүүх/, албан тушаалтан /Ерөнхийлөгч/-аас нэр дэвшин УИХ-аас томилогддог боловч тэдний ашиг сонирхлыг төлөөлөх, үйл ажиллагаа тэдгээрийн өмнө хариуцан тайлагнах үүрэг хүлээдэггүй болно. Мөн Үндсэн хуулийн Цэцийн гишүүд нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10-д заасан “Төрийн зарим төрлийн албан хаагчдын намын гишүүнийг түдгэлзүүлж болно” гэсэн заалтын дагуу томилогдсон өдрөөсөө эхлэн намын харъяаллаа түдгэлздэг юм.

# ЗАХИРГААНЫ АЛБАДЛАГА

*Магистрант Г.Ганболд*

Албадлага /constraint/ төрийн мэдлээр дамжин хэрэгжиж тухайн засаглалын шинжийг илэрхийлж байдаг төрийн удирдлагын болон эрх зүйн арга, (процесс) ойлголт юм.

Төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлдэг албадлагыг эрх зүйн үйлчлэлээр нь төр эрх зүйн, захиргааны, эрүүгийн, эрүүгийн байцаан шийттэх, иргэний, хөдөлмөрийн эрх зүйн гэж авч үздэг байна. Захиргааны албадлага нь эрүүгийнхээс бусад нь зөвхөн тухайн салбартаа хамааралтай Эрх зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг хангаж, хууль зүйн хариуцлага хүлээхэд үйлчилдэг төрийн албадлагын бие даасан нэг төрөл бол захиргааны эрх зүйн арга юм.

**Захиргааны албадлага гэдэг нь иргэн, албан тушаалтан, байгууллага, аж ахуйн нэгжийн хуулиар хүлээсэн үүргийг гүйцэтгүүлэхийн тулд төрийн эрх бүхий байгууллагаас эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, захиргааны процессийн ажиллагааг хангах, хариуцлага хүлээлгэх зорилготойгоор хууль, түүнд нийцсэн эрх зүйн актад урьдаас заасан арга хэмжээг албадан хэрэглэхийг хэлнэ.**[1]

Захиргааны албадлагын төрөл ангилалын тухай манай хуульч эрдэмтэд, судлаачид өөр өөр санал, үзэл баримтлалтай байдаг. Тухайлбал хууль зүйн шинжлэх ухааны доктор Д.Лүндээжанцан захиргааны албадлагыг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, захиргааны хариушлагын арга хэмжээ[2] гэсэн гурван хэсэгт авч үзсэн байхад доктор Ж.Долгорсүрэн дээрх гурав дээр нэмж захиргааны процессийн албадлага[3] гэсэн ангилалтыг тодорхойлон авч үзжээ.

Дээрхи эрдэмтдийн үзэл баримтлалыг үндэслэн, төрийн эрх бүхий байгууллагаас эрх зүйн дэг журмыг хамгаалах бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа албадан нөлөөлөх захиргааны эрх зүйн арга хэрэгсэлийн

[1] Ж.Долгорсүрэн "Захиргааны албадлага" 1999, 31 дэх тал
[2] Д.Лүндээжанцан "Экологийн эрх зүй" 1995, 108 дахь тал
[3] Ж.Долгорсүрэн "Захиргааны албадлага" 1999, 36 дахь тал

олон талт үйл ажиллагааг дараах байдлаар ангилан авч үзэж болох юм.

- Захиргааны урьдчилан сэргийлэх албадлага
- Захиргааны таслан зогсоох албадлага
- Захиргааны процессийн албадлага
- Захиргааны шийтгэл буюу хариушлагын арга хэмжээ

**Захиргааны урьдчилан сэргийлэх албадлага**: Төрийн эрх барих болон захиргааны байгууллагаас нийтийн аюулгүй байдлыг хангах, эрх зүйн эсрэг нөхцөл байдлыг бүрдүүлэхгүй байх, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах зорилгоор захиргааны урьдчилан сэргийлэх албадлагыг хэрэглэдэг. Энэ нь эрх зүйн зөрчил заавал гарсантай холбоотой биш тодорхой нөхцөл байдлын улмаас хорио цээр тогтоох, хязгаарлалтын хэлбэрээр нэг талын хүсэл зоригийг илэрхийлэн, хууль, түүнд нийцэж гарсан актад урьдчилан заасан дагуу хэрэгжиж байдаг.

Захиргааны урьдчилан сэргийлэх албадлагын арга хэмжээг дараах төрлүүдэд авч үзэж болох бөгөөд эдгээрийг:

- **Эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд шууд чиглэгдсэн**
- **Нийгмийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн** гэж үндсэн хоёр чиглэлд авч үзэж болох юм.

Үүнд:

- Баримт бичиг шалгах,
- Үзлэг хийх
- Хүн, тээврийн хэрэгсэл, холбоо, мэдээллийн хэрэгсэл бусад зүйлсийг дайчлан ашиглах
- Хөдөлгөөнийг түр зогсоох, хориглох, хязгаарлах, хаах
- Хорио цээр тогтоох
- Захиргааны хяналт тогтоох
- Албадлагын шинжтэй хяналт шалгалт хийх
- Эд хөрөнгийн үстгал хийх, хураах үйл ажиллагаа орно.

**Захиргааны таслан зогсоох албадлага:** Төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хуульд заасан үндэслэлээр шууд албадах ажиллагааг эрх зүйн зөрчил үйлдэгдсэн болон түүнийг үргэлжлүүлэн гаргахгүй болгох, учирч болох аюулыг таслан зогсоох зорилгоор хэрэгжүүлдэг. Захиргааны таслан зогсоох албадлага нь эрх зүйн шинж, учирч болох хор аюулд нөлөөлөх байдал,

хэрэглэх үндэслэлээрээ захиргааны бусад албадлагаас ялгагдана. Захиргааны таслан зогсоох албадлага хэрэглэх үндэслэл нь нийгэм иргэнд ямар нэг хор аюул учрах нь бодитой болсон, тэдний эрх ашгийг төрөөс хамгаалж уг хор аюулыг хойшлуулшгүй зогсоох шаардлага бий болсон байх явдал байдаг. Тухайлбал, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан согтууран хэвийн бус байдал гаргасан хүнийг эрүүлжүүлэх, эрх зүйн зөрчил гаргасан этгээдийн гадаадад зорчих эрхийг түр хугацаагаар хязгаарлах нь захиргааны таслан зогсоох албадлагын арга хэмжээ болно.

Захиргааны таслан зогсоох албадлагын арга хэмжээг дараах байдлаар авч үзнэ.

Үүнд: - Эрх зүйн эсрэг үйлдлийг албадан таслан зогсоох
- Баривчлах, түр тусгаарлах
- Зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх
- Албадан эмчлэх, хорио цээр тогтоон тусгаарлах
- Үйл ажиллагааг хаах, хориглох, хураах.

Захиргааны таслан зогсоох арга хэмжээ нь нийгэм, иргэдийн эрх ашгийг хамгаалаад зогсохгүй эрх зүйн зөрчил гаргагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, хууль ёсны ашиг сонирхолыг нь хамгаалах ач холбогдолтой байдаг. Захиргааны таслан зогсоох албадлага нь учирч болох аливаа хор аюулаас зайлуулах, мөн зөрчигдсөн эрхийг сэргээн хангах арга хэрэгсэл, зарим тохиолдолд захиргааны зөрчилтэй хэргийг шийдвэрлэх үйл ажиллагааг хангах процессийн шинжийг агуулж байдаг.

**Захиргааны процессийн албадлага:** Захиргааны зөрчилтэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хангах албадлагын арга хэмжээг захиргааны процессийн албадлага гэж ойлгодог бөгөөд энэ арга хэмжээг захиргааны таслан зогсоох арга хэмжээтэй зарим хуульч эрдэмтэд адилтган үздэг тал бий. Хуульч, доктор Ж.Долгорсүрэн "Захиргааны албадлага" нэг сэдэвт бүтээлдээ захиргааны процессийн албадлага нь зорилго, агуулга, үндэслэл, хэрэглэгдэх байдлаараа ялгагдах албадлагын бие даасан нэг төрөл мөн[4] гэж тодорхойлсон. Өмнө дурдсан захиргааны процессийн албадлага нь захиргааны зөрчилтэй хэргийг хугацаанд нь үнэн зөв хянан шийдвэрлэх, захиргааны шийтгэлийн биелэлтийг хангахад чиглэгддэг байна.

[4] Ж.Долгорсүрэн "Захиргааны албадлага" 1999, 86 дахь тал

Захиргааны процессийн албадлага нь дараах онцлог шинжтэй байдаг.

- Эрх зүйн зөрчлийг илрүүлэх, түүний үндэслэл, бүрэлдэхүүн хангалттай байгаа эсэхийг тодруулахтай холбогдон хэрэглэгдэнэ.
- Төрийн эрх барих байгууллагаас захиргааны аль нэг хэрэг, маргаан шийдвэрлэх явцдаа хууль хамгаалах хүрээнд хэрэгжүүлдэг.
- Захиргааны шийтгэлийн биелэлтийг хангах, захиргааны зөрчилд хүлээлгэх хариуцлага тогтоосон эрх зүйн материаллаг хэм хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгыг агуулсан байдаг.
- Хууль зүйн бусад хариуцлага хүлээлгэх нөхцөлийг хангах, түүнд туслах чиг үүрэгтэй байдаг.

Захиргааны процессийн албадлагыг төрөөс эрх олгогдсон байгууллага, албан тушаалтнаас хуульд урьдчилан заасны дагуу хэрэгжүүлнэ.

Захиргааны процессийн албадлагын үйлчлэх шинжээс нь хамаарч эд хөрөнгийн (хөрөнгө битүүмжлэх, хураах, устгах) эд хөрөнгийн бус (үзлэг хийх, захиргааны журмаар албадан саатуулах) гэж хоёр ангилдагийн зэрэгцээ чиг үүргийнх нь хэрэгжих онцлогоор нь захиргааны процессийн таслах зогсоох, нотлох баримт олоход чиглэгдсэн, захиргааны шийтгэлийн биелэлтийг хангахад чиглэгдсэн гэж ангилдаг.

**Захиргааны шийтгэл:** Захиргааны шийтгэл нь төрийн эрх мэдэл бүхий байгууллагуудаас эрх зөрчигчдөд албадлагын нөлөөлөл үзүүлэх хариуцлага хүлээлгэдэг хууль зүйн хэрэгсэл юм. Захиргааны хариуцлагын илрэх хэлбэр нь захиргааны шийтгэл бөгөөд захиргааны албадах арга хэмжээний нэг төрөл болдог.

Захиргааны шийтгэлийн зорилго:

- хууль сахих, эрх зүйн дэг журмыг хүндэтгэх үзлээр хүмүүжүүлэх
- эрх зүйн зөрчил дахин үйлдэхээс уг этгээдийг хамгаалах
- бусад этгээдээс эрх зүйн зөрчил гаргах явдлаас урьдчилан сэргийлэхэд оршино.

**Захиргааны шийтгэлийн агуулга** нь хүний субъектив эрхийг хязгаарлахад хэрэглэгдэн захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдан зохицуулагдах төрийн удирдлагын хүрээн дэх удирдан захирах шинж байдлаар тодорхойлогдоно

Захиргааны шийтгэлд тусгайлан олгосон эрхийг хасах, захиргааны

журмаар баривчлах, торгох, хууль бус орлого эд зүйлийг хураах[1] асуудал хамаардаг бөгөөд тухайн шийтгэлийг гэм буруугийн хэмжээ, эд хөрөнгийн байдал, хариуцлагыг хөнгөрүүлэх буюу хүндрүүлэх нөхцөл байдал, эрх зөрчигчийн үйлдлийн шинж байдлыг харгалзан төрийн эрх мэдэл бүхий байгууллага, албан тушаалтан сонгон ногдуулдаг байна.

Захиргааны шийтгэл ногдуулах эрх бүхий албан тушаалтан нь захиргааны шийтгэлийг сонгохдоо тухайн этгээдийн гаргасан захиргааны зөрчил нь хууль тогтоомжийн ямар заалтыг зөрчсөн, түүнд захиргааны ямар шийтгэл хүлээлгэхээр заасныг үнэн зөв тогтоох, өөрөөр хэлбэл зөв зүйлчлэх /зөрчлийн шинж, бүрэлдэхүүнийг тодорхойлох, хуулийн аль заалтад болон ямар санкцад хамаарахыг хууль зүйн хувьд зөв сонгох/ шаардлагатай юм. Захиргааны шийтгэлийг хэрэглэх түүнийг оногдуулах нь захиргааны процессийн үйл ажиллагаа бөгөөд захиргааны эрх зүйн зөрчилтэй хэргийг шийдвэрлэх журам нь харьцангуй энгийн байх, шударга байх, гагцхүү үнэнийг хангаж тогтоож хууль ёсны шийдвэр гаргах ёстой.

Захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтанд шүүгч, бүх шатны засаг дарга, цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, хилийн төлөөлөгч, гүйцэтгэх ажилтан, хорих ангийн дарга, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч хамаарна. Тэд хуулиар олгогдсон эрх харъяаллын дагуу захиргааны шийтгэлийг хүлээлгэнэ.

Захиргааны эрх зүйн зөрчил гаргагч этгээдэд захиргааны шийтгэл оногдуулахдаа тухайн зөрчлийн шинж байдал, уг зөрчлийг давтан үйлдсэн эсэх, хор хөнөөлтэй эсэх, гэм буруугийн хэмжээ, эд хөрөнгийн байдал, хүндрүүлэх хөнгөрүүлэх байдлыг харгалзан "Захиргааны хариуцлагын тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д заасан захиргааны шийтгэлийн төрөл хэмжээг тодорхойлж зөрчил гаргасан этгээдэд ногдуулна.

[1] "Захиргааны хариуцлагын тухай" хууль 4-р зүйл

# ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Санхүү, Эдийн Засгийн Дээд Сургуулийн*
*Бизнесийн удирдлагын тэнхмийн багш,*
*Хууль зүйн ухааны магистр, Ж.Хулан.*

Олон улсын хөдөлмөрийн эрх зүйн харилцаа гэдэг нь ОУ-ын хөдөлмөрийн эрх зүйн норм, хэм хэмжээгээр зохицуулагдаж байгаа "гадаадын элементийн" хөдөлмөрлөх үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцаа юм.[1] Хөдөлмөрийн харилцаа нь "гадаадын элемент" оролцсон үед л олон улсын шинжтэй болно. Энэ харилцааг дотоодын хууль тогтоомж болон олон улсын хэм хэмжээгээр зохицуулна. Хөдөлмөрийн харилцаанд "гадаадын элемент" нь дараахь байдлаар илэрнэ.

1. Хөдөлмөрийн харилцааны субъект. Жишээ нь, тухайн харилцаанд оролцогч талууд нь гадаадын ажилтан эсвэл гадаадын ажил олгогч байх.

2. Хөдөлмөрийн харилцааны объект. Жишээ нь, тухайн харилцааны талууд нэг ижил иргэний харъяалалтай боловч ажилтны хөдөлмөрлөх үйл явц, түүний үр дүн нь гадаадад бий болдог.

3. Хууль зүйн үйл баримт.Жишээ нь, ажилтан тодорхой хугацаагаар гадаадад амьдарч байгаа үйл баримт нь түүний ажилласан жилийг ямар улсын хуулиар тодорхойлох вэ гэсэн асуудал үүсгэнэ.[2]

Дээр дурьдсан "гадаадын элементүүдээс" аль нэг нь оролцсон хөдөлмөрийн харилцаа нь агуулгаараа олон улсын шинжтэй болдог. ОУ-ын хөдөлмөрийн харилцаа ихэнхдээ ажилтан ба ажил олгогч нарын хооронд ганцаарчилсан хөдөлмөрийн маргаанд үүсдэг. Гэхдээ зарим тохиолдолд Үйлдвэрчний эвлэл хамтын маргаанд оролцох нь цөөнгүй.

Олон улсын хөдөлмөрийг үндсэн 3 төрөлд хуваадаг.

1. Тухайн орны иргэн болон апатрид эх орондоо буюу байнга оршин сууж буй улсдаа гадаадын байгууллагад эсвэл гадаадын хөрөнгө

[1] Корсик М.П. Особенности правового положения иностранных граждан в России. 1998.
[2] Киселев И.Я. Международный труд. 1997.

оруулалттай үйлдвэрийн газар ажиллах. Энэ тохиолдолд хөдөлмөрийн харилцааг тухайн орны дотоодын хуулиар зохицуулна.

2. Хуулийн этгээдийн ба иргэн, апатридын харъялалсан буюу байнга оршин сууж буй улс нь ижил боловч хуулийн этгээдийн үйл ажиллагаагаа явуулж байгаа гадаад оронд ажиллах.
3. Тухайн орны иргэн ба апатрид ажил олох зорилгоор гадаадад гарч ажиллах.[3]

Дээрхи 3 тохиолдол бүрд аливаа нэг улс эсвэл ажил олгогчтой холбоотойгоор "гадаадын ажилтан" гэсэн ойлголт гарч ирж байна. Эхний болон хоёр дахь төрөлд л "гадаадын ажилтан" гэсэн нэр томъёог хэрэглэх боломжтой. Харин гурав дахь төрөл бол "цагаач-ажилтан" гэх ойлголтонд орж байна.

Олон улсын эрх зүйд энэ талаар тогтсон нэр томъёо одоогоор байдаггүй бөгөөд хөдөлмөрлөхтэй холбоотой цагаачлалын асуудлыг судалдаг Английн эрдэмтэн П.Стокер цагаачлалыг 5 хувааж үзсэн байна. Үүнд; шилжин суурьшигчид, гэрээгээр ажиллагсад, өндөр мэргэжлийн ажилтнууд, хууль бусаар цагаачлагчид, дүрвэгсэд болон улс төрийн орогнол хүсэгчид. П.Стокер "цагаач-ажилтан" гэх нэр томъёог хэрэглээгүй ч энэ ойлголтонд тусгай мэргэжлийн болон мэргэжилгүй улирлын шинжтэй ажил хийдэг гэрээгээр ажиллагсад болон өндөр боловсролтой, ажлын туршлага, ур чадвартай голдуу үндэстэн дамнасан корпорацуудын ажилтнуудыг багтааж байна.

"Гадаадын ажилтан" гэх ойлголтонд багтадаггүй бүлэгт; дипломат болон олон улсын байгууллагын ажилтнууд, гадаадад суралцагч оюутнууд, томоохон бизнес эрхлэгчид, дүрвэгсэд болон улс төрийн орогнол хүссэн хүмүүсийг хамааруулж байна. Учир нь тэдгээрийн эрх зүйн байдлыг хөдөлмөрийн эрх зүйгээр бус харин олон улсын хэм хэмжээ, тусгайлсан дотоодын хууль тогтоомж, эсвэл илгээгч орны хуулиар зохицуулдаг.

Ийнхүү судлаачдын ангилал нь олон янз байж болох бөгөөд энэ нь олон улсын хөдөлмөрийг олон талт, өргөн хүрээтэйг харуулж байна. Судлаачдын гадаадын иргэдийг бүлэг болгон ангилах нь бүлэг тус бүрийн эрх зүйн байдлыг болон бүлэг тус бүрийн онцлогт тохируулсан эрх үүргийг

---

[3] Киселев И.Я. Международный труд. 1997.

тодорхойлох ач холбогдолтой юм. Хэдийгээр паспортын дэглэм, цагаачлалын хууль зэрэг эрх зүйн тогтвортой институт байдаг боловч олон улсын байгууллага нэгдсэн, нийтээр хүлээн зөвшөөрсөн уг харилцааг зохицуулах олон улсын эрх зүйн үндсийг бий болгож чадаагүй байна.
Үүнээс үндэслэн олон улсын хөдөлмөрийн харилцааг зөрчилдөөний хэм хэмжээгээр зохицуулах ач холбогдол нэмэгдсээр байна.

Хөдөлмөрийн эрх зүй дэх зөрчилдөөний хэм хэмжээ нь Баруун Европын орнуудад сүүлийн арван жилд эрчимтэй хөгжиж байна. Олон улсын хөдөлмөрийн харилцааг зохицуулахад улс орон бүр янз бүрийн Хөдөлмөрийн хуультай байдагтай холбогдон аль улсын хуулийг хэрэглэх талаар хэм хэмжээ, бүтцийг боловсруулж байна. Зөрчилдөөний асуудал нь зөрчилдөөний хэм хэмжээний тусламжтайгаар аливаа нэг тодорхой хөдөлмөрийн харилцааг зохицуулахад хоёр ба түүнээс дээш орны хуулиудаас аль нэг улсын хуулийг хэрэглэхээр сонгох үед гарч ирдэг. Гэхдээ зөрчилдөөний хэм хэмжээ нь дангаараа эрх зүйн харилцааг зохицуулдаггүй бөгөөд тухайн орны дотоодын хууль тогтоомжийн материаллаг хэм хэмжээг ишлэл болгодог. Ийнхүү олон улсын хөдөлмөрийн харилцааг дан ганц зөрчилдөөний хэм хэмжээгээр бус мөн материаллаг хэм хэмжээгээр зохицуулах шаардлага гардаг.

Хуулийн зөрчилдөөний асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар Олон улсын хувийн эрх зүйгээр судалдаг. Зөрчилдөөний хэм хэмжээний эхний хэсэг буюу зохицуулах гэж буй эрх зүйн харилцааг тодорхойлсон хэсгийг зөрчилдөөний хэм хэмжээний "хүрээ" гэх ба тухайн харилцаанд хэрэглэгдэх эрх зүйг (аль орны хуулийг) заасан хоёр дахь хэсгийг зөрчилдөөний хэм хэмжээний "зүүлт" гэнэ. Жишээ нь, Монгол улсын иргэн X болон БНСУ-ын нэгэн компанийн хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээнд "ажил олгогчийн хуулийг" хэрэглэнэ гэсэн зөрчилдөөний хэм хэмжээний "хүрээ" нь хөдөлмөрийн гэрээ, харин "зүүлт" нь ажил олгогчийн хууль буюу БНСУ-ын хөдөлмөрийн хуулийг хэрэглэнэ гэсэн үг юм.

Олон улсын хөдөлмөрийн харилцааг зохицуулдаг зөрчилдөөний үндсэн 3 арга байдаг.

- Ажлын газрын хуулийг хэрэглэх зарчим буюу Lex Loci Laboris.
- Талууд хуулиа сонгох зарчим буюу Lex voluntatis.
- Тухайн тодорхой харилцаатай нягт холбоотой хуулийг хэрэглэх зарчим.

Ихэнхи орнууд тухайлбал, Австри, Испани, Швейцарь, Нидерланд нь "ажлын газрын хуулийг" хэрэглэх зарчмыг сонгосон байна. Өөрөөр хэлбэл тухайн ажил хийгдэж байгаа улсын хуулийг хэрэглэнэ гэсэн үг. Хэрэв тухайн хүнийг ажиллуулж байгаа үйлдвэрийн газар болон удирдлага нь өөр өөр оронд байрлаж байгаа бол тухайн хүнийг ажиллуулж байгаа үйлдвэрийн газрын байрлаж буй улсын хуулийг ойлгоно.

АНУ, Англи, Итали, ХБНГУ, Канад, Швец зэрэг орнууд "талууд хуулиа сонгох зарчмыг" хэрэглэдэг байна. Энэ нь хөдөлмөрийн гэрээний талууд өөрсдөө хэрэглэх хуулиа сонгох хэлбэрээр илэрнэ. Гэхдээ гэрээний талуудын үндэсний хууль тогтоомжинд хуулиа сонгохыг зөвшөөрөөгүй императив шинжтэй хэм хэмжээ байвал дээрхи хэлцэл хүчингүй юм.

Хэдийгээр эхний хоёр зөрчилдөөний аргыг хөгжингүй орнууд хууль, шүүхийн практикт хэрэглэдэг боловч тодорхой нэг тохиолдолд гурав дахь зарчим буюу "тухайн тодорхой харилцаатай нягт холбоотой хуулийг хэрэглэх зарчмыг" сонгох нь сүүлийн үед түгээмэл байна. Энэхүү зарчмыг хэрэглэхэд талуудыг холбох дараахь хүчин зүйлүүдийг харгалздаг. Үүнд; ажлын байрны оршин байгаа газар, үйлдвэрийн газрын болон байгууллагын удирдлагын оршин байгаа газар, талуудын иргэний харъяалал ижил байх, үйлдвэрлэлийн зааварчилгааг хаанаас авч байгаа эх үүсвэр, хөдөлмөрийн хөлсөө хаанаас авч байгаа эх үүсвэр болон ямар валютаар авч байгаа, хөдөлмөрийн гэрээг ямар улсын хэлээр бичсэн зэрэг болно. Жишээ нь, компаний болон ажилтны харъяалал нэг бөгөөд ажилтан нь өөрийн компанийн оршин буй газрын орноос өөр газар томилогдон, компанийн ажлыг гүйцэтгэж байвал ажилтны эрх, үүргийг тодорхойлсон хөдөлмөрийн гэрээг компанийн оршин буй газрын орны хуулиар зохицуулна.

Талууд хоорондоо хэрэглэх хуулиа сонгоогүй тохиолдолд шүүгч нь дээр дурьдсан зөрчилдөөний аргын аль нэгийг хэрэглэдэг. Хэрэв ажилтан ажил үүргийн хуваарийн дагуу нэгээс дээш тооны улсад ажилладаг бол (жишээ нь олон улсын менеджер) тухайн хүнд ажил олгогчийн гол үйл ажиллагаагаа явуулдаг, эсвэл ажилтны ихэвчлэн ажлаа гүйцэтгэдэг орны хуулийг хэрэглэдэг.

Олон улсын хөдөлмөрийн маргаанд зөрчилдөөний ямар хэм хэмжээг хэрэглэх нь аль орны шүүхийг маргаанаа хянан шийдвэрлүүлэхээр сонгосноос шууд шалтгаалдаг. Энэ нь шүүхийн ач холбогдол их гэдгийг

харуулж байна. Ихэнхи орнуудад аливаа иргэний болон хөдөлмөрийн маргааныг тухайн маргаан гарах болсон тохиолдолтой илүү нягт холбоотой улсын шүүх хянан шийдвэрлэх ёстой гэсэн зарчмыг баримталдаг байна. Дараагийн нэг жишээ авъя, монголын иргэн А америкийн нэгэн IT-компанид ажилладаг ба ажлаа монголдоо интернетеер явуулдаг гэж бодъе. Тэгвэл энэ хөдөлмөрийн харилцааг хэрхэн зохицуулах вэ? "Ажлын газрын хуулийг хэрэглэх" зарчмаар бол Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийг баримтална. "Тухайн тодорхой харилцаатай нягт холбоотой хуулийг хэрэглэх" зарчмаар бол хөдөлмөрийн хөлсөө америкаас авдаг гэдгээр АНУ-ын хөдөлмөрийн харилцаатай холбоотой хуулийг хэрэглэнэ гэсэн үг юм. Гэтэл жишээн дээр дурьдсан хөдөлмөрийн харилцааг зохицуулсан зөрчилдөөний хэм хэмжээ манай улсын Хөдөлмөрийн хуулинд байдаггүй. Монгол улсын Хөдөлмөрийн хуулинд зөрчилдөөний хэм хэмжээг тусгаагүй нь монголын болон гадаадын иргэн оролцсон олон улсын хөдөлмөрийн харилцааг зохицуулахад цаашид бэрхшээлтэй асуудлууд үүсэхийг үгүйсгэхийн аргагүй юм. Иймээс манай улс Хөдөлмөрийн хуулиа боловсронгуй болгох үүднээс олон улсын хууль, шүүхийн практикт өргөн хэрэглэгддэг зөрчилдөөний аргуудыг тусгаж өгөх нь зүйтэй юм.

### Ашигласан материал;


1. Международное публичное и частное право. (16) 2004.
2. И.Я. Киселев. Сравнительное и международное трудовое право. 1999.

# БАГШИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЛДАРЫГ ЁСЛОН ТЭМДЭГЛЭВ



Монгол Улсын гавъяат хуульч, хуль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Шихихутуг ХЗДС-ийн зовлох багш Г.Совдын хөдөлмөрийн алдарыг ёслон тэмдэглэх үйл ажиллагаа энэ оны 4 дүгээр сарын 6-ны өдөр Шихихутуг ХЗДС-д болов.

Ёслолын ажиллагааг тус сургуулийн захирал, дэд профессор Д.Оюунцэцэг нээж үг хэлэв. Ёслолын ажиллагаанд Шихихутуг ХЗДС-ийн үүсгэн байгуулагчийн нэг, Монгол Улсын Их Хурлын дэд дарга, шинжлэх ухааны доктор, профессор Д.Лүндээжанцан, сургуулийн удирдах зөвлөлийн дарга, шинжлэх ухааны доктор, профессор Ч.Энхбаатар, тэнхимийн эрхлэгч, академич Ж.Болдбаатар, шинжлэх ухааны доктор, профессор О..Амархүү, сургуулийн бусад багш нар, оюутан, магистрант нар оролцов. Мөн урилгаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Монгол Улсын гавъяат хуульч, доктор (Ph.D) Н.Жанцан, МУИС-ийн Хуулийн сургуулийн ректор, академич С.Нарангэрэл, тус сургуулийн багш доктор (Ph.D), профессор Т.Мөнхжаргал, Ж.Бямбаа, Отгонтэнгэр Их Сургуулийн дэд захирал, шинжлэх ухааны доктор, профессор Л.Баасан, Цагдаагийн Академийн дэд захирал, доктор (Ph.D), профессор Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Оюуны өмчийн газрын дарга, профессор Н.Чинбат нарын зэрэг эрдэмтэд, Дэлхийн банкны "Шүүх эрх мэдэл, эрх зүйн шинэчлэл" төслийн зохицуулагч Д.Оюунчимэг нар оролцож баяр хүргэж үг хэлэв.

Хөдөлмөрийн алдарыг ёслон тэмдэглэж байгаатай холбогдуулан Г.Совд багшийн ажил, амьдралын түүхэн замнал, өнөөгийн хөдөлмөр, зүтгэлийн талаар "төрийн нэрт түшээ", "алдарт багш, сурган хүмүүжүүлэгч", "хууль зүйн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр" сэдвээр Д.Лүндээжанцан,

О.Амархүү, багш Б.Бат-Ерөөлт нар илтгэл тавьж, Г.Совд багшийн амьдрал ахуйн холбогдолтой гэрэл зургийн болон түүний эрдэм номын бүтээлийн үзэсгэлэн гаргав. Мөн Шихихутуг ХЗДС-ийн оюутан, магистр нарын төлөөлөгчид Г.Совд багшдаа баяр хүргэн үг хэлж, бэлэг дурсгалын зүйл гардуулав.

Ёслолын ажиллагааны төгсгөлд тус сургуулийн захирал, дэд профессор Д.Оюунцэцэг багш Г.Совдод алд цэнхэр хадаг, мөнгөн аягатай сүү барьж, урт удаан насалж, эрүүл энх байж, эрдэм номынхоо арвин хураас бид бүхэндээ үргэлж түгээн буулгаж явахыг хүсэн ерөөж, хүндэтгэлийн өргөмжлөлийг мөнгөн шагналын хамт гардуулав.

Тус сургуулийн магистр багш Б.Бат-Ерөөлтийн санаачилсан Эрүүгийн эрх зүйн иж бүрэн кабинетыг шинээр тохижуулан тоноглож сургалтад оруулах, түүнчлэн нэгдүгээр курсын хэсэг оюутны санаачилсан "судалгаа, илтгэх ур чадвар, мэдээллийн" үйл ажиллагаа эрхлэх "ГЭРЭГЭ" клубын нээлт үг ёслолын ажиллагааны үеэр болж Г.Совд багш оролцон сурлага, эрдэм номын их амжилт олохыг ерөөж үг хэлэв.

## ТӨРИЙН ТУЛХТАЙ ТҮШЭЭ

Г.Совд багш маань дуудах нэрээс гадна дуурсагдах нэртэй нэгэн билээ. Монгол Улсын гавъяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор хэмээх алдар хүнд, эрдмийн зэрэг, цолыг багш маань төр, түмэндээ чин үнэнчээр зүтгэсэн олон жилийнхээ шударга хөдөлмөрийн үр шимээр хүртэснийг бахархан тэмдэглэх ёстой гэж бодож байна.

Г.Совд багш монголын мянга мянган үр садад эрдэм номын хичээл, сургаалаа хайрласан, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын оргил өөд бартаат зам мөрөөр олон жил авиран мацсан нэр цуут багш, сурган хүмүүжүүлэгчээс гадна манай төрийн нэн чухал сабаруудад доороос нь дээр нь хүртэл төрийн албыг хашиж залгуулсан төрийн тулхтай түшээ мөн гэдгийг Монгол түмэн төдийгүй дэлхийн олон улс орнуудад андахгүй мэднэ.

Төрийн албанд зүтгэсэн түүний анхны гараа одоогоос 50 гаруй жилийн тэртээд Увс аймгийн прокурорт мөрдөн байцаагчийн ажлаас эхэлсэн түүхтэй юм байна. Тэр үед Совд багш маань тусгай мэргэжлийн дунд болон дээд боловсрол эзэмшиж амжаагүй, ердөө л цэргийн хугацаат албыг дүүргэсэн, хөдөөгийн нэгэн сайн бичиг үсэгтэн залуу байжээ. Энэ бол 1954-1956 оны хоёр жилийн хугацаа. Ажиллах хугацаанд уг залуугийн авъяас, чадвар танигдаж, ирээдүйн сайн хуульч болох зам мөр нь тодорч эхэлсэн учир түүнийг Улаанбаатар хот дахь Хууль цаазны дунд сургуульд томилолтоор суралцуулж хууль цаазны тусгай дунд боловсрол эзэмшиж, улмаар одоогийн ОХУ-ын Свердловскийн хуулийн дээд сургуулийг дүүргэснээр хуульчийн харгуй нь шулуудсаныг дашрамд дурдах нь зүйтэй.

Сонирхолтой нэгэн баримтыг иш татья. Г.Совдыг Свердловскийн хуулийн дээд сургуулийн төгсөх ангид суралцаж байх үед, тодруулбал 1962 онд Монгол Улсын Дээд Шүүхийн гишүүнээр Ардын Их Хурлын Тэргүүлэгчид томилж, энэ тухай өөрт нь мэдэгдэж байсан байна. Тэрээр оюутны өвлийн амралтаар нутагтаа ирээд Улсын Дээд Шүүхийн гишүүний үүрэгт ажлаа хэсэг хугацаанд хийж цалин авч, сургуульдаа буцаж очин төгсөж ирээд 1964 он хүртэл уг ажлаа үргэлжлүүлэн хийсэн байх юм.

Г.Совдыг МУИС-д тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байхад нь тухайн үеийн практик ажлын хэрэгцээ, эрүүгийн нөхцөл байдлаас хамааруулан

Улсын Дээд Шүүхийн нэгдүгээр орлогч дарга бөгөөд Эрүүгийн коллегийн даргаар томилж, 1974-1978 он хүртэл ажлуулжээ. Дараа нь энэ ажлаас нь шилжүүлэн Улсын Прокурорын нэгдүгээр орлогчийн үүрэгт ажилд тохоон томилсон байна.

Шүүх, прокурорын системд Г.Совд багшийн ажилласан жилүүдэд тэдгээр байгууллагууд төв, орон нутагт аж ахуй, зохион байгуулалтын хувьд бэхжиж, хуульч мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаж, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, хяналтын үйл ажиллагааг шуурхай, хууль ёсны дагуу хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг шүүхээр хангаж хамгаалах, шударга ёсны шүүх ажиллагааг дэмжин дэлгэрүүлэх зэрэг үр бүтээлт арга ажиллагаанд ахиц, дэвшил гарч байсныг түүх гэрчилнэ.

Хуулийн төсөл боловсруулах, тухайн үед тогтож хэвшсэн хууль тогтоох эрх мэдлийн тогтолцооны хүрээнд ажлын чанарыг сайжруулах амьдралын шаардлагын үүднээс онол, практикийн өндөр мэдлэг, чадвартай боловсон хүчнээр Монгол Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албыг бэхжүүлэх зайлшгүй хэрэгцээ тулгарч байсан байна. Иймийн учир Г.Совдыг Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн газрын Хуулийн хэлтсийн даргаар 1979 онд томилон энэ албан тушаалд 5 жил ажиллажээ. Дурдсан хугацаанд БНМАУ-ын Ардын Их Хурлын Регламент, Сайд нарын Зөвлөлийн тухай хууль, Ардын хяналт шалгалтын тухай Бүх Ард нийтийн цэргийн үүргийн тухай хууль, Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн тухай хууль, Ардын боловсролын тухай хууль, Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн тэтгэврийн тухай хууль зэрэг хэд хэдэн томоохон хууль батлагдсан байна. Эдгээр хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлахад Г.Совд багшийн хүч, хөдөлмөр, мэдлэг, чадвар ихээхэн хувь нэмэр оруулсныг тэмдэглэвэл зохино.

Онцлон хэлэх нэг зүйл бол манай нийгмийн хөгжлийн тухайн үе шатанд хуулийн төсөл санаачлах, боловсруулах, хэлэлцүүлэх, батлах зэрэг хууль бүтээх үйл ажиллагаанд тэр үеийн Шүүх яам, Сайд нарын Зөвлөл, Ардын Их Хурлын Тэргүүлэгчид үлэмж үүрэг роль гүйцэтгэдэг түүхэн онцлогтой байлаа. Г.Совд багш маань тэр үеийн Шүүх яамны сайд асан Б.Чимэд, О.Жамбалдорж, Сайд нарын Зөвлөлийн хэрэг эрхлэх газрын хуулийн хэлтсийн дарга асан О.Амархүү нарын зэрэг хуульч эрдэмтэдтэй хууль бүтээх арга ажиллагаанд санаа сэтгэл, гар бие, хүч хөдөлмөрөө нэгтгэж, эвсэг,

ухаалаг, нөхөрсөг, зарчимч байр сууринаас хамтран ажиллаж зохих амжилтад хүрч байсан юм. Энэ нь түүний удирдан зохион байгуулах, хүнтэй ажиллах авъяас, чадварын бас нэг илрэл гэж хэлж болно.

Төрийн тулхтай түшээ мөн болохоо харуулсан хамгийн тод нэг жишээ бол Г.Совд Монголын төрийн түүхэнд ардчилал, зах зээлийн эдийн засгийн шинэчлэлийн эхэн үеэс анх удаа байгуулагдан ажилласан Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн анхны бүрэлдэхүүнд гишүүнээр томилогдож улмаар Цэцийн анхны даргаар хуульд заасан хоёр удаагийн бүрэн эрхийн хугацаанд ажилласан явдал мөн. Энэ бол 1992-1998 он юм:

Төрийн дээд, тэр тусмаа цоо шинээр байгуулагдсан бөгөөд өндөр үүрэг хариуцлага хүлээсэн, улс орныхоо Үндсэн хуулийн зүйл, заалт бүрийг сонор сэргэгээр манаж хамгаалах нэр хүндтэй энэ албыг төр тохиолдлоор хэн хүнд итгэн хариуцуулахгүй нь мэдээж билээ. Үндсэн хуулийн цэцийн даргын өндөр албан тушаалыг Г.Совд 6 жил хашихдаа холбогдох хуулиудыг чандлан мөрдөж, эрх бүхий субъектүүдийн батлан гаргасан хууль, эрх зүйн бусад акт Үндсэн хуультай зөрчилдөж байгаа гэсэн асуудлаар иргэдээс ирүүлсэн олон арван өргөдөл хүлээн авч хянан магадалж дүгнэлт гаргах нарийн түвэгтэй ажилд оюун ухаан, мэдлэг, чадвараа харамгүй дайчлан омтгойдолгүй ажилласныг цохон дурдах нь зүйтэй. Тэр бүхнийг баримт жишээгээр дурдан тоочвол их ээхэн урт түүх болж, цаг их шаардах учир энэ удаад үүгээр товчлоё.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын хоёр дахь удаагийн бүрэн эрхийн хугацаа дуусан 1998 онд Г.Совдыг уг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцсэн Улсын Их Хурлын чуулган Үндсэн хуулийн цэцийн анхны гишүүн, анхны даргаар үр бүтээлтэй ажилласан Г.Совдод үйл ажиллагааных нь төлөө Улсын Их Хурлын нийт гишүүдийн өмнөөс талархал илэрхийлж, дараа дараагийн ажил үйлс нь улам өөдрөг байхын ерөөлийг дэвшүүлж тэр үеийн УИХ-ын дарга Р.Гончигдорж Совд гуайг үг хэлэхийг урьж байсан баримт одоо ч манай архивт байгаа билээ. Г.Совд тэрхүү чуулганд хэлсэн үгэндээ "намайг ажиллаж байх хугацаанд түшиж тулж ажилласан Улсын Их Хурлын бүх гишүүн та бүхэнд чин сэтгэлээсээ талархсанаа илэрхийлж байна" гээд "Монгол төрийн жинхэнэ албан хаагчийн алтан соёмбот зодгийг тайлах ёсыг би гүйцэтгэх ёстой. Үүнийг энэ алд цагаан хадгаар төлөөлүүлж Монгол Улсын Их Хурлын гишүүд Та бүхэнд өргөн барья. Хүлээн авна уу." хэмээсэн нь төрт ёсоо дээдлэн хүндэлж, төрийн жинхэнэ

албан хаагчийн ёс зүйг жудаглан сахигч төрийн түшээ асан Г.Совд багшийн маань сайхан чанар, үлгэр дуурайллын нэгэн шинж болой гэж хэлээд би үгээ дуусгая.

***Г. Совд багшдаа хамгийн сайн сайхны ерөөлийг дэвшүүлье.***

Анхаарал тавьсанд баярлалаа

Шихихутуг ХЗДС-ийн эрдмийн зөвлөлийн дарга, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Д.Лүндээжанцан

# МАНАЙ БАГШИЙН АЛДАР

Монголын мянга мянган хуульчидын багш, бас багшийн багш, Монгол Улсын гавъяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор-энэ бол манай Г.Совд багшийн алдарын хамгийн хураангуйлсан тодорхойлолт мөн.

"Багш" гэж олноо өргөмжлөгдсөн цол, "багш аа" гэж дуудах хүндэтгэлийн үг бол Монгол хүний сэтгэлгээний өвөрмөц илрэл, энэрэл хайрлалын эрхэм бэлэгдэл, мэдлэг, мэргэжлийн цар хүрээний нэгэн хэмжүүр гэж хэлж болно.

Оюун сэтгэлгээний энэ их хүндэтгэлийн түүхэн зам мөрийг манай Г.Совд багш ид залуу зандан 28 насандаа буюу 1958 онд Улаанбаатар хотын хууль цаазны дунд сургуульд багшилж эхэлсэн тэр цагаас тодруулан хөтөлж, өдгөө 50 шахам жилийнхээ нүүртэй золгож явна. Багшийн ажил үргэлжилж МУИС-ийн хуулийн салбарт 1964 оноос тэнхимийн эрхлэгч, багшийн эрдэм мэдлэг, ур чадварт хүчээ дайчилсаар даруй 40 гаруй жил болж байна. Г.Совд багш маань энэ хугацаанд МУИС, Удирдлагын академи, Шихихутуг ХЗДС, Улаанбаатар эрдэм судлал ХЗДС-д багш, зөвлөх багш, тэнхимийн эрхлэгч зэрэг оюунлаг, эрдэмжсэн ажил үйлсийг дангаар буюу хавсран гүйцэтгэсээр ирсэн түүхэн алдар гавьяатай хүн юм.

Монголын төрийн үйл хэргийг хамжилцах, түшилцэх, аж ахуй, нийгэм, соёл, шинжлэх ухааны аль ч салбарт төрийн хууль цаазыг омтгойтолгүй даган мөрдүүлэх, иргэний эрх, эрх чөлөөг нандигнан хамгаалах томоохон үйлсийг гардан хэрэгжүүлэгч үндэсний хуульч мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан бэлтгэх ариун үйл хэрэгт амьдралынхаа тал хувийг тасралтгүй зориулж, тод мэдрэгдэх, товойж харагдах амжилт бүтээлтэй хүн хэн бэ гэвэл Увс аймгийн Завхан сумын малчин ард Галдан гуайн гэр бүлд 75 жилийн тэртээ мэндэлж Совд хэмээх нэрийг эцэг эх, лам багшаасаа хүртсэн, өдгөө бид бүхэнтэйгээ мөр зэрэгцэн суугаа буурал өвгөнөө харахад хэн бүхний сэтгэл бадран, ухаан санаа уужран сарүүлсаж хүндэтгэл, хайрлалын оч цог гялалзаж байгааг бахдан хэлэхэд нэн тааламжтай байна.

Г.Совд багшийн унаган шавь нар өнөөдөр монголын хуульчдын нэр хүндийг эх орондоо төдийгүй, дэлхий дахины олон улс оронд өндөрт өргөн

авч явсаар байна. Төр засгийн дээд байгууллагаас эхлээд хууль, хяналтын бүх шатны байгууллага, боловсрол, шинжлэх ухааны салбарт түүний шавь нарын мэдлэг чадвар, хүч, авьяас өдрөөс өдөрт тодрон гарсаар байгааг тэмдэглэн хэлэхгүй байхын аргагүй юм. Улсын Их Хурлын дэд даргын өндөр албан тушаалыг хашиж буй шинжлэх ухааны доктор, профессор Д.Лүндээжанцан, хуульд заасан хугацаат, ээлжит албаа амжилттайгаар саяхан дуусгаад байгаа Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дарга, одоо мөнхүү Цэцийн гишүүн Н.Жанцан нар бол Г. Совд багшийн унаган шавь нар юм. Төрөө түшилцсэн УИХ-ын эрхэм гишүүдээс мөнхүү багшийн шавь хэд хэд байсан, байгааг бид мэднэ.

Г.Совд багшийн шавь нараас өнөөдрийн байдлаар түүхийн шинжлэх ухааны эрдэмтэн Ж.Болдбаатар, хууль зүйн шинжлэх ухааны эрдэмтэн С.Нарангэрэл, Ж.Амарсанаа гэсэн гурван академич, И.Дашням, Т.Сэнгэдорж, О.Амархүү, Л.Баасан, Д.Лүндээжанцан, Н.Лүндэндорж, С.Төмөр нарын хууль зүйн шинжлэх ухааны доктор 7, хууль зүйн ухааны буюу боловсролын доктор 20-иод хүн төрөн гарчээ. Эдгээрийн дотроос Д.Лүндээжанцан, С.Нарангэрэл, Ж.Амарсанаа нарын шинжлэх ухааны докторын ажлын зөвлөхөөр, мөн дэд доктор 3 хүний эрдэм шинжилгээний ажлын удирдагчаар Г.Совд багш ажиллаж, эрдмийн зэргийг тус тус амжилттай хамгаалуулжээ.

Багш маань өөрөө томоохон судлаач эрдэмтэн гэдгийг дотоод, гадаадад сайн мэддэг билээ. Тэрээр нэг сэдэвт зохиол, сурах бичиг, гарын авлага зэрэг 23 ном, эрдэм шинжилгээний 70 өгүүлэл бичиж тууриван нийтийн хүртээл болгосны зэрэгцээ олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, симпозиумд 4 удаа илтгэл тавьж хэлэлцүүлсэн юм. Энэ бүхэн Монголын эрх зүйн сэтгэлгээг шинжлэх ухааны эргэлтэд оруулахад Г.Совд багшийн маань гүйцэтгэсэн жинтэй хувь нэмэр гэж зүй ёсоор хэлэх ёстой.

Түүнчлэн Г.Совд багшийн шавь нараас хууль зүйн салбарт хөдөлмөр, бүтээл зүтгэл, алдар хүндээрээ бусдаасаа ялгаран тодорч төрийн эрхэм дээд шагнал "Монгол Улсын гавъяат хуульч" цол хүртсэн 18 хүн байгаа билээ.

Дээрх эрдэмтэд, гавъяатнууд өөр өөрсдийн оюун ухаан, хичээл зүтгэл, хөдөлмөр бүтээлийн үр шимээ илтгэн харуулсан ч гэсэн эрдэм номын нөр их бартаат зам мөрд хөтөлсөн Г.Совд багшийн нөр их хөдөлмөр, зүтгэл, хувийн үлгэр жишээ, хүнлэг сайхан мөс чанар, сурган хүмүүжүүлэх авъяас

чадвар, төлөв түвшин зан айл, хувиршгүй ноён нуруу, ёс суртахууны эрхэм нандин дуурайлал зэрэг нь мартагдашгүй ач буянаа өгсний давхар давхар баталгаа гэж хэлэхэд эргэлзэх хүн гарахгүй гэдэгт итгэл дүүрэн байна.

Г.Совд багш бол эрдэм номын үе үеийг дамжсан багш нарын багш хүн гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй. Энэ бол Г.Совд багшийн шавь нараас түмэн олны үр садад эрдэм номын шимийг түгээн хүртээх хувь тавилангаараа багш болсон, бас тэр багш нарын шавиудаас мөн л багш нар төрж байгаа тасралтгүй хөврөх залгамж холбоог хэлж байгаа бөлгөө. МУИС-ийн Хуулийн сургууль гэхэд л Г.Совд багшийн шавь Ж.Болдбаатар, Б.Чимид, Т.Сэнгэдорж, С.Нарангэрэл, Ж.Амарсанаа, Л.Баасан, Т.Мөнхжаргал, Ж.Бямбаа, Чинбат гээд манай нэр цуутай багш нар одоо ажиллаж байна. Эдгээр багш нарын шавиудаас олон залуу багш нар бас төрөн гарсаар байгаа билээ.

Шихихутуг ХЗДС-ийг мөн нэгэн жишээ болговол Г.Совд багшийн шавь Д.Лүндээжанцан, О.Амархүү, Д.Оюунцэцэг зэрэг багш төрж, тэдний шавь нараас багш гэхэд л Д.Оттонтуяа, Ц.Цэлмэг, С.Оюунбилэг, Г.Амаржаргалан, Ж.Наранпүрэв, М.Батсуурь, Ч.Онөрбаяр, Ч.Эрхэмбаяр гээд өч төчнөөн шижигнэсэн залуу багш нар бий болоод байна. Эдний шавь нараас бас л багш нар гарч ирсээр байх болно.

Г.Совд багш маань дээд боловсролтой хуульч мэргэжилтэй боловсон хүчнийг Монголдоо хувийн хэвшлийн сургуулиар бэлтгэх шинэ ажлын анхны хошуучлагч нь болж, тавьсан зорилгодоо цагийн шалгарлыг давж амжилттай хүрч яваа Шихихутуг ХЗДС-д 10 гаруй жил зөвлөх багшаар оюутан, магистр, багш нартай эрчимтэй ажилласаар бид бүхэндээ ач буянаа өгсөөр байна.

Омнө өгүүлсэн бүхнээ нэгтгэн цэгнэж, монгол хүний экологийн сэтгэлгээний үүднээс дүгнэж үзвэл, Г.Совд багш маань "монголын хууль зүйн ертөнцөд уул ус нь юм" гэж бахдан бардам хэлж болно.

Багшдаа сөгдөн мөргөмүү. Багшийн маань эрдэм чадал, эрч хүч, эр зориг, эрхэм сайхан зан чанар Та бидэнд наран мэт гийж байх болтугай.

Анхаарал тавьсанд баярлалаа

Шихихутуг ХЗДС-ийн Тэнхимийн эрхлэгч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор О.Амархүү

## ХУУЛЬ ШИНЖЛЭХ УХААНД Г.СОВД БАГШИЙН ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

Оюун-ухааны их харгуйд түмэн олон шавиа хөтөлсөн эрхэм хүндэт багш таны болон энд хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт зочид төлөөгчид, эрдэмтэн профессор, багш, оюутан магистр та бүхний хаан амрыг мэдэж хатан амгаланг айлтгая.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор профессор, Монгол Улсын Гавъяат хуульч Совд багшийнхаа хууль зүйн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийн талаар та бүхний сонорыг мялаах үг хэлэх ахадсан хүндтэй үүргийг миний бие хүлээгээд байна. Энэ хүний бүтээсэн туурвисан, цогцлоон байгуулсан бүхнийг судлан энд ярина гэвэл цаг хугацааны хувьд ч тэр мөхөс миний оюун хүрэлцэхгүй гэдэгт та бүхэн надтай санал нэгдэх буй за.

Гэвч Совд багшийн хууль зүйн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийн талаар өөрийн олж мэдсэн, ахмадууд та бүхний зааж зөвлөсөн зарим нэг зүйлийг хураангуйлан товчловол, сурах бичиг, ном, нэг сэдэвт бүтээл-23, эрдэм шинжилгээний өгүүлэлүүд 70, олон улсын хурал, симпозиумд тавьсан илтгэл 5 байна. Эндээс би багшийн бүтээлүүдийг гурван чиглэлээр авч үзэх нь зүйтэй байх гэсэн бодолтой байгаа юм.

Совд багшийн бичиж туурвисан сурах бичиг, нэг сэдэвт эрдэм шинжилгээний зохиол болон бусад бүтээлүүдийг судлан үзэхэд эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны чигэлэлээр бичсэн ном, сурах бичиг 12 байна. Хамгийн сүүлийн жишээ дурьдахад 2002 онд баталагдсан Монгол Улсын шинэ эрүүгийн хуулийг тайлбарласан "Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар" бүтээл нь шинээр батлагдсан Эрүүгийн хуулийг амьдралд зөв хэрэглэх, нэг мөр ойлгоход судлаач, эрдэмтэд төдийгүй, хуулийн практикт өргөн ашиглагдаж байгаа томоохон хэмжээний бүтээл мөн гэж судлаач-эрдэмтэд санал нэгтэй хүлээн зөвшөөрч байгаа юм. Мөн багш Эрүүгийн эрх зүйн чиглэлээр 26 эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн нь нийт эрдэм шинжилгээний өгүүлэлийн дотор чухал байр суурь эзэлж байна.

Эндээс үзэхэд Совд багш маань Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны салбарт хуульчид, шавь нараа хөтлөн дагуулсан охь манлай хүн гэж хэлж болно. Эндээс би нэг жишээг онцолмоор байна. Г.Совд багш

1965 онд "БНМАУ-ын эрүүгийн эрх /тусгай анги/" сурах бичиг бичиж хэвлүүлсэн нь Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухааны салбар дахь анхдагч бүрэн хэмжээний сурах бичигт тооцогддог ба МУИС-ийн ХЗДС-ийн 2 дахь удаагийн төгсөлт энэхүү сурах бичгээр улсын шалгалтаа бэлдэж амжилттай өгч байсан түүхийн гялбаа бийг олон арван хуульчид дурсан санаж байдаг юм байна. Энэхүү сурах бичиг одоо ч гэсэн үнэ цэнэтэй бүтээл хэвээр байгааг та бүхэн бэлхнээ мэдэж байгаа.

Үндсэн хуулийн дээд хүчин чадлыг сахин хамгаалах нэр хүндтэй үйлсэд Совд багшийн хүчин зүтгэсэн төрийн түшээ байсныг Лүндээжанцан багш маань түрүүн хэлсэн. Совд багш маань бас Үндсэн хуулийн эрх зүйн онолын үзэл баримтлалд үнэлж баршгүй хувь нэмрээ оруулсан эрдэмтэн хүн гэж хэлэхэд нэн бахархалтай байна. Г.Совд багшийн бүтээлүүдийн дотор Үндсэн хуулийн эрх зүйн талаар хамгийн анх Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны тайлбарыг 1993 онд бичиж гаргасан нь жинтэй бүтээл болсон юм. Энэ нь тухайн үедээ Үндсэн хуулийн талаар гарсан анхны ном байв.

Г.Совд багш "Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар" /2000 он/, "Үндсэн, хууль, хүний эрх" /1999 он/, Үндэсний аюулгүй байдал ба хүний эрх" зэрэг бүтээлүүд онол, практикийн нэн чухал ач холбогдолтойг цохон тэмдэглэх нь зүйтэй. Энд нэг зүйлийг онцлоход 1990 оны ардчилсан хувьсгалын эхэн үеүдэд "Үнэн", "Ардын эрх" сонинуудад нийт 7 нийтлэл, өгүүлэл хэвлүүлсний ихэнхи нь манай Улсын тухайн үед хамгийн их тулгамдаж байсан засаглалын хэлбэр, нийгмийн хөгжлийн чиг баримжаа, Үндсэн хуульт ёс, эрх зүйт төрийн талаархи үзэл бодол байсан нь цаг үеэ мэдэрсэн, ард түмнийхээ төлөө оюун ухаанаа чилээдэг жинхэнэ "Монгол эрдэмтэн" мөнийг олон хүн баталдаг юм байна.

Г.Совд багшийн бүтээлүүдийн дараагийн гол шинж нь нийгмийн хөгжлийн шинэ үе шатанд эрх зүйт төр, Үндсэн хуульт ёсыг дээдлэх гол арга хэрэгслийн нэг болж, Монголын төрийн түүхэнд анх удаа байгуулагдан ажиллаж байгаа, Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны онол практикийн зам мөрийг эхлүүлэн тавьсан явдал мөн. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хууль тогтоомжийг зөв ойлгож хэрэглэхэд туслалцаа үзүүлэх зорилгоор "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар" /1999 он х.х. 11 УБ хот/ бүтээл, "Үндсэн хуулийн зөвлөл ямар байх вэ" эрдэм шинжилгээний өгүүлэл /1989 он/ Совд багш бичсэн байна. Энэ бүхэн онолын

судлаачид, багш, оюутан төдийгүй төрийн түшээд, Үндсэн хуулийн соргог манаа Цэцийн гишүүдийн ширээний ном болсныг хүндэт багш таныхаа талаар элдэв зүйл цуглуулан, зүрх гарган өгүүлснийг өршөөн соёрхоорой. Таны эрдэм-оюуны их харгуйд түм түмэн шавиа дагуулан хөлийг нь дөрөөнд, гарыг нь ганзаганд хүргэсэн энэрэлт их ачий тань өмнө бишрэе. Сайн сайхан бүхнийг хүсье! Номын буян арвижих болтугай.

Анхаарал тавьсанд баярлалаа

Шихихутуг ХЗДС-ийн багш, хууль зүйн ухааны
магистр Б.Бат-Ерөөлт

# КАНАДАД ЗОЧИЛСОН АЯНЫ БОГЦООС

Дэлхийн банкны санхүүжилтээр Монгол Улсад "Шүүх, эрх зүйн шинэтгэл" төслийг хэрэгжүүлж байгаагийн дотор хуулийн дээд боловсролыг сайжруулах "дэд төсөл" орж байгаа юм. Энэ төслийн зорилго нь өдгөө хууль зүйн сургалт бүхий их, дээд сургууль, коллежийн сургалтын агуулгыг Үндсэн хуульт ёс, эрх зүйн шинэтгэлийн үзэл баримтлал, гадаадын олон орны хууль зүйн сургалтын жишгийг харгалзан, монголын эрх зүйн харилцааны онцлогт тулгуурлан шинэчлэн боловсруулж, түүний дагуу багш, оюутны мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөн төлөвшүүлэх асуудалд чиглэгдэж байгаа билээ.

Сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг боловсруулж, туршин хэрэгжүүлэх ажлыг Шихихутуг ХЗДС, Отгонтэнгэр Их сургууль, Цагдаагийн академид 2004 оны намраас эхлэн хийж байна. Энэ ажилд Канадын Куебек мужийн Монтералийн Их сургуулийн зөвлөх профессорууд оролцож байгаа юм.

Хичээлийн хөтөлбөр, сургалтын арга зүй, хэрэгжүүлэх орчныг судлахаар 2005.02.19-2005.03.03 хүртэл хугацаанд монголын дээрхи 3 сургуулийн



удирдлага, багш нараас бүрдсэн төлөөлөгчид Канадын Монтреалийн Их сургууль, Монтреалийн Бизнесийн Их сургууль, Торонто хотын Osgoode Hall их сургуульд зочилсон. Энэхүү айлчлалын сониноос та бүхэндээ хүргэж байна. Ярилцлагыг Шихихутуг сэтгүүлийн нарийн бичгийн дарга Н.Батболдтой Шихихутуг ХЗДС-ийн захирал, дэд профессор Д.Оюунцэцэг, багш Ж.Наранпүрэв нар хийв.

**Асуулт:** ***Өрнөдийн их, дээд сургуулиудад интернэтээр хичээлээ явуулж, мөн зарим нэгэн үйлчилгээг ч үзүүлдэг гэсэн. Канадад ийм интернэтийн үйлчилгээ оюутанд хэрхэн үр өгөөжтэй байдаг талаар асуултаа эхлэх үү?***

**Хариулт:** Канадад бүхэлдээ сургалттай холбоотой бүх мэдээлэлийг интернэтэд байрлуулсан байдаг. Бидний зочилж, танилцсан Монтреалийн болон Торонто хотын Osgoode Hall сургуулийн аль аль нь өөрийн гэсэн интернэт хаягтай, түүнд сургуульд хэрхэн элсэж болох, элссэн оюутнууд хичээлийг хэрхэн сонгох, сонгосон хичээл нь хэзээ, хаана орох, ямар багш хичээл заах, сургуульд ямар үйлчилгээ бий, түүнд хэрхэн хамрагдаж болох тухай мэдээлэлийг байршуулдаг. Мөн тухайн хичээлийн агуулга нь бүхэлдээ электрон хэлбэрээр интернэтийн тухайн хаягт байдаг.

**Асуулт:** ***Номын сангийн үйлчилгээний тухайд?***

**Хариулт:** Номын сан нь их тохиолог, мэдээлэлийн бүрэн автоматжуулсан системд шилжсэн. Ямарч ном, хэрэглэгдэхүүнийг электрон номын сангаас шүүж, эрж хайх боломжийг хангасан. Ер нь сургуулийн номын сангийнх нь 50%-иас илүү нь цахим байдлаар байршсан байдаг учраас ном хүрэлцэхгүй, хүлээгдэх, цөөн хоног ашиглах, гэмтэх зэрэг асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байдгаас гадна номын сангийн ачааллыг эрс багасгадаг. Үүнтэй холбоотойгоор номын сан нь олон тооны компьютертай бөгөөд түүгээр дамжуулан оюутнууд мэдээлэлээ олж авдаг. Монтреалийн "Бизнесийн Их сургууль"-д оюутнуудыг заавал notebook-тэй байхыг шаарддаг бөгөөд уг сургуулийн номын сан ч мөн электрон хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж оюутанд үйлчилдэг.

**Асуулт:** ***Оюутнууд хичээлдээ интернэт сүлжээ болон техник, хэрэгслийг хэр өргөн ашиглаж байна вэ?***

**Хариулт:** Их өргөнөөр ашигладаг. Жишээ нь, гадаад хэлний лаборатори нь иж бүрэн компьютер, бусад техник хэрэгслээр тоноглогдсон, багшийн өгсөн даалгавар болон бие даалт, хичээлийн сэдвүүдийг интернэтийн сүлжээг ашиглан компьютерээр гүйцэтгэдэг. Түүнчлэн интернэтийн дүрстэй суваг ашиглан нэг зэрэг хоёр улстай холбогдож телевизорээр хичээл явуулах боломжтой. Өөрөөр хэлбэл тухайн танхимд хоёр телевизортой бөгөөд аль аль нь өөр өөр улстай холбогдсон байна. Хичээл эхлэхэд хоёр өөр улсын оюутнууд, мөн өөр нэг сургуулийн багш интернэтийн сүлжээг ашиглан хичээл явуулдаг. Түүнчлэн оюутнууд сургуульд байх олшруулах машинаар чөлөөтэйгөөр үйлчлүүлдэг. Энэхүү олшруулах машинд тухайн оюутан үнэмлэхээ таниулаад, тодорхой төлбөр төлж ашигладаг. Мөн видеокамер, телевизор, хөгжим, поректорийг ашиглан хичээлээ явуулдаг, хичээл нь ч ийм хэлбэрээр явагдах хөтөлбөртэй байдаг.

**Асуулт:**. ***Оюутны холбоо нь оюутанд ямар үйлчилгээ, туслалцааг үзүүлдэг бол?***

**Хариулт:** Оюутны холбоо, сургууль хоорондоо сургууль дээрхи үйлчилгээний талаар ерөнхийдөө тохиролцож чадсан. Сургууль дээрхи бүх үйлчилгээ, тухайлбал, олшруулах, хувилах, цайны газар, ном, бичиг хэрэгслийн болон электрон барааны дэлгүүрийг бүхэлдээ оюутны холбоо хариуцан ажиллуулдаг. Энэхүү үйлчилгээний газарт нь оюутнууд өөрсдөө ажиллах бөгөөд олсон орлогыг оюутны холбоонд тушаадаг. Тиймээс ямар нэгэн уралдаан, тэмцээнд оюутны холбоо өөрийгөө санхүүжүүлэн оюутныг бэлтгэж оролцуулахаас гадна оюутанд хандсан бүхий л ажиллагааг энэ хөрөнгөөрөө санхүүжүүлж үйл ажиллагаагаа явуулдаг. Бүхэлдээ оюутны холбоо нь бүрэн бие даасан, санхүүгийн хувьд их хүчирхэг, оюутанд хандсан үйлчилгээг үзүүлдэг байгууллага гэж ойлгосон.

**Асуулт:** ***Санхүүгийн хувьд оюутанд сургуулиас ямар нэгэн туслалцаа үзүүлдэг юм болов уу?***

**Хариулт:** Юуны өмнө сургуульд элсэсэн болон элсэх гэж буй оюутнуудад зориулж санхүүгийн асуудлаар зөвлөгөө өгдөг. Жишээ нь, бидний танилцсан Osgoode Hall их сургууль нь оюутанд зориулсан бүх төрлийн санхүүгийн туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн албатай. Жилдээ хуулийн факултетийн оюутан нь 12000 канад долларын сургалтын төлбөр төлдөг бөгөөд нийт суралцах хугацааны төлбөрөө засгийн газраас 3 жилийн хугацаатайгаар хүүгүй зээлэх, эсвэл банкнаас зээл авч төлдөг. Хэрвээ банкнаас зээл авч суралцаж байгаа бол хүүг нь сургууль төлдөг бөгөөд тухайн зээлдэгч оюутныг төгссөний дараа сургуулиас төлсөн зээлийн хүүг эргэж төлөхийг шаардаггүй. Гэхдээ оюутан бүрт сургалтын зээл олгохгүй. Жил бүрийн 9-р сард зээллэг авах шаардлагатай оюутнууд сургуулийнхаа санхүүгийн албанд хандаж зээл хүссэн мэдүүлгээ гаргах бөгөөд мэдүүлгийг үндэслэн сургууль нь хэнд зээллэг олгохыг шийдвэрлэдэг журамтай.

**Асуулт** ***Оюутанд дотуур байр болон орон сууцны талаар ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?***

**Хариулт:** Монтреал болон Торонтогийн Osgoode Hall их сургуулийн аль аль нь нүсэр бүтэцтэй, цогц байгууламжтай. Энэ байгууламжид сургуулиас гадна оюутны бие даах төв болон үйлчилгээний маш олон байгууллага багтдаг. Оюутны•хотхонд зөвхөн оюутнууд амьдардаг бөгөөд зарим сууц нь хүүхэдтэй, эсвэл тахир дутуу оюутнуудад зориулагдсан байдаг. Мөн байрны зориулалт, багтаамжийг ихэд чухалчилдаг юм билээ. Тухайлбал, хойд Йоркийн эрүүл мэндийн зөвлөлийн гаргасан шийдвэрийн дагуу дотуур байранд 2-оос илүү хүүхэдтэй гэр бүл амьдрахыг хориглосон байдаг.

**Асуулт:** ***Оюутны эрүүл мэндийн үйлчилгээний тухайд?***

**Хариулт:** Сургуулийн хотхондоо эрүүл мэндийн төвтэй. Уг төв нь оюутнуудад эрүүл мэндийн бүх төрлийн үйлчилгээг үзүүлэхээс гадна янз бүрийн эрүүл мэндийн холбоотой ном, нийтлэл, зөвлөмж, дүрс бичлэгийн мэдээллээр хангадаг.

**Асуулт:** ***Гадаадын оюутнууд хэр олон суралцдаг бол? Гадаадын оюутанд зориулсан үйлчилгээ байх юм уу?***

**Хариулт**: Гадаадын 20 гаруй орноос оюутан солилцооны хөтөлбөр болон элсэлтийн шалгалтаар тэнцсэн оюутнууд суралцдаг. Гадаадын оюутнуудад зориулсан үйлчилгээг нилээд өргөн хэмжээгээр зохион байгуулдаг нь ажиглагдсан. Тухайлбал, тухайн улсын зан заншил, уламжлалтай холбоотой бүх төрлийн мэдээллээр хангах, хэлний бэрхшээлийг арилгах сургалт зохион байгуулах, хичээл болон сургалтын төлбөртэй холбоотой тусгайлсан сургалт, уулзалт зохион байгуулах, нийгмийн халамж болон даатгалын, мөн оюутны дотуур байраар хангах зэрэг маш олон үйлчилгээг үзүүлдэг. Дашрамд дурьдахад Монголоос Монтреалийн болон Osgoode Hall их сургуульд оюутан суралцдаггүй юм байна. Хэрвээ Монголоос оюутан суралцвал бид бүхий л талаар дэмжих болно гэж сургуулийн удирдлагууд хэлж байсан шүү.

**Асуулт:** ***Оюутны эрх нь зөрчигдсөн тохиолдолд сургуулиас болон бусад байгууллагаас ямар арга хэмжээ авдаг вэ?***

**Хариулт:** Юуны түрүүнд сургалт, хичээлтэй холбогдолтой асуудлыг оюутны холбоо, эсхүл оюутны эрхийг хамгаалах сайн дурын байгууллагаар дамжуулан асуудлыг шийдвэрлэдэг журамтай. Харин оюутан өөрөө ямар нэгэн хэрэг, зөрчилд холбогдсон тохиолдолд зуучлалын үйлчилгээг авч болно. Энэ зуучлалын үйлчилгээг зуучлалын төв байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд тухайн оюутанд тулгарч буй аливаа асуудлыг аль болох хурдан, тухайн оюутанд хүндрэл багатайгаар шийдвэрлэх арга замыг нь зааж өгч, холбож зуучилдаг, ийм арга замаар оюутны эрхийг хамгаалах үйлчилгээ үзүүлдэг ашгийн бус байгууллага байдаг.

**Асуулт:** ***Оюутанд ахуйн чиглэлээр өөр ямар нэгэн үйлчилгээг үзүүлэх үү?***

**Хариулт**: Оюутнуудад зориулж, ялангуяа тахир дутуу оюутанд зориулсан ахуйн үйлчилгээг үзүүлдэг. Жишээ нь, ахуйн үйлчилгээг хэрэглэх оюутан нь сургуульд хандаж өргөдөл гаргах бөгөөд сургууль өргөдөлтэй нь танилцаж ахуйн үйлчилгээ үзүүлэх эсэхийг шийддэг. Энэхүү ахуйн үйлчилгээнд тухайн оюутны эрүүл ахуйн нөхцлийг хангах, дасгал хийх, бие бялдраа хөгжүүлэх, хоол ундыг нь бэлтгэх, хөнгөн цэвэрлэгээ болон угаалга

хийх, өдөр тутмын амьдралын бусад үйлчилгээг үзүүлдэг бөгөөд энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй хийгддэг.

**Асуулт:** ***Оюутанд зориулсан тээврийн үйлчилгээний тухайд? Манайд бол оюутны автобусны хөнгөлөлтийн карт гэж байдаг.***

**Хариулт:** Торонтогийн тээврийн алба нь өөрийн хэд хэдэн автобусны үйлчилгээг сургуулийн бүсэд ажиллуулдаг. Оюутнууд энэхүү автобус болон метрогоор үйлчлүүлэх бөгөөд оюутан нэг бүрт автобус болон метроны маршрутын зураг, цагийн танилцуулгыг тараан өгдөг. Автобус болон метрогоор үйлчлүүлэхэд тодорхой хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлдэг.

**Асуулт:** ***Оюутны хотхонд хэв журмыг хэрхэн сахиулж, оюутны амгалан тайван байдлыг хэрхэн хангадаг бол?***

**Хариулт:** Оюутны хотхонд аюулгүйн төв ажиллах бөгөөд аюулгүй ажиллагааг хангах 24 цагийн ажиллагаатай. Уг алба нь тусгай бэлтгэгдсэн ажилтнуудаас бүрдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд цагдаа, гал, эмнэлгийн машиныг хотхоны хаалганаас угтан авч ослын газарт дагалдан хүргэх үүрэг хүлээдэг. Мөн хамгаалалтын алба ажиллах бөгөөд оюутны аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээдэг. Хамгаалалтын албаныхан автобусны буудал, машины зогсоол, орон сууцны ойролцоо байх бөгөөд хэрвээ хүсвэл оюутныг хүрэх газарт нь хүртэл дагаж явах, автобус, таксиг цуг хүлээх, машиныг нь асах хүртэл байлцаж хамгаалалтыг хэрэгжүүлдэг юм билээ.



*Өмгөөлөгч, хууль зүйн ухааны магистр М.Алтан-Өлзий*

**Мэргэшсэн чиглэл:**
**Гэрээний эрх зүй, үл хөдлөх эд хөрөнгө, зээл, эд хөрөнгийн болон барьцааны эрхийн хэрэг маргаан.**

**Энэ удаад өмгөөлөгч М.Алтан-Өлзийгийн хууль зүйн зөвлөгөөг нийтлэв.**

***Иргэн:*** Би өөрийн үр тарианы компаний эргэлтийн хөрөнгөд зориулж мөнгөний хэрэгцээ байсны дагуу зарын сонин дээрээс нэгэн Хадгаламж зээлийн хоршооны зарыг уншиж, нэгээс хоёр цагийн хугацаанд үл хөдлөх эд хөрөнгө барьцаалж түргэн шуурхай зээл олгоно гэсний дагуу утас, хаягийг нь авч 2003 оны 8-р сарын 10-нд зээл авах хүсэлтэй гаргасан бөгөөд тэр өдөртөө өөрийн өмчлөлийн 25 сая төгрөгний үнэ бүхий 4 өрөө орон сууцаа барьцаанд тавьж зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, тус хадгаламж зээлийн хоршооноос 3 сарын хугацаатай, сарын 5%-ийн хүүтэйгээр 10 сая төгрөгний зээл авсан юм. Тэр намраа ургац алдаж манай компани алдагдалтай ажилласны улмаас авсан зээлээ хугацаанд нь төлж чадахгүй болсон учир энэхүү нөхцөл байдлаа 2003 оны 11 сарын 1-нд тус хадгаламж зээлийн хоршоонд бичгээр мэдэгдэж, зээлийн гэрээний хугацаа дууссан өдрөөс хойш зээлийн хүүг зогсоож өгөхийг хүссэн юм.

Хадгаламж зээлийн хоршоо тэр дариудаа шүүхэд нэхэмжлэл гаргаж, надаас үндсэн зээл 10 сая, 3 сарын хүү 1,5 сая төгрөг, нийт 11.5 сая төгрөг нэхэмжилж шүүхэд хандсан бөгөөд харин шүүх хурала болон шүүхэд тус Хадгаламж зээлийн хоршоо нэхэмжлэлээ дэмжиж ирээгүй гэсэн үндэслэлээр шүүх нэхэмжлэлийг буцаасан юм. Тэгээд нэг хэсэг чимээгүй болсон бөгөөд би ч гайхаж байтал бүтэн 1 жилийн дараа буюу 2004 оны 11 сарын 10-нд шүүхэд дахин нэхэмжлэл гаргасан бөгөөд надаас үндсэн зээл 10 сая төгрөг, үндсэн хүү болон хугацаа хэтрүүлсний хүү гэж 7.5 сая төгрөг, нэмэгдүүлсэн

хүү гэж 1.5 сая төгрөг, нийт 19 сая төгрөг нэхэмжилж байна. Энэхүү нэхэмжлэл нь хэр үндэслэлтэй нэхэмжлэл вэ? Надад зөвлөгөө өгч туслалцаа үзүүлнэ үү!

***Хуульч: Нэгдүгээр хувилбар зөвлөгөө.*** Тус хадгаламж зээлийн хоршооноос гаргасан зар, таны зээл авахыг хүссэн хүсэлт, зээл авсан нөхцөл байдалд дүгнэлт хийж зөвлөхөд та юуны өмнө өөрийг чинь хоршооныхоо гишүүнээр элсүүлсэн эсэх талаар лавлагааг Үндэсний Татварын Ерөнхий Газрын бүртгэлийн албанаас авах хэрэгтэй. Учир нь.

*Нэгдүгээрт:* Хоршооны тухай хуулийн 48.3 дугаар зүйлд Хадгаламж Зээлийн үйл ажиллагаа явуулж байгаа Хоршоо нь зөвхөн гишүүндээ зээл олгож болно гэж заасан байдаг ба мөн хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу тухайн хоршооны дүрмийг зөвшөөрсөн, хоршоонд гишүүнээр элсэхийг хүссэн этгээд өргөдлөө Тэргүүлэгчдэд гаргах ба дүрэмд өөрөөр заагаагүй бол гишүүнээр элсүүлэх асуудлыг Бүх гишүүдийн хурлаар, дүрэмд заасан бол Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэж, хэрвээ гишүүнээр элсүүлэх шийдвэр гарсан бол таны гишүүнээр элсэхийг хүссэн өргөдөл, гишүүнээр элсүүлсэн тухай шийдвэрээ бүртгэх байгууллагад буюу нийслэл хотод бол Татварын Ерөнхий Газрын бүртгэлийн албанд бүртгүүлсэн байх ёстой.

*Хоёрдугаарт:* Хадгаламж зээлийн хоршооны бусад гишүүдийн болон хадгаламж эзэмшигч нарын эрх, ашиг сонирхолыг хамгаалах үүднээс тус хадгаламж зээлийн хоршооны Зээлийн хороо таны зээл хүссэн өргөдлийг шалгаж, зээл олгох эсэх асуудлыг мөн шийдвэрлэсэн байх ёстой.

Дээрх үйлдлүүдийг хийж гүйцэтгэхэд Бүх гишүүдийн хурал эсвэл Тэргүүлэгчдийн хурал, мөн Зээлийн хорооноос нэг, хоёр биш нэжгээд цаг хугацаа шаардах нь зүйн хэрэг. Хэрэв дээрх асуудлуудыг нэг, хоёр цагийн хооронд шийдвэрлэж болдог бол энэ нь дээр хэлсэнчлэн хоршооны бусад гишүүдийн болон хадгаламж эзэмшигч нарын эрх, ашиг сонирхолыг бүдүүлгээр зөрчсөн хэрэг болох билээ.

Хэрвээ таныг Хадгаламж зээлийн хоршооны гишүүнээр элсүүлсэн гэдэг нь албан ёсоор тогтоогдохгүй бол тус хадгаламж зээлийн хоршоог Хоршооны тухай хуулийн $48^3$ дугаар зүйлийн $48^3$. 1-д заасныг зөрчиж гишүүн биш этгээдтэй, Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.9-т заасны дагуу хуулийн этгээд үйл ажиллагааныхаа үндсэн зорилгыг зөрчиж хэлцэл хийсэн байна гэсэн үндэслэлээр Хоршоо болон таны хооронд байгуулсан хэлцлүүдийг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцох үндэслэл гарах болно. Энэ нь таны хувьд маш

ашигтай хувилбар байх болно.

***Хуульч: Хоёрдугаар хувилбар зөвлөгөө.*** Тус Хадгаламж зээлийн хоршоо таныг төлбөрийн чадваргүй болсон талаарх бичгийг хүлээж авсны дараа шүүхэд гаргасан нэхэмжлэлээ дэмжээгүй, шүүх хуралд хүрэлцэн ирээгүй учир шүүх нэхэмжлэлийг нь буцаах захирамж гаргасан байна гэж ойлгогдож байна. Үнэхээр тус Хадгаламж зээлийн хоршоо таны төлбөрийн чадваргүй болсныг мэдсээр байж, тэр тусмаа хугацаа алдалгүй шүүхэд гаргасан нэхэмжлэлээ дэмжиж зохих шийдвэр гаргуулаагүй байж бүтэн 10 сарын дараа дахин нэхэмжлэл гаргаж, нэхэмжлэлийн үнийн дүнг дурьдагдсан хугацаагаар таньтай байгуулсан гэрээний нөхцөлөөр нэмэгдүүлсэн нь хууль зүйн үндэслэл муутай байна гэж үзэхээр байна. Учир нь:

Иргэний хуулийн 223 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт ***Үүрэг гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд үүрэг гүйцэтгүүлэгч ямар нэгэн үйлдэл хийх ёстой байсан боловч түүнийг гүйцэтгээгүйгээс хугацаа хэтэрсэн бол үүрэг гүйцэтгүүлэгч хугацаа хэтрүүлсэн гэж үзнэ*** гэж заажээ. Мөн энэ хуулийн 224 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт ***Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгүүлэгч гэм буруутай эсэхээс үл хамааран мөнгөн төлбөрийн үүрэг ёсоор хүү, анз авах эрхээ алдана*** гэж заасан байна. Иргэний хуулийн дээрх үндэслэлүүдээр тус Хадгаламж зээлийн хоршооны шүүхэд гаргасан нэхэмжлэлээ дэмжиж шүүхэд болон шүүх хуралд ирээгүй эс үйлдлээс болж хугацаа хэтэрсэн байна гэж үзэх үндэслэл харагдаж байх тул шүүхэд анх нэхэмжлэл гаргасан өдрөөс хойшхи хугацаа хэтрүүлсэн хүү, нэмэгдүүлсэн хүү авах эрхээ алдсан байна гэж үзэх үндэслэл байна. Иймд танаас зөвхөн үндсэн зээл 10 сая төгрөг, гэрээний хугацааны дагуу 3 сарын хүү 1.5 сая төгрөг, мөн зээлийн гэрээнд заасан бол тооцогдсон хүүнд хамаарах нэмэгдүүлсэн хүү болох 0.3 сая төгрөгийг нэхэмжлэвэл илүү үндэслэлтэй байх болно.

Эцэст нь хэлэхэд дээрх нөхцөл байдлуудыг тогтооход зарим талаар мэргэжлийн нарийн төвөгтэй ажиллагаа шаардлагатай болох тул өмгөөлөгчийн туслалцаа авахыг танд зөвлөж байна.

**Жич:** Та бүхэн өмгөөлөгч М.Алтан-Олзийгээс хууль зүйн зөвлөгөө авах хүсэлтэй бол доорх утсаар хандана уу!

Утас: 99191041

1916 “Хууль зүйн лавлах”




Хуульч, судлаач та бүхний гар дээр 2005 он гарсаар доорхи ном, бүтээлүүд очиж байна.

1. АНУ-ын Тьюлейний Их Сургуулийн дэргэдэх харьцуулсан эрх зүйн төвийн захирал доктор, профессор К.Осаквегийн бичсэн "Харьцуулсан эрх зүй судлал" /ерөнхий ба тусгай анги-бүдүүвч/ бүтээл монгол хэлнээ орчуулагдан хэвлэгдлээ. Эл бүтээлийг Ж.Нямдорж, Л.Ундрах, И.Намхай нар орчуулж, орчуулгыг МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд захирал, доктор (Sc), профессор Н.Лүндэндорж, багш докторант М.Батсуурь, докторант Ч.Онөрбаяр нар хянан тохиолдуулжээ. Манай орны хууль зүйн сургалт, судалгаанд цаашид түлхүү хөгжүүлэх нэн чухал чиглэл бол харьцуулсан эрх зүй мөн бөгөөд харьцуулсан эрх зүйн-онол арга зүйн хөгжилд энэ бүтээл зохих хувь нэмэр оруулах болно.




2. М.Ариунаа "Төр - эрх зүйн онол" /УБ 2005/. Судлаач энэ бүтээлдээ төр-эрх зүйн онолын ойлголтуудыг зохих түвшинд судлаж, шинэлэг санаа, үзэл баримтлалуудыг дэвшүүлсэн онцлогтой юм. Эл ном оюутан, магистрант, судлаачдын оюун сэтгэлгээний хүрээг тэлэхэд чухал хувь нэмэр оруулах болно.

Бэлтгэсэн: Б. Бат-Ерөөлт